

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

1.1 “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Хан-Уул дүүргээс хариуцан хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2050” бодлогын баримт бичигтэй уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс дүүрэг хамтран хэрэгжүүлэх 5 бүлэг, 5 зорилт, 12 арга хэмжээний биелэлтийг нэгтгэн баталгаажуулж дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 06/977 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Биелэлтийн дундаж 59 хувьтай хэрэгжсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:

“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд:

Хан-Уул дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүд болон Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтнуудаас бүрдсэн тандалт, шуурхай хариу арга хэмжээний 3 баг 24 цагаар ажиллаж, дүүргийн хэмжээнд ковидын дуудлага, үзлэг бүрийг цаг алдалгүй 100% хүлээн авч ажиллалаа. Түргэвчилсэн болон ПСР шинжилгээний 22, дархлаажуулалтын 11 явуулын түр цэгийг ажиллуулсан.

Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 1-р тунд 392, 2-р тунд 1297, 3-р тунд 9481, 4-р тунд 10399, 5-р тунд 3 хүнийг хамруулсан. 2022 оны эхний 5 сарын өссөн дүнгээр 1-р тунд 178147 буюу 121,0%, 2-р тунд 177493 буюу 120,5%, 3-р тунд 68619 буюу 46,6% хүнийг хамруулсан байна. Үүнийг нийслэлийн хүн амын тоонд харьцуулбал: 1-р тунд 16.03%, 2-р тунд 16.0%, 3-р тунд 6.2% нь хамрагдсан байна.

Коронавируст халдварын 28038 тохиолдол батлагдаж, Туул тосгоны 80 ортой түр эмнэлэгт 230, Нэгдсэн эмнэлгийн 150 ортой “Ковид-21” тасагт 761, бусад эмнэлэгт 2371, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмчийн хяналтад 24676 иргэн эмчлүүлсэн. “Био салбар” эмнэлэгт ковидын 40 ортой түр эмнэлгийн бэлэн байдлыг хангаж, эмнэлгүүд 2 сарын нөөц бүрдүүлэн ажилласан.

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн эмнэлэг, эмийн сангийн судалгааг шинэчлэн гаргасан. Судалгаагаар улсын эмнэлэг-4, хувийн эмнэлэг-105, эмнэлгийн нийт орны тоо-1990, нийт их эмчийн тоо-440, эмийн сан-150 бүртгэгдсэн.

“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд:

Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг иргэд, олон нийтэд эмнэлгийн тусламж үйлчилгээг 24 цагаар тасралтгүй хүргэх зорилгоор “Телемедицин” үйлчилгээг 2022 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн нэвтрүүлж, 1500 гаруй иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. Эрүүл мэндийн яамны дуудлагын нэгдсэн “Цахим эмч 119” дугаартай холбох Callro үйлчилгээг Эрүүл мэндийн төвийн 341003, Нэгдсэн эмнэлгийн 70049255 дугаарын утсанд холбон нарийн мэргэшсэн эмч нар 24 цагаар, “Ковид-19”-ын тусламж үйлчилгээг 89250565, хүүхдийн тусламж үйлчилгээг 345903 утсаар хүргэж байна. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй хүн амын зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт үед нь илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны мэдээллийг бүрэн цахимжуулсан.



“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд: “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, өсвөр насны эрэгтэй хүүхдийн нөхөн үржихүй, хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвүүд цахим хуудсаар дамжуулан мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Тус дүүргийн ерөнхий боловсролын 15 сургуулийн 2500 гаруй хөвгүүдэд танхим болон цахимаар сургалт зохион байгуулсан. Өсвөр насны хөвгүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг хэрэгжүүлж, нийт 636 хөвгүүдэд утсаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. 2022 оны эхний ээлжийн цэрэг татлагаар 4478 цэргийн насны залуучууд 12 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдсанаас 790 буюу 18% нь өвчтэй илэрч, 8 төрлийн шинжилгээнд 350 залуучуудыг хамруулсан.

Гэр оронгүй, архины хамааралтай иргэдийг түр хоноглох үйлчилгээнд хамруулдаг “Хаган богда” төрийн бус байгууллагад байрлаж буй 30 иргэнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.



Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасагт “Эрэгтэйчүүдийн кабинет”-ын үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт кабинет байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг хүргүүлсэн. “Эрэгтэйчүүдийн кабинет”-ыг байгуулахтай холбогдуулан эмч, сувилагч нарыг чадавхжуулах сургалтад хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргасан.

Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй

үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх зорилтын хүрээнд:

Иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр дараах спортын арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

1. “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд спортын заал-7, фитнес-1, гадаа талбай-2, клуб-1, чийрэгжүүлэх танхим-4, урлаг заал-2, нийт 16 байршилд 5-74 насны 28418 иргэн;

2. “Улаанбаатар марафон-2022” цомыг 2022 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс 5 дугаар сарын 20-ны өдөр хүртэл 106 байгууллагаар аялуулж, цом аялах хугацаанд албан хаагчдын дунд спортын 189 уралдаан, тэмцээнд 6097 албан хаагч;

3. 2022 оны 5 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан “Улаанбаатар Марафон-2022” олон улсын гүйлт, “Авто машингүй өдөр”-ийн өдөрлөгт 1400 тамирчин, 150 гаруй төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагын 1614 ажилтан, албан хаагч, урлаг спорт, олон нийтийн арга хэмжээнд 1200 гаруй иргэн, нийт 4200 гаруй иргэн;

4. Хан-Уул дүүргийн аварга шалгаруулах “Гимнастрада” уралдаант үзлэгт 20 байгууллагын 400 гаруй албан хаагч, иргэд;

5. “Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох” арга хэмжээнд 33 байгууллагын 3830 ажилтан, албан хаагч, иргэд;

6. “Хамтдаа алхаад эрүүлжье” 10 удаагийн явган алхалтад 800 гаруй албан хаагч, иргэд;



Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн 20 сургуулийн багш нар 755 цахим хичээлийг боловсруулан <http://teacher.itpd.mn/>, <https://eschool.mn/>, Classroom зэрэг сайтуудад байршуулж, суралцагчдыг бие даан хичээллэх боломжийг бүрдүүлсэн. Цэцэрлэгүүд 1317 цахим үйл ажиллагаа, 449 ширхэг дасгал ажлын дэвтэр бэлтгэсэн.

“Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлэх хүрээнд:

“Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийн ур чадвар, заах арга зүйн тасралтгүй хөгжлийг дэмжсэн сургалтад 3539 багш хамрагдсан. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, удирдах ажилтны дунд “Оны шилдэг илтгэл” шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурлыг “Багшийн мэргэжлийн өсөлтөд-Ахмад багшийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдвээр 2 үе шаттай зохион байгуулж, нийт 1311 багш оролцсон.


“Хүмүүжлийн эерэг арга” сургагч багш бэлтгэх сургалтад 136 багш хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгдсэн. Нийслэлийн Боловсролын газар Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Мета сэтгэл судлалын хүрээлэн хамтран зохион байгуулсан “Ерөнхий боловсролын сургуулийн Сэтгэл зүйчдийн чадавхыг бэхжүүлэх нь” сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 11 сэтгэл зүйч, сургууль, цэцэрлэгийн 48 багш хамрагдсан.

Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангах хүрээнд:

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээ”-ний төвөөр 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 25 /Хүүхэд-24, насанд хүрэгч-1/ үйлчлүүлсэн байна.

Хүүхдийн тусламжийн утас-108, Түр хамгаалах байраар нийт 435 дуудлага мэдээлэл бүртгэгдэж, үүнээс Зөрчлийн тухай хуулиар 9 хэргийг шалган шийдвэрлэсэн.

Бие махбодын хүчирхийлэлд өртсөн-101, бэлгийн хүчирхийлэлд өртсөн-12, түр хамгаалах байраар үйлчлүүлсэн-25, нийт 137 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс 13 хүүхдэд хууль ёсны төлөөлөгч, 4 хүүхдэд өмгөөлөгч, 21 хүүхдэд боловсролын үйлчилгээ, 63 хүүхэд анхан шатны сэтгэл зүйн болон хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлсэн.



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд: Авлига, хүнд суртлыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга, орон нутгийн өмчит байгууллагын удирдлагууд нийт 31 албан тушаалтныг Авлигын эсрэг нийслэлийн зөвлөгөөнд оролцуулсан. Төрийн байгууллагын албан хаагчдыг авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалтад 4 албан хаагчийг хамруулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Шударга байдлын үнэлгээ 2022" судалгаанд байгууллагын 30 албан хаагч болон Засаг даргын Тамгын газартай хамтран ажилладаг 20 байгууллага, албан хаагчаас шинжээчийн судалгаа авч холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 4 төрлийн тв шторк, видео график, теле зохиомжийг дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод буланд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн.

Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам" 2020 оны 42 дугаар тогтоолоор өөрчилсөн "Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам"

Засгийн газрын 111 дүгээр тогтоолоор батлагдсан "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам", Монгол Улсын Их Хурлын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчилсэн найруулгын дагуу албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем <http://erp.ulaanbaatar.mn/> Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт 100 байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшил болгон ажиллаж байгаа бөгөөд уг программыг ашиглахад зөвлөгөө өгч мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажилласан.

Хүнс, худалдаа, үйлчилгээний чиглэлээр: Нөөцийн махны худалдааг 50 дэлгүүрээр 135,6 тонн мах, өргөтгөсөн худалдааг 2 дугаар улирлын амралтын өдрүүдэд давхардсан тоогоор 39 байршилд 323,5 тн махыг худалдаалах ажлыг зохион байгуулж, дүүрэг дэх Цагдаагийн газар,

Мэргэжлийн хяналтын хэлтэс, хороодтой хамтран махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийн гомдол, санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан.

Дүүргийн хэмжээнд нийт 459.1 тонн нөөцийн мах худалдан борлуулж, хүн амын махны хангамжийг нэмэгдүүлж ажилласан.



“Амралтын өдрийн худалдаа” арга хэмжээг 2 байршилд 4 удаа зохион байгуулж 16 үйлдвэрлэл эрхлэгчийг үнэ төлбөргүй асарт байршуулж, бараа бүтээгдэхүүнийг сурталчлан ажилласан.

Нийслэл, дүүргээс зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд зориулсан 5 удаагийн үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 37 үйлдвэрлэл эрхлэгчийг оролцуулж борлуулалтыг дэмжсэн.

Үйлдвэрлэл эрхлэгчдийг бараа бүтээгдэхүүнээ олон нийтэд сурталчлах, худалдан борлуулах ажлыг дэмжин нийтийн эзэмшлийн зам талбайд чөлөөтэй худалдаа эрхлэхийг Засаг даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн.



Малын үүлдэр угсааг сайжруулах ажлын хүрээнд үржүүлэг, технологийн ажлыг “Шилмэл сүрэг” ХХК, “Үржлийн шилмэл сүрэг” ХХК-иуд дүүрэгт хийж гүйцэтгэхээр НХХААГ-тай гэрээ байгуулсан. Хагас жилийн байдлаар 19 өрхийн 76 үхэрт зохиомол хээлтүүлгийн ажил үйлчилгээ авахаар захиалга өгсөн.

Хөдөө аж ахуйн салбарт үүсэж болох болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын батлагдсан төсөвт 25 тн өвс, 7 тн тэжээл худалдан авахаар суулгасан.

Малын тоо толгой албан татварын тухай хуулийн хүрээнд таван хошуу малд ногдох албан татварын хэмжээг 0-2000 төгрөгийн хязгаарт багтаан сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, малын төрөл тус бүрээр тогтоохоор заасантай холбогдуулан дүүргийн Татварын хэлтэстэй хамтран 12, 13, 14 дүгээр хорооны малчин, мал бүхий иргэдтэй уулзаж малын тоо толгойн албан татварын тухай хуулийг танилцуулан, дахин санал асуулга авах ажлыг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 178 малчин, мал бүхий иргэд хамрагдсан.



Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран мал аж ахуй болон газар тариалан бүхий 13, 14 дүгээр хорооны зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/71 дүгээр тушаал “Малын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар”, Малын А данс болон ургац хураалтын мэдээ тайлан гаргах аргачлалын талаар заавар, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан.



Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр: Дүүргийн хэмжээнд гэр хорооллын галлагаатай айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангах, угаарын хий мэдрэгчийг зөв ажиллуулж, агаарын хийн эрсдэлээс сэргийлэхэд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 10 хүртэлх хугацаанд сайжруулсан түлш борлуулах 53 цэг, гэр хорооллын 13 хорооны 17090 айл өрхөд “Угаарын хий хордлогоос” урьдчилан сэргийлэх, 3-15 кВт, 16-100кВт, 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухнуудын үйл ажиллагаанд хяналт тавьсан.

Сайжруулсан шахмал түлш борлуулдаг цэгээр өдөрт 230-260 тн түлш борлуулагдсан бөгөөд түлшний сайн карттай 14909 өрх, угаар мэдрэгч төхөөрөмжтэй 15036 өрх айл байгаагаас угаар мэдрэгч төхөөрөмж нь гэмтсэн 501 өрхөд шинээр авч 100 хувь хамрагдсан.

2022 оны 01 сарын 7, 8, 9-ны өдрүүдэд Монгол улсын шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 142 дугаар тушаал, МХЕГ-ын даргын 2022.01.06-ны өдрийн 01/04 дугаар “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд зөвшөөрөлгүй түүхий нүүрс түлж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21 хороодын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүрэг дэх Цагдаагийн газар, хороодын Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч хамтарсан 242 хүний бүрэлдэхүүнтэй баг 3400 айл өрх, 188 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан хяналт шалгалт хийсэн. Энэ ажлын үр дүнд өнжмөл түүхий нүүрс тэй 12, 13 дугаар хороодод байрлах Хэсэгчилсэн инженерийн хангамжийн тусгай зөвшөөрөлтэй уурын халаалтын зууханд 18 тн, тусгай зөвшөөрөлтэй “Түмэн шувуут” ХХК-ны уурын халаалтын зууханд 3 тн түүхий нүүрсийг хэрэглэж байсныг илрүүлэн газар дээр нь холбогдох арга хэмжээ авч ажилласан.

Зураг 2. “Түмэн шувуут” ХХК-д илэрсэн зөрчил




“Агаарын бохирдлын эх үүсвэр”-ийн Улсын тооллогоор: Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 29-ны А/930 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын тооллого, бүртгэл явуулж “ОРЧНЫ БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭР, ХАЯГДЛЫН ТООЛЛОГЫН МЭДЭЭЛЛИЙН САН”-д байршуулж ажилласан. Үүнд:

Дүүргийн хэмжээнд 2021 онд “ОРЧНЫ БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭР, ХАЯГДЛЫН ТООЛЛОГЫН МЭДЭЭЛЛИЙН САН”-д ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 17090 зуухыг тоолж бүртгэсэн.

Сууцны төрлөөр нь авч үзвэл 41% буюу 7059 нь гэрт, 56% буюу 9613 нь байшинд, 3% буюу 418 нь тохилог орон сууц ашиглаж байна.

Зураг 6. Сууцны төрлөөр авч үзвэл:



Зураг 7. Тооллогын дүн



17090 зуух хэрэглэгч айл өрхийн 6725 нь сайжруулсан, 10365 нь ердийн зуух ашиглаж байна.

Үр дүн:

1. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/376, дүүргийн Засаг даргын 2022 оны А/206 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласанаар дүүргийн хэмжээнд “Угаарын хийн эрсдэл”-д өртсөн айл өрх байхгүй байсан.
2. Монгол улсын шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн 142 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласнаар дүүргийн хэмжээнд түүхий нүүрс хэрэглэсэн айл өрх, аж ахуйн нэгж байгууллага байхгүй болсон.

“Агаарын бохирдлын эх үүсвэр”-ийн Улсын тооллогоор гэр хорооллын яндангийн тоог 92 өрхөөр бууруулсан ба 100кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын уурын зуухны тоог 9 аж ахуйн нэгжийн 10 зуухаар бууруулсан байна.

1.3 Улсын болон нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/133, А/613 дугаар захирамжуудаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 14,260.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Санхүүжилт		Хороо	Ажлын явц
		Төсөвт өртөг	2021 онд		
Гэрээ байгуулсан-1					
1	Цэцэрлэгийн барилга, 240 ор	3,220.0	300.0	4	Эйч Ар Ви Констракшн ХХК шалгарч гэрээ байгуулсан.
Тендер зарласан-1					
2	Сайжруулсан чулуун зам	900.0	900.0	8, 16	2022.03.24-нд тендер зарласан боловч аж ахуйн нэгж, байгууллагаас тендер ирээгүй тул 2022.05.11-нд 2 дахь удаа тендер зарласан.2022.06.13-нд нээлт хийнэ.
Тендер зарлах шатанд-2					

3	Сургуулийн барилга, 960 суудал	10,100.0	3,000.0	20	2022.03.03, 2022.04.07, 2022.05.24-нд 3 удаа тендер зарласан боловч аж ахуй нэгж материал ирүүлээгүй тендер хүчингүй болсон. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 06 дугаар сарын 08-ны 06/934 дугаар албан бичгээр газрын асуудал шийдвэрлэх, төсөвт өртгийг зах зээлийн бодит үнэлгээтэй уялдуулж өгөх талаар хүсэлт хүргүүлсэн.
4	Камержуулалтын ажил /ХУД/	186.0	186.0	-	Нийслэлийн цахим хөгжил, мэдээлэл технологийн газраас ажлын даалгавар хүссэн. Ажлын даалгавар батлагдах шатанд байна.
Нийт		14,620.0	4,600.0		

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх барилга байгууламжийн ажлын саналыг дэргэдэх хэлтэс, албадаас авч нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 06/161 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн тус саналуудыг Сангийн Яамны www.pimis.publicinvestment.gov.mn цахим системд холбогдох мэдээллийн хамт үнэлж оруулсан.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/285, 2022 оны А/68, А/138, дугаар захирамжуудаар нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1,180.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Санхүүжилт		Хороо	Ажлын явц
		Төсөвт өртөг	2020 онд		
Гэрээ байгуулсан-4					
1	Гүний худгуудад ухаалаг төхөөрөмж суурилуулах ажил	80.0	80.0	14	Баялаг говь ХХК шалгарч гэрээ байгуулсан.
2	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар	40.0	40.0	13	Шинэ эрин инженеринг ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд байна.
3	Нэгдсэн эмнэлгийн ариун цэврийн ерөөнд засвар, шинэчлэлт	139.4	139.4	8	Баялаг говь ХХК шалгарч гэрээ байгуулсан.
4	Нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн хөл бөмбөгийн талбайг тэгшлэх /ХУД/	57.9	57.9	4	БЭЗБ ХХК шалгарч гэрээ байгуулсан.
Гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн-1					
5	114 дүгээр сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	80.0	80.0	9	Голденхоул ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд байна.
6	Нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуульд сандал, ширээ /ХУД/	14.0	14.0	-	Эрдэнэтхөх хайрхан ХХК гэрээ байгуулах шатанд байна.
Үнэлгээ хийгдэж байгаа-1					
2	Нийслэлийн Ерөнхий боловсролын 18, 32, 118 дугаар сургуулиудад суурин	186.0	186.0	-	2022.05.09-нд тендер зарласан. 2022.06.09-нд нээлт хийсэн. 5 аж

	компьютер, дагалдах хэрэгсэл, 12, 28, 35, 73, 209 дүгээр цэцэрлэгүүдэд зөөврийн компьютер (ХУД)				ахуйн нэгж материалаа ирүүлсэн. Үнэлгээ хийгдэж байна.
Тендер зарлах шатанд-1					
11	Хан Хиллсээс Эрдэнийн төгөл хотхон руу хүрэх далангийн шат, явган хүний зам /ХУД 17 дугаар хороо/	70.0	70.0	17	2022.05.09-нд тендер зарласан. Аж ахуйн нэгж материалаа ирүүлээгүй.
	Нийт	1,180.6	1,180.6		

Гэр хорооллыг шинэ үзэл баримтлалын дагуу хөгжүүлж, иргэдэд боломжийн өртөгтэй орон сууцтай болох “Зөв шийдэлтэй” дахин төлөвлөлтийн талаар:

Хан-Уул дүүргийн 5, 6, 7, 8 дугаар хороодод нийт 10 хэсэг 175,3 га талбайд 9 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна. Үүнд:

- 8 дугаар хороо А-хэсэг 45.9 га "Монголиан инвестмент кропорешн" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 10%-тай байна.
- 7 дугаар хороо В- хэсэг 40.9 га "Ланкастер" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 10%-тай байна.
- 6 дугаар хороо Г-хэсэг 54.5 га Голден мартин ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 10%-тай байна.
- 5 дугаар хороо Д-хэсэг 34 га Андын зам констракшин ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 10%-тай байна.
- 8 дугаар хороо Б-хэсэг 46.1 га Ивээлт цамхаг констракшн ХХК 3 талт гэрээний байгуулах ажлын явц 30-40%-тай байна. Эхний ээлжийн газар чөлөөлөлтийн ажлын төлөвлөгөө гарсан.
- 5 дугаар хороо 41-р сургууль орчим 10.55 га Ама констракшн ХХК 3 талт гэрээний байгуулах ажлын явц 30-40%-тай байна. Эхний ээлжийн газар чөлөөлөлтийн ажлын төлөвлөгөө гарсан.
- 4 дүгээр хороо Е-хэсэг 39.9 га талбайд “Андын зам констракшн” ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 60%-тай байна.
- 8 дугаар хороо А хэсэг 11.5 га 134 нэгж талбарт “Ажнай цэгц” ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 80%-тай байна. 32 айлын орон сууцны барилгын суурийг тавьсан. 7 сард барилга угсралтын ажил хийгдэж эхэлнэ.
- 4 дүгээр хороо 34-р сургууль орчим 16.5 га 159 нэгж талбарт “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ 80%- тай 3 талт гэрээ байгуулсан. Газар чөлөөлөлтийн ажил түр зогссон төлөвлөсөн байршилд авто замын трасс давхацсан. Нийслэлийн авто замын хөгжлийн газартай зөвшилцөж байна.
- 8 дугаар хороо Б-хэсэг 15 га талбайд “Баярс ХХК” ажлыг Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/156 дугаар захирамжаар батламжийг цуцалсан. 2022 онд тус байршилд төслийн сонгон шалгаруулалт дахин зарлахаар баримт бичиг боловсруулагдаж байна.

“Нийслэлийн орон сууц бодлогын газар”-тай хамтран дүүргийн 5, 6, 7, 8 дугаар хорооны оршин суугч иргэдэд Яармагийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн явцын талаарх мэдээллийг бэлтгэн 4 удаагийн хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан.





Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцны дахин төлөвлөлт:

Дүүргийн АШХНЗОС-ны 34 барилга байгаагаас 29 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдаж байна. Одоогийн байдлаар 615 айлын 23 орон сууцыг буулган 1539 айлын 10 орон сууц ашиглалтад оруулж, 444 айлыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангасан. 2022 онд АШХНЗОС дахин барилгажуулах ажлын явц дараах байдалтай байна. Үүнд:

- ХУД 01-р багц "Фүжи девелопмент" ХХК Нэхмэлийн 11, 16 дугаар байр буулган барилгын суурийн ажил хийгдэж дууссан. 6 дугаар сард барилга угсралтын ажлын материал таталтын ажил хийгдэж байна.
- ХУД 02-р багц "Харү констракшн" ХХК Нэхмэлийн 12, 13, 17, 18 дугаар байр буулгалтын ажил хийгдсэн.
- ХУД 02-р багц "Эм Эм Жи Капитал" ХХК АШҮН 26, Нэхмэлийн 3-р байр, 36 айлын орон сууцыг буулган 253 айлын 1 орон сууц ашиглалтад оруулсан.
- ХУД 10-р багц "Шинэ гэр түншлэл" ХХК 36А, 36Б дугаар байрны дахин төлөвлөлтийн ажил зогссон шүүхийн маргаантай байна.
- ХУД 10-р багц "Шинэ гэр түншлэл" ХХК 36А, 36Б дугаар байрны дахин төлөвлөлтийн ажил зогссон шүүхийн маргаантай байна.
- ХУД 11-р багц Монтекарло гоулд" ХХК Нийслэлийн Засаг даргын А/80 дугаар захирамжаар батламжаа авсан. Сүрьеэ 20 дугаар байрны дахин төлөвлөлтийн ажлын 3 талд гэрээ байгуулах ажил 80%-тай буюу 31 айлтай гэрээ байгуулсан.
- 2022 онд Хан-Уул дүүргийн 3, 10, 12 дугаар хороон 5 ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 1,13 га нэгж талбарт төслийн сонгон шалгаруулалтыг нэг удаа зарласан. Үүнд: /ХУД-06-р багц 10 дугаар хорооны Нисэхийн 34, 35 дугаар байр 0.52 га, ХУД-08-р багц 12 дугаар хорооны Биокомбинатын 39 дүгээр байр 0.26 га, ХУД-09-р багц 3 дугаар хорооны Арьс ширний 31 дүгээр байр 0.2 га, ХУД-13-р багц 3 дугаар хорооны Талхны 20 дугаар байр 0.15 га/. Тус сонгон шалгаруулалтаар гүйцэтгэгч шалгараагүй.
- ХУД 11-р багц Монтекарло гоулд" ХХК Нийслэлийн Засаг даргын А/80 дугаар захирамжаар батламжаа авсан. Сүрьеэ 20 дугаар байрны дахин төлөвлөлтийн ажлын 3 талд гэрээ байгуулах ажил 80%-тай буюу 31 айлтай гэрээ байгуулсан.



“Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар”-тай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 12-ний өдөр Хан-Уул дүүргийн соёлын төвд Сүрьеэ 20 дугаар байрны 45 оршин суугч иргэдэд

дахин төлөвлөлтийн явцын талаарх мэдээлэл бэлтгэн хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан.



Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Дүүргийн ИТХ-ын 2021 оны 12 сарын 17-ний өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдаж, 2022 оны 03 дугаар сарын 10-ны 09 дүгээр тогтоолоор тодотгол хийгдэж орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр 50, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр 2 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хороо	Батлагдсан төсөвт өртөг /сая.төг/	2022 онд санхүүжих дүн /сая.төг/	Ажлын явцын тайлбар
1	2	3	4	5	6
ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ					
ХЭРЭГГИЖ ДУУССАН /2/					
1	Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	-	70.0	70.0	Хэрэгжиж дууссан. Гүйцэтгэгч "Нанопланет" ХХК
2	Хорооны байр худалдаж авах	-	1,250.0	1,250.0	Хэрэгжиж дууссан. Гүйцэтгэгч Оргил делта трейд ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН /17/					
3	Улсын бүртгэлийн хэлтсийн албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	-	70.0	70.0	Гүйцэтгэгчээр "Монтех дистрибьюшн" ХХК шалгарч гэрээ байгуулсан.
4	Цахилгааны хүчдэл сайжруулах	13, 14	909.0	909.0	Гүйцэтгэгчээр "Эрчим Өгий" ХХК шалгарч гэрээ байгуулсан.
5	Эрүүл мэндийн төвийн гадна зам талбайн тохижилтын ажлын зураг төсөв	-	15.0	15.0	Гүйцэтгэгчээр Нью Тover ХХК шалгарч гэрээ байгуулсан.
6	7, 8 дугаар байрны хойд талын даланг тохижуулах	2	555.0	555.0	Гүйцэтгэгчээр Таван од констракшн ХХК шалгарч гэрээ байгуулсан.
7	Нэгдсэн эмнэлгийн гадна барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам талбайн буулгалт	4	185.0	185.0	Гүйцэтгэгчээр "Юу зэт Эрдэнэ" ХХК шалгарч гэрээ байгуулсан.
8	Нийтийн зориулалттай орон сууцны фасад засвар	2, 10	1,300.0	1,300.0	Гүйцэтгэгчээр Чингисийн төгөл ХХК шалгарч гэрээ байгуулсан.

9	Зам цэвэрлэгээ, усалгааны машин худалдан авах	-	640.0	640.0	Гүйцэтгэгчээр Батсээр ХХК шалгарч гэрээ байгуулсан.
10	Хэсгийн ахлагч нарын болон төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд компьютер, принтер худалдан авах	-	250.0	250.0	Гүйцэтгэгчээр Ай ти зон ХХК шалгарч гэрээ байгуулсан.
11	Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн камержуулалт	10,12, 13,14, 21, 25	300.0	300.0	Гүйцэтгэгчээр Сонголт нар ХХК шалгарч гэрээ байгуулсан.
12	200 ортой цэцэрлэгийн барилга угсралт, дотор халаалт салхивч, цэвэр ус, цахилгаан холбоо, гадна зам талбайн тохижилтын ажил	4	667.1	667.1	Гүйцэтгэгчээр Тэргүүн констракшн ХХК шалгарч гэрээ байгуулсан.
13	14, 15 дугаар байрны ард талын тоглоомын талбайг шинэчлэх	1	250.0	250.0	Гүйцэтгэгчээр Прогресс интермедишн ХХК шалгарч гэрээ байгуулсан.
14	Гэрэлтүүлэг	4, 11,12, 14,16, 17, 18,19, 20	692.0	692.0	Гүйцэтгэгчээр РЗА ХХК шалгарч гэрээ байгуулсан.
15	Онцгой байдлын хэлтсийн албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	-	95.0	95.0	Гүйцэтгэгчээр МИНЖИТ ТБ ТРЕЙД ХХК шалгарч гэрээ байгуулсан.
16	Өглөөний гудамж байгуулах, орчны засвар, тохижилт хийх ажлын зураг төсөв	1	40.0	40.0	Гүйцэтгэгчээр Скайлайн дизайн ХХК шалгарч гэрээ байгуулсан.
17	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /дотор засвар, сантехник, лифт/	20	900.0	900.0	Гүйцэтгэгчээр Рокгранд ХХК шалгарч гэрээ байгуулсан.
18	Хөг тээврийн авто машин худалдан авах	-	4,800.0	4,800.0	Гүйцэтгэгчээр Хьюндай Моторс Монгол ХХК шалгарч гэрээ байгуулсан.
19	Хороолол дундах зам, талбай, явган хүний замын засвар, тохижилт	19, 20	250.0	250.0	Гүйцэтгэгчээр Заабар ХХК шалгарч гэрээ байгуулсан.
ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ШАТАНД /5/					
20	Хороолол дундах зам, талбай, явган хүний замын засвар, тохижилт	11, 15, 17	250.0	250.0	Гүйцэтгэгчээр Мөнхчандмань илч ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд байна.
21	Усан спорт сургалтын төвийн дээвэр, фасад засвар	16	525.0	525.0	Гүйцэтгэгчээр Гурванхажинга трейд ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд байна.
22	Замын Цагдаагийн хэлтсийн барилгын дулаалга, фасад засвар	20	220.0	220.0	Гүйцэтгэгчээр Талст өндөрлөг ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд байна.
23	Хороолол дундах зам, талбай, явган хүний замын засвар, тохижилт	1, 2, 3	250.0	250.0	Гүйцэтгэгчээр Зоос импекс ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд байна.

24	Ажилчны алдар талбайг засварлах зураг төсөв	-	50.0	50.0	Гүйцэтгэгчээр ДИ ДИ ЭИ ЖИ ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд байна.
ҮНЭЛГЭЭ ХИЙГДЭЖ БАЙГАА /5/					
25	"Эко зуслан"-ийн зураг төсөл, төсөв	-	100.0	100.0	2022.06.06-нд нээлт хийсэн. 1 аж ахуй нэгж материал ирүүлсэн үнэлгээ хийгдэж байна.
26	Цахилгааны хүүчдэл сайжруулах	14	821.0	821.0	2022.06.06-нд нээлт хийсэн. 3 аж ахуй нэгж материал ирүүлсэн үнэлгээ хийгдэж байна.
27	Гэрэлтүүлэг	-	500.0	500.0	2022.06.07-нд нээлт хийсэн. 4 аж ахуй нэгж материал ирүүлсэн үнэлгээ хийгдэж байна.
28	Гал унтраах ангийн автомашины гражийн өргөтгөл	-	270.0	270.0	2022.06.09-нд нээлт хийсэн. 1 аж ахуй нэгж материал ирүүлсэн үнэлгээ хийгдэж байна.
29	Чингисийн хүрээгийн авто замаас Эко Ахмадын сувилал хүртэл авто замын зураг, төсөв	8	55.0	55.0	2022.06.09-нд нээлт хийсэн. 4 аж ахуй нэгж материал ирүүлсэн үнэлгээ хийгдэж байна.
ТЕНДЕР ЗАРЛАСАН /2/					
30	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар	3, 10, 15	627.0	627.0	2022.06.27-нд нээлт хийнэ.
31	Хорооны байр худалдан авах	23	1,300.0	1,300.0	2022.06.07-нд нээлт хийнэ.
ТЕНДЕР ЗАРЛАХ ШАТАНД /6/					
32	Хорооны цогцолбор барилга	16	2,000.0	1,000.0	Скайтауэр констракшн ХХК Сангийн яамны 2022.04.27-ний №03/2640 тоот албан бичгээр гомдол гарсан тухай мэдэгдэл ирүүлсэн 2022.05.18-ны өдөр татгалзах хүргүүлсэн
33	Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын зураг төсөв	20	36.0	36.0	2022.04.08-нд нээлт хийсэн. Үнэлгээ хийгдэж байна. 1 аж ахуйн нэгж материалаа ирүүлсэн 2022.04.06-ны өдөр татгалзсан мэдэгдэл хүргүүлсэн.
34	Мод үржүүлгийн газрын зураг төсөв	-	50.0	50.0	2022.06.03-ны №237, 238 татгалзах мэдэгдэл хүргүүлсэн
35	15 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөв	-	50.0	50.0	2022.06.07 №247 тоот албан бичгээр татгалзах хүргүүлсэн
36	Хороодын албан хэрэгцээнд тавилга, эд хогшил худалдан авах	-	200.0	200.0	2022.03.18-нд нээлт хийсэн. Тендер хүчингүй болсон. Худалдан авах ажиллагааны шатанд

37	Хогийн камержуулалт	цэгийн	-	900.0	900.0	2022.04.13-нд тендер зарлаж, 2022.05.13-ны өдөр нээлт хийсэн. Гүйцэтгэгчээр Арш технологи ХХК шалгарч, гэрээ байгуулах шатанд Сангийн яаманд гомдол гарч, тендер хүчингүй болсон.
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ТҮР ЗОГСООСОН /9/						
38	Хатуу хучилттай авто зам тавих		9, 16	2,420.0	2,420.0	Худалдан авах ажиллагааг зогсоосон
39	Хорооны байр худалдан авах		20	1,200.0	1,200.0	Худалдан авах ажиллагааг зогсоосон
40	Өглөөний гудамж байгуулах, орчны засвар, тохижилт хийх		1	980.0	980.0	Худалдан авах ажиллагааг зогсоосон
41	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвийн байрыг буулгаж, шинээр барих		7	600.0	600.0	Худалдан авах ажиллагааг зогсоосон
42	Наадамчдын замаас Нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэл авто замын засвар, шинэчлэлт		4	1,700.0	750.0	Худалдан авах ажиллагааг зогсоосон
43	Наадамчдын авто замд явган хүний гарцын байгууламж барих		-	2,500.0	1,000.0	Худалдан авах ажиллагааг зогсоосон
44	Чингисийн өргөн чөлөөний явган хүний замын шинэчлэлт /дугуйн зам бүхий/		1, 2, 3, 19, 20	1,250.0	1,250.0	Худалдан авах ажиллагааг зогсоосон
45	Нийтийн эзэмшлийн талбайн үерийн далангийн засвар, шинэчлэлт		-	500.0	500.0	Худалдан авах ажиллагааг зогсоосон
46	Хүйтний улиралд иргэд амарч, зугаалах зориулалт бүхий өвлийн баазын зураг төсөв		-	150.0	150.0	Худалдан авах ажиллагааг зогсоосон
ТЕНДЕР ЗАРЛУУЛАХААР БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГАГДАЖ БАЙГАА /3/						
47	200 ортой цэцэрлэгийн барилга угсралт, дотор халаалт салхивч, цэвэр ус, цахилгаан холбоо, гадна зам талбайн тохижилтын ажил		15	681.6		Зураг төсөв хийгдэж байна.
48	200 ортой цэцэрлэгийн барилга угсралт, дотор халаалт салхивч, цэвэр ус, цахилгаан холбоо, гадна зам талбайн тохижилтын ажил		16	547.0	547.0	Зураг төсөв хийгдэж байна.
49	Хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга		24	2,750.0	1,856.4	Газрын гэрчилгээ гарах шатанд.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын явцын график:




Төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 30 төсөл, арга хэмжээний зураг төсөв боловсруулах шатанд хяналт тавьж ажилласан. Томоохон ажлуудаас дурдвал:

Өглөөний гудамж байгуулах ажил. Загвар зураг боловсруулагдаж байна.




Спорт цогцолборын барилга. Загвар зураг батлагдах шатанд.



14, 15 дугаар байрны ард талын тоглоомын талбайг шинэчлэх. Зураг төсөвт магадлал хийгдсэн.



Хороо, эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга /15, 21 дүгээр хороо/ Зураг төсөвт магадлал хийгдэж байна.



Хөрөнгө оруулалтын ажлуудад захиалагчийн албаны хяналт тавьж ажилласан. Томоохон ажлуудаас дурдвал:

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хороонд баригдаж буй 200 ортой цэцэрлэгийн барилга. Барилгын аяган суурийн ажил хийгдэж байна. Ажлын явц 10 хувьтай.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 21 дүгээр хороод баригдаж буй Хороо, эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга. Барилгын каркас цутгалтын ажил хийгдэж дууссан. Ажлын явц 30 хувьтай.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 21 дүгээр хороод баригдаж буй 200 ортой цэцэрлэгийн барилга. Гадна фасад будгийн ажил хийгдэж байна. Ажлын явц 70 хувьтай.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 2 дугаар хороо 7, 8 дугаар байрны хойд талын даланг тохижуулах ажил. Тус ажлын хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 950 м.кв явган хүний зам, 519.1 м.кв талбай бүхий авто зогсоол, 1186 м.кв далангийн эко хавтан, 60 урт метр далангийн хайс, 1 ширхэг пандус, 1 3х3 сагсан бөмбөгийн талбай, хүүхдийн тоглоомын талбай, мод, бут, сөөг тарих ажил бүрэн хийгдсэн. Ногоон байгууламж, гэрэлтүүлэг, засал чимэглэлийн ажил хийгдэж байна. Ажлын явц 80 хувьтай.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 2, 10 дугаар хорооны нийтийн зориулалттай орон сууцны фасад засварын ажил. Өнгө сэргээлт, парпет төмрийн ажил хийгдэж байна.



ДҮҮРГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ

№	Төсөл, арга хэмжээний нэршил	Хороо	Төсөвт өртөг /сая.төг/	Ажлын явц
1	Камержуулалт	4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 21	614.8	Гүйцэтгэгчээр Бодь электроникс ХХК шалгарч гэрээ байгуулсан.
2	Нийтийн эзэмшлийн зам талбайн засвар, шинэчлэлт, тохижилтын ажил	1, 2, 3, 11, 15, 17, 18, 19, 20	648.2	Багц 1, 2 аж ахуй нэгж материал ирүүлээгүй. Багц 3 гүйцэтгэгчээр Инвестмент трейд энд финанс корпорэйшн ХХК шалгарч гэрээ байгуулах шатанд байна.
3	Камержуулалт	1-11, 14-21	591.0	2022.05.30-нд нээлт хийсэн. Үнэлгээ хийж байна. 2 аж ахуй нэгж материал ирүүлсэн.
4	Орчны тохижилт	12	64.7	2022.05.13-нд нээлт хийсэн. 1 аж ахуйн нэгж материалаа ирүүлсэн Үнэлгээ хийгдэж байна. 2022.05.24-нд татгалзах мэдэгдэл хүргүүлсэн.
Нийт			1,918.7	

ОНХС-ын санал асуулга зохион байгуулсан байдал:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх төсөл арга хэмжээнд иргэд олон нийтээс цахимаар санал авах ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Санал асуулга явагдаж буй хугацаанд хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт шинээр аппликейшин ашиглалтад орсонтой холбоотойгоор Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын явцын мэдээллийг танилцуулж, “e-mongolia”, “Орон нутгийн хөгжлийн сан” аппликейшнээр санал өгөх заавар зөвлөмж өгч ажилласан.

Мөн иргэдийг идэвхтэй хамруулж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хороо тус бүрт 140 ширхэг тараах материал хүргүүлж, “Орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал асуулга” удирдамж батлан зохион байгуулагч, хэсгийн ахлагчдын дунд уралдаан зарласан. Хан-Уул дүүргийн хэмжээнд 18-аас дээш насны 89,836 иргэн хамрагдахаас 28,076 иргэн санал өгч, 30.3 хувьтай хамрагдсан байна.

ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:


Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, борооны усны зайлуулах шугам сүлжээний засвар, шинэчлэлтийн чиглэлээр:

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хороо, Чимэд-Осорын гудамжинд 350 урт метр авто замын ус зайлуулах шугамын өргөтгөл шинэчлэлт, 12 дугаар хороонд 180 урт метр Туул голын далан өндөрлөх, эргийн бэхэлгээ хийх ажлыг бүрэн гүйцэтгэсэн, 10 дугаар хороо 300 урт метр нисэхийн ус зайлуулах сувгийг засварлаж, 4 байршилд ус гаргуурыг шинэчлэх ажил суурийн арматурын шатанд хэрэгжиж байна.

Зураг. Үерийн хамгаалалтын барилга, байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлын явц



Дүүргийн 3 дугаар хороо, Ажилчны гудамжнаас Яармагийн гүүр хүртэл /Шунхлай ШТС/ авто замын ус зайлуулах шугамын барилга угсралт, 8, 21 дүгээр хороонд Жаргалантын амны 1,8 км урт үерийн хамгаалалтын байгууламжийн ажил 2022 оны 07 дугаар сараас эхлэхээр бэлтгэл хангагдаж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 7 дугаар хороо үерийн ус зайлуулах байгууламж барих, засварлах ажил ус зайлуулах суваг сууриллуулах, нисэхийн бүсэд /9, 10, 16 дугаар хороо/ үерийн ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төсөв магадлал хийгдэх шатанд хэрэгжиж байна.



Авто зам, замын байгууламжийн чиглэлээр: Улсын төсвийн хөрөнгөөр 16, 17 дугаар хороонд 2,8 км авто зам барих 2 төсөл арга хэмжээ, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 17, 18, 19, 20 дугаар хороонд 3,64 км хатуу хучилттай авто зам тавих ажил хуваарийн дагуу хэрэгжиж байна.

Зураг. Номин юнайтед худалдааны төвөөс Шаравын гудамж хүртэл авто замын ажил



Дүүргийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 5, 16, 21 дүгээр хороонд 3,1 хатуу хучилттай авто зам барих ажил гэрэлтүүлэг, явган хүний зам тавих шатанд хэрэгжиж байна.

Зураг. Авто зам дагуух явган зам, гэрэлтүүлгийн ажлын явц



Дүүргийн төсвийн хөрөнгөөр Хан-Уул зам, засвар арчлалт ОНӨААТҮГ 2022 онд шинээр 9, 8, 19, 20, 21 дүгээр хорооны 4 байршилд авто зам барих ажлыг хэрэгжүүлэхээс 21 дүгээр хорооны Буянт-Ухаа 2 хорооллын авто зам, газар шорооны шатанд хэрэгжиж байна.

Зураг. Буянт-Ухаа 2 хороололд авто зам тавих ажлын явц



Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ 1, 2, 3, 4, 11, 14, 15 дугаар хороодын эвдрэл ихтэй авто замын судалгааг гаргаж, 45 байршилд 450.43 м.кв асфальтбетон нөхөөсний ажлыг гүйцэтгэсэн.

Зураг. Авто замын нөхөөсний ажлын явц



Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Орчны тохижилт хийх" ажлын хүрээнд 10 дугаар хороо, 60/1 дүгээр байрны гадна 1100 м.кв талбай, 7, 8 дугаар байрны далангийн тохижилтын ажлын хүрээнд 519.1 м.кв талбайд шинээр авто зогсоол байгуулсан.


Зураг. Авто зогсоол байгуулах ажлын явц



Явган хүний зам, дугуйн замын засвар, шинэчлэлтийн чиглэлээр:

Улаанбаатар зам, засвар арчлалтын газар ОНӨААТҮГ дүүргийн 19 дүгээр хороо, Богд хааны ордон музейн зүүн талын хашааг буулгаж, газар чөлөөлсөн талбайд 300 урт метр явган хүний зам, дугуйн зам шинээр тавьж, орчныг тохижуулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Зайсангийн гүүрнээс Маршалын гүүр хүртэл Туул голын арын далан дагуух 2.5 метрийн өргөнтэй 2.4 км урт дугуйн замын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зураг. Явган хүний замын засварын ажлын явц



Нийслэлийн Хот тохижилтын газар, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, 61а байрны баруун талд явган зорчигч явах боломжгүй байсан нарийн хэсгийг өргөсгөн засварлаж, явган хүний зам тавьж, засварласан.


Зураг. 61а байрны баруун талын явган зам засварын ажил



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд орон сууц хороолол, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн эвдрэлтэй 27 байршилд явган хүний зам талбайг засварлах, шинэчлэх ажлын хүрээнд 2, 3, 12, 19, 21 дүгээр хороонд 3046,7 м.кв талбайд явган хүний зам шинээр тавьсан байна.

Дүүргийн Засаг даргын 2022 оны А/237 дугаар захирамжаар нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эвдрэлтэй явган хүний замыг засварлах, чанар, стандартын шаардлагыг хангах төсөв хөрөнгийг шийдвэрлэж, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэхээр бэлтгэл хангаж байна.

Зураг. Дүүргийн төсвөөр хэрэгжиж буй явган зам, засварын ажлын явц



Камержуулалтын чиглэлээр: Дүүргийн хэмжээнд 2022 онд дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто зам, хогийн цэгийг камержуулах 5 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 3 төсөл арга хэмжээ худалдан авах ажиллагааны шатанд, 2 төсөл арга хэмжээ гүйцэтгэх шатанд тус тус хэрэгжиж байна.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгөөр "Арш технологи" ХХК дүүргийн 1-11, 14-21 дүгээр хороодын 38 байршилд 117 ширхэг камер суурилуулах бөгөөд ажлын зураг төсөв батлагдаж, 38 ширхэг шон суурилуулж, 40,000 метр шилэн кабел татсан, ажил 70 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр хэрэгжих "Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж зохицуулах цэгүүдийн камержуулалт"-ын ажлын гүйцэтгэгчээр "Сонголт нар" ХХК шалгарсан бөгөөд тус ажлын хүрээнд 12, 13, 14, 16 дугаар хороодод 5 байршилд 10 ширхэг авто машины дугаар таних тусгай зориулалтын камер суурилуулна. 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар ажлын зураг төсөв боловсруулах шатанд хэрэгжиж байна. Дүүргийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Хогийн цэгийн камержуулалт"-ын ажлын хүрээнд 88 байршилд 182 ширхэг камер суурилуулах ажлын гүйцэтгэгчээр "Арш технологи" ХХК шалгарч, гэрээ байгуулахаар ажиллаж байна.

1.4 Үндэсний хөтөлбөрт заасан хэрэгжих зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж иргэд, төрийн албан хаагчдын жендэрийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

Жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Гэр бүл дэх тэгш байдал”, “Гэр бүлийн гишүүдийн эрх, үүрэг, оролцоо”, “Харилцан хүндэтгэе” сургалт, мэдээ, мэдээллийг www.khan-uul.mn, www.khanuul.child.gov.mn сайт, “Хан-Уул Эко дүүрэг”, “Хан-Уул хүүхэд” болон 21 хорооны албан ёсны цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчилсан.

Удирдлагын академиас зохион байгуулж буй “Ахисан түвшний Жендэрийн дүн шинжилгээ” сэдэвт төрийн албан хаагчдад зориулсан сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газар болон нутгийн захиргааны 43 байгууллага, төрийн өмчийн ерөнхий боловсролын 19 сургууль, 29 цэцэрлэгийн нийт 493 төрийн албан хаагч хамрагдаж, сертификат авсан.



Жендэрийн талаарх ойлголт мэдлэг олгох танхимын 2 удаагийн сургалтад 123 иргэн, бүлгийн зөвлөгөөнд 25 иргэн хамрагдсан. Төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтад 37 байгууллагын 252 албан хаагч хамрагдсан.

Хан-Уул дүүргийн Жендэрийн салбар хорооноос төрийн захиргааны болон үйлчилгээний 75 байгууллагад "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-д Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5, 11.6, 11.7 дахь хэсгийн зохицуулалтыг тусган баталж, хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг хүргүүлсэн бөгөөд 63 байгууллага дотоод журамд тусган, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэх, бууруулах арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр:

Бага насны хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх ажлын хүрээнд 2-18 насны 11325 хүүхдүүдийг амбулатори болон урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Хүүхдийн үзлэгийн эзлэх хувь өмнөх оноос 24%-иар нэмэгдсэн байна. Шүдний кабинетаар үйлчлүүлж, эмчилгээ хийлгэж байгаа 954 хүүхдэд видео болон муляж дээрх сургалтыг зохион байгуулж, амны хөндийн эрүүл ахуйн гарын авлага олгосон.

189-р цэцэрлэгийн 69 хүүхдийг үзлэгт хамруулснаас 24 хүүхэд өвчлөл илэрснийг хяналтад авч, 19 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн. Эрүүлжүүлэлтийн хувь 79,1%-тай. 41-р сургуулийн 11, 12-р ангийн 320 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, өвчлөл илэрсэн 32 хүүхдийг хяналтад авснаас 28 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн. Эрүүлжүүлэлтийн хувь 87,5%-тай. Салбар амбулатори болон "Good Neighbors" олон улсын байгууллага хамтран 1320 хүүхдэд нүд, шүд, чих хамар хоолойн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийсэн.

1.5 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

"Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-ний төсөлд тусгуулах саналыг боловсруулж дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний 06/890 дугаартай албан бичгээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт уламжилсан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар батлагдсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-өөс Хан-Уул дүүрэг хариуцан болон хамтран хэрэгжүүлж буй 5 бүлгийн 45 арга хэмжээний 2022 оны эхний хагас жилийн биелэлтийг холбогдох хэлтэс, албадаас авч,

нэгтгэн Засгийн 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр ажиллаж байна.

"Нийслэлийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөнөөс тус дүүрэг хамтран хэрэгжүүлэх 6 бүлэг, 15 зорилт, 16 зорилго, 60 арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтэд дээрх журмын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 58%, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдэн илтгэх хуудсыг биелэлтийн хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тайлагнасан.

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 онд дэвшүүлсэн зорилго, зорилтоос тус дүүрэг хамтран хэрэгжүүлэх 11 зорилго, 15 зорилтын эхний хагас жилийн биелэлтийг холбогдох хэлтэс албадаас хүлээн авч, нэгтгэх ажил хийгдэж байна.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:

Иргэн төвтэй үйлчилгээ зорилтын хүрээнд: Хан-Уул дүүргийн хороодын үйлчилгээг иргэдэд ойртуулах, шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор зарим хороодын хүн амын тоо, төлөвлөлт, газар нутгийн байршлыг судлах, хороодын хилийн цэс өөрчлөх эсэх талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/233 дугаар захирамжаар батлуулж, холбогдох судалгаа, мэдээллийг гарган ажлын хэсэгт танилцуулсан. Судалгааны дагуу 21 хороог 25 болгон шинэчлэн хуваах талаар санал, холбогдох судалгаа, тайланг гарган дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд албан бичгээр хүргүүлж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01 дугаар тогтоолоор хорооны хүн ам, суурьшлын тоог харгалзан шинэ хэсгийн хуваарилалтад оруулан Хан-Уул дүүрэг нь 25 хороо, 65 хэсэгтэй болж, 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор хороодын хилийн цэсийг баталсан.

Мэргэшсэн тогтвортой төрийн алба зорилтын хүрээнд: Дүүргийн Засаг даргын 2022 оны А/129 дүгээр захирамжаар Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, хэлтэс, албадын уялдаа холбоог сайжруулсан бөгөөд Засаг даргын Тамгын газрын даргын 2022.04.25-ны өдрийн 04/644 дугаар албан бичгээр шинэчилсэн бүтцийн дагуу нийт төрийн захиргааны 34 албан тушаалын харьцуулалт боловсруулж Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн.

Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 7 ажил 50 хувийн хэрэгжилттэй байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Удирдлагын академийн мэргэшүүлэх болон чиглүүлэх сургалтад 3 албан хаагчийг хамруулсан бөгөөд Нийслэлийн Хүний нөөцийн Хөгжлийн төвөөс зохион байгуулсан 10 төрлийн сургалтад 15, Төрийн албаны зөвлөлийн "7-4-10" сургалтад 10 удаа давхардсан тоогоор 100 албан хаагч, "А3" гэрчилгээ олгох сургалтад 11 албан хаагчийг тус тус хамруулж албан хаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Ажлын байран дээрх 7 төрлийн сургалтад 135 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулсан.

Байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувьтай байна.

Хан-Уул дүүргийн хэмжээнд төрийн албаны соёл, дэг журмыг чангатгах, ажлын цаг ашиглалтыг сайжруулж хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэхэд онцгой анхаарч, хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга болон хорооны Засаг дарга, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал, төрийн өмчийн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгож дүүргийн Засаг даргын 2022 оны А/245 дугаар захирамжийг батлуулж, Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04/646 дугаартай албан бичгээр 98 байгууллагад хүргүүлсэн.

Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/35 дугаар тушаалын хавсралтаар “Захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын дагаж мөрдөх харилцаа хандлагын нийтлэг журам”-ыг мөрдлөг болгон ажилласан.

Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 30 хувьтай байна. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэх талаар нийт албан хаагчдад анхааруулж, хяналт тавин ажилласан.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйтэй холбоотой өргөдөл ирүүлсэн 4 иргэнтэй холбогдож шууд шийдвэрлэх боломжтой асуудлыг тухай бүр шийдвэрлэж иргэнийг гомдолгүй болгосон бөгөөд 2 албан хаагчтай холбоотой өргөдлийг байгууллагын Ёс зүйн зөвлөлд гомдол гаргах хүсэлтэй байсан тул тухайн иргэнд Ёс зүйн зөвлөлд хандсан гомдлыг нотлох баримтын хамт ирүүлэх тухай мэдээлэл хүргэсэн боловч одоогоор ирүүлээгүй байна.

Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрт бэлтгэх зорилгоор “Оролцоо” төсөлд 18-34 насны 61 залуучуудыг бүртгэж баталгаажуулсан. Хан-Уул Эко дүүрэг пэйж хуудсанд хөдөлмөрийн зах зээлд нээлттэй зарлагдсан ажлын байрны жагсаалтыг 14 хоног тутам байршуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж байна.

2022 оны эхний хагас жилд 168 аж ахуйн нэгж байгууллагын 1556 сул ажлын байрыг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан/LMIS/-д бүртгэж, бүртгэлтэй 559 ажилгүй иргэнд ажлын байр санал болгосноор байнгын ажлын байранд 273, түр ажлын байранд 67, нийт 340 иргэнийг ажилд зуучилсан. Оюутан залуучуудын цагийн ажил хийх оюутнуудын судалгааг гарган нутаг дэвсгэрийн 5 аж ахуйн нэгж байгууллагуудаас сул чөлөөтэй цагийн ажлын байрны 100 захиалга хүлээн авсан. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн 15-34 насны 122 залуучуудын мэдээллийг LMIS программд бүртгэж, 10 залуу ажилд зуучлагдсан.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг талуудтай хамтран зохион байгуулах зорилтын хүрээнд: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 08 дугаар тогтоолоор сар бүрийн сүүлийн 7 хоногийн Ням гарагийг “Гэр бүлийн өдөр” болгон зарласан. Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх 2022 оны нэгдсэн удирдамж, хуваарь гаргаж, дүүргүүдэд тухайн сарын онцлогт тохируулсан үйл ажиллагаа зохион байгуулах чиглэл ирүүлсэн.

Чиглэлийн дагуу “Гэр бүл дэх эрх тэгш байдал, тэгш боломж, тэгш оролцоо” сэдвийн хүрээнд “Хүннү молл” худалдааны төвд 2022 оны 3 дугаар сарын 27-ны өдөр гэр бүлийн өдрийг зохион байгуулсан.



Үйл ажиллагаанд оролцогчдод зориулан хүүхдийн хөгжил, танин мэдэхүй, сэтгэл зүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцож, үйл ажиллагаагаа сурталчилсан.

Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу шилдэг гэр бүл шалгаруулах ажлыг зохион байгуулж, нийт 15 гэр бүлийн материал хүлээн авч, шилдэг гэр бүлийн материалыг хүргүүлсэн. Нийслэлийн “Оюунлаг гэр бүл”-ээр тус дүүргийн 2

дугаар хорооны иргэн Н.Нямдоржийн гэр бүл, “Авьяаслаг гэр бүл”-ээр 3 дугаар хорооны иргэн Д.Шинэцогийн гэр бүл тус тус шалгарсан.

БЗДХ/ДОХ, халдварт гепатит, бусад халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, эмчилгээнд хамруулах зорилтын хүрээнд: Хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх хүрээнд “Сүрьеэгүй ирээдүй”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Эрүүл идэвхтэй амьдрал” “Харшлаас сэргийлцгээе”, “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” “Хамтдаа алхаад эрүүлжэе” зэрэг эрүүл мэндийн аяныг зохион байгуулсан. Бэлгийн замаар дамжих халдварыг илрүүлэх 2279 үзлэгээс урьдчилан сэргийлэх үзлэг 1987 байгаа нь нийт үзлэгийн 87,2%-ийг эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна. 0-5, 6-17 насны иргэд өрхийн эрүүл мэндийн төвд, 18-30, 31-45, 46-60, 61-ээс дээш насны иргэд Эрүүл мэндийн төв, “Гэгээн ар үр” эмнэлэг, “Clinico health care” клиник, “ЭНЭҮТ”, “Санмедикал” эмнэлэг, Нэгдсэн эмнэлгүүдэд эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ, оношилгоонд хамрагдаж байна. 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 0-5 насны 3478, 6-17 насны 2177, 18-30 насны 547, 31-45 насны 961, 46-60 насны 1140, 61-ээс дээш насны 1249, нийт 9552 иргэн эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ оношилгоонд хамрагдаад байна.



Сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд томуу, томуу төст өвчин, менингитийн дэгдэлт ихэссэнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын 2022 оны А/152 дугаар захирамжаар бага насны хүүхдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах талаар эцэг, эх, асран хамгаалагч нарт мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор 30,000 ширхэг гарын авлагыг хэвлүүлж, төрийн болон төрийн бус өмчийн 48 сургуулийн 1-2 дугаар ангийн 12,000 сурагч, 123 цэцэрлэгийн 18,000 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нарт гарын авлагыг хүргэсэн.



Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулах зорилтын хүрээнд: Хотын соёл аяны хүрээнд хотын соёлыг сурталчлан таниулах 5 контент, 12 постерыг шинээр бэлтгэн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хороодын албан ёсны цахим сайтад байршуулсан. Нийслэл хотоос баримталж буй бодлогыг иргэд, олон нийтэд сурталчилж, соён гэгээрүүлэх ажлыг бүх нийтийн соёл болгох зорилгоор зохион байгуулж буй “Хотын соёл”-ын аяны хүрээнд хотын соёлыг төлөвшүүлж, түгээн дэлгэрүүлэх ажлыг төрийн болон төрийн бус өмчийн 48 сургууль, 124 цэцэрлэг “Хотын соёл” төлөвлөгөө гарган ажиллаж, 3 чиглэлээр 14 ажлыг зохион байгуулан давхардсан тоогоор 74152 багш, сурагчдыг хамруулсан.



Ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд: Хан-Уул дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэгш хамран суралцах орчин бүрдсэн хичээлийн байртай сургууль 17, тусгай тоноглол бүхий ариун цэврийн өрөөтэй 10 сургууль байна. Япон улсын "Олон улсын хамтын ажиллагааны байгууллага", БШУЯ-тай хамтран хэрэгжүүлж буй "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдэд үзүүлэх, эрүүл мэнд,

боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах нь” төслийн хүрээнд хөгжлийн бэршээлтэй хүүхдийн сурах орчин, үйл ажиллагааг дэмжсэн 280 ширхэг гарын авлага, зөвлөмж, видео хичээлийг ерөнхий боловсролын 48 сургуульд хүргүүлсэн.

Хөгжлийн бэршээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах үүрэг бүхий “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/125 дугаар захирамжаар байгуулсан. Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 48 сургуулийн “Дэмжлэгийн баг”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах орчин бүрдүүлэн ажиллах” заалтын хэрэгжилтээр 38 сургууль буюу 79 хувь сургуулийн гадна хаалганы орчинд хөгжлийн бэршээлтэй, тэргэнцэртэй иргэд зорчих налуу замтай болсон байна.

Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах, дэмжлэгийн багийг чадавхжуулах 4 удаагийн сургалтад 576 багш хамрагдаж, цэцэрлэгт 54, сургуульд 422 хөгжлийн бэршээлтэй хүүхэд суралцаж байна.

ТОХИЖИЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Дүүргийн Засаг даргын 2022 оны А/74 дүгээр захирамжаар тохижилт, засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд 1, 2, 12, 13, 16, 20 дугаар хорооны 7 байршилд цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, тоглоомын талбай шинээр байгуулах болон хуучин тоглоомын талбайг сэргээн засварлах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 12 дугаар хороо, тоглоомын талбай байгуулах ажил гүйцэтгэх шатанд, 2 төсөл арга хэмжээ зураг төсөв магадлал хийгдэх шатанд, 4 төсөл арга хэмжээ зураг төсөв боловсруулах шатанд тус тус хэрэгжиж байна.

Зураг. Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын хэрэгжүүлж буй тохижилтын ажлын явц



Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 21 дүгээр хорооны Буянт-Ухаа 2 хороололд иргэд олон нийтэд зориулсан тохижилт, ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэгийн ажил хэрэгжиж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 1 дүгээр хороо, 9, 25 дугаар байрны гадна хүүхдийн тоглоомын талбай байгуулах, хуучин хөл бөмбөгийн талбайг сэргээн засварлах ажил он дамжин хэрэгжиж ашиглалтад орсон. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 1 дүгээр хороо, 9, 25 дугаар байрны гадна хүүхдийн тоглоомын талбай байгуулах, хуучин хөл бөмбөгийн талбайг сэргээн засварлах ажил он дамжин хэрэгжиж ашиглалтад орсон.

Зураг. Тохижилтын ажлын явц



"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяныг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны 800 өрхийн хашаанд 7643 ширхэг мод, бут, сөөг тарьж, өрх тус бүрд мод тарих хялбаршуулсан аргачлал бүхий гарын авлага, гэрчилгээг олгосон.

Зураг. "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяны хүрээнд гэр хорооллын өрхүүдэд мод тарих ажлын явц:



Төрийн болон хувийн хэвшлийн оролцоотойгоор дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 35 га талбайд 15 байгууламж бүхий "Олон улсын соёлын цэцэрлэгт хүрээлэн" байгуулах төсөл хэрэгжиж байна.

Зураг. Олон улсын соёлын цэцэрлэгт хүрээлэн



Гэрэлтүүлгийн чиглэлээр:

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 4, 11, 12, 14, 16, 17, 18, 20 дугаар хороодод шинээр хийх 220 ширхэг гэрэлтүүлгийн гүйцэтгэгчээр "РЗА" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын зураг төсөв батлагдсан. Гэрэлтүүлгийн шон, суурийн дотор үйлдвэрлэгдэж байна. Дүүргийн 5, 16, 21 дугаар хороонд шинээр тавигдсан 3.1 км авто зам дагуу 96 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах ажил хийгдэж байна.

Орон сууцны хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээг сайжруулж, тогтмол хяналт тавьж ажиллаж байна. 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 900 метр кабель шугам, 439 ширхэг 50 вт лед гэрэл, 195 ширхэг лед 70 вт гэрэл, 95 ширхэг 90 вт лед гэрэл, 323 ширхэг 50 вт прожуктор, 94 ширхэг пускатель, 63 ширхэг 50 вт лед трансформатор, 58 ширхэг 70 вт лед трансформатор, 166 ширхэг гал хамгаалагч, 71 ширхэг цахилгааны самбарын хайрцаг засвар, 16 ширхэг гэрэлтүүлгийн шон солих, засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Зураг. Гэрэлтүүлгийн засварын ажлын явц:



Баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд дүүргийн 15 дугаар хороо Махатма Ганди, Цэнгэлдэхийн тойрог орчмын 68 ширхэг гэрэлтүүлгийн шонг будаж, өнгө үзэмжийг сайжруулсан.

Зураг. Гэрэлтүүлгийн шонг будах ажлын явц



Үйлдвэрийн гудамжинд 88 ширхэг натри бүдэг гэрэлтүүлэгчийг лед 100 вт гэрлээр сольж замын зорчих хэсгийн тусгалыг сайжруулсан. Дүүргийн 11 дүгээр хороо Соёмбот уулын гэрэлтүүлгийг асалтын горимд шилжүүлэн ажиллаж байна.

Зураг. Үйлдвэрийн гудамж, гэрэлтүүлгийн засварын ажлын явц



Орон сууцны фасад, дээвэр засвар:

Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 1 дүгээр хороо, 25 дугаар байр, 13 дугаар хороо, 5 дугаар байрны дээврийн засварын ажлыг ашиглалтад хүлээж авсан. Дүүргийн 2 дугаар хорооны 8а байр, 30 дугаар байр, 10 дугаар хорооны 2, 61 дүгээр байрнуудын фасад засвар, дулаалгын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 3 дугаар хороо 1а байр, 10 дугаар хороо 60, 63, 61/1, 61/2, 67 дугаар байр, 15 дугаар хороо Жаргалан 60 дугаар байр нийт 7 байрны дээвэр засварын ажлын тендерийг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зарласан. 2022 оны 06 дугаар сарын 27-нд нээлт хийнэ. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 2 дугаар байрны дээврийн засвар ажил гүйцэтгэх шатанд хэрэгжиж байна.

Зураг. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадын засварын ажлын явц:



Зураг. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засварын ажлын явц:



ХОГ ХАЯГДЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжих “Эко-Эрүүл дүүрэг” хөтөлбөрийн хүрээнд “Хоггүй Хан-Уул 2022” ээлжит бүх нийтийн их цэвэрлэгээг 1 дүгээр сараас 6 дугаар сарыг хүртэл сар бүр зохион байгуулж ажилласан.

Их цэвэрлэгээнд Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх 22 хэлтэс, албадын 500 гаруй албан хаагчид, 21 хороо, өрхийн Эрүүл мэндийн төвүүд, төрийн өмчийн ерөнхий боловсролын 18 сургууль, 29 цэцэрлэг, 286 СӨХ, 1136 аж ахуйн нэгж байгууллагуудын 5102 ажилтан, албан хаагч, иргэд хамтран их цэвэрлэгээ хийж, 3,357,250м2 талбайгаас 1,139,3 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Зураг 9. Хан-Уул дүүрэг, “Хоггүй Хан-Уул 2022” аяны хүрээнд зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээний явц



Дүүрэгт худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллүүдэд хотын стандартын талаар мэдээлэл өгөх сургалтын үеэр хог хаягдлыг ангилан ялгах, хүнсний хаягдлыг бордоо болгон ашиглах тухай сургалтыг зохион байгуулж, 200 гаруй аж ахуй нэгж байгууллага хамрагдсан.

1.6 Дэд хөтөлбөрт тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

“Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/51 дугаар захирамжаар батлагдсан 9 дэд хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар “Эко ногоон дүүрэг” дэд хөтөлбөрийн хүрээнд 1 төсөл арга хэмжээ, “Хорооны хөгжил” дэд хөтөлбөрийн хүрээнд 1 төсөл арга хэмжээ, “Зөв хүүхэд-Зөв ирээдүй” дэд хөтөлбөрийн хүрээнд 10 төсөл арга хэмжээ, “Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөрийн хүрээнд 3 төсөл арга хэмжээ, “Багш” дэд хөтөлбөрийн хүрээнд 1 төсөл арга хэмжээ, “Ахмадаа дээдэлье” дэд хөтөлбөрийн хүрээнд 2 төсөл арга хэмжээ нийт 9 дэд хөтөлбөрийн 18 зорилт арга хэмжээ 34.5 хувьтай хэрэгжсэн.

№	Дэд хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв /сая, төгрөг/	Зарцуулсан болон зарцуулах төсөв	Үлдэгдэл	Хувь
1	“Эко ногоон дүүрэг”	200.0	15,500,000	184,500,000	7.5%

2	“Хоггүй Хан-Уул”	150.0	-	150,000,000	-
3	“Хорооны хөгжил”	130.0	17,500,000	112,500,000	13%
4	“Архигүй орчин”	50.0	10,000,000	50,000,000	
5	“Эрүүл дүүрэг”	150.0	-	150,000,000	-
6	“Зөв хүүхэд-Зөв ирээдүй”	200.0	153,891,000	46,109,000	77%
7	“Залуучуудын хөгжил”	55.0	23,889,000	31,111,000	44%
8	“Багш” дэд хөтөлбөр	115.0	14,000,000	101,000,000	12%
9	“Ахмадаа дээдэлъе” хөтөлбөр	150.0	89,244,000	70,756,000	47.5%

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлд ирүүлсэн Нэгдсэн эмнэлэг, Биеийн тамир, спортын хороо, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн төсөл, арга хэмжээний мэдээллийг нэгтгэн, Засаг даргын зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуралд танилцуулсан.

Эрүүл мэндийн төвийн “Б” корпусын 500 м2 талбайд 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар их засварыг хийж, 865.0 сая төгрөгийн үнэ бүхий 11 нэр төрлийн тоног төхөөрөмжийг суурилуулж, “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулсан.



Эрүүл мэндийн төвд 3 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн эхо аппарат 1 ширхэг, 4,2 сая төгрөгийн сүрьеэгийн Gene Expert аппарат 1 ширхгийг тус тус нийлүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн хүлээн авах танхимыг Япон улсын “Өвсний үндэс” төслийн 550.0 сая төгрөгийн санхүүжилтээр тохижуулсан. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн төвийн Яармаг салбарын амбулаторийн үйлчилгээг Нэгдсэн эмнэлгийн амбулаторит шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 115.0 сая төгрөгийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/52 дугаар захирамжийн 4 дүгээр хавсралтаар батлуулсан. “Багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн 2 удаагийн хурлыг зохион байгуулж, 15 дугаар сургуулийн “Багш хөгжлийн төв” төслийг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Засаг даргын зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар шийдвэрийн дагуу тус төслийг хэрэгжүүлж, 14.0 сая төгрөгийг зарцуулсан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Зөв хүүхэд-Зөв ирээдүй” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 200.0 сая төгрөгийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/52 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлуулсан. “Зөв хүүхэд-Зөв ирээдүй” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлд 22 төсөл ирснээс 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 153,891,000 төгрөгийг зарцуулсан.

1. 75 дугаар сургууль “Хүүхдийн төлөө хамтдаа” төсөл -18,765,000 төгрөг
2. 41 дүгээр цэцэрлэг “Эко бүлэг” “Бүлгийн тоглоом” төсөл-6,179,000 төгрөг
3. 189 дүгээр цэцэрлэг “Хүүхдийн эргэн тойронд эрүүл, аюулгүй, эрсдэлгүй орчныг бүрдүүлцгээе” төсөл-12,600,000 төгрөг
4. 65 дугаар цэцэрлэг “Арван есийн жаргалтай багачууд” төсөл-8,000,000 төгрөг

5. 290 дүгээр цэцэрлэг “Цэцэрлэгийн гал тогооны сав суулга” төсөл-3,314,600 төгрөг
6. 35 дугаар цэцэрлэг “Эрүүл орчныг бүрдүүлцгээ” цэцэрлэгийн анги бүлгүүдийг хивсэнцрээр тохижуулах төсөл-8,700,000 төгрөг
7. 218 дугаар цэцэрлэг “Эко цэцэрлэг, эрүүл цэцэрлэг, цахим цэцэрлэг” төсөл-8,700,000 төгрөг
8. 32 дугаар сургууль “Цайны газрын тоног төхөөрөмж” төсөл-19,282,400
9. 60 дугаар сургууль “Уран хэлхээ” бүжгийн чуулгын сурагчдад дэмжлэг үзүүлэх төсөл-1,200,000 төгрөг
10. “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан зорилтот өрхийн хүүхдүүдэд бэлэг олгох төсөл-67,150,000 төгрөг.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 55.0 сая төгрөгийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/52 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтаар батлуулсан. “Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлд 6 төсөл ирснээс 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 23,889,000 төгрөгийг зарцуулсан.

1. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх сургалт, хэлэлцүүлэг” төсөл-4,945,000 төгрөг
2. “Зуны дифлимпын XXIV наадамд чөлөөт бөхийн төрөлд Монгол Улсыг төлөөлөн оролцох Д.Чинзоригт дэмжлэг үзүүлэх” төсөл-4,000,000 төгрөг
3. “Ээж бол ертөнц” төсөл-14,944,000 төгрөг

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ахмадаа дээдэлье” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 150.0 сая төгрөгийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/52 дугаар захирамжийн 5 дугаар хавсралтаар батлуулсан. “Ахмадаа дээдэлье” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлд 5 төсөл ирснээс 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 79,244,000 төгрөгийг зарцуулсан.

1. “Сар шинийн баярыг угтан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх” төсөл -64,944,000 төгрөг
2. “Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний танилцуулга” төсөл-14,300,000 төгрөг.



1.7 Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилт, 152 арга хэмжээний 2022 оны хагас жилийн биелэлтийг Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, албадаас авч, нэгтгэн боловсруулж байна.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:

“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээг цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд:

Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/-ийг нэвтрүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй, чанартай хүргэх зорилгоор 41 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас нийт 136226 иргэнд 55,289.406 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: “Эхийн алдар” одонтой эхийн тэтгэмж 10535 иргэнд 1,281,500,000, насны хишиг 9491 иргэнд 782,280,000, 0-3 хүртлэх насны хүүхдээ асарсны тэтгэмж 11282 иргэнд 2,429,624,335, гурав ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх/ эцэгт/ олгох тэтгэмж 324 иргэнд 131,528,468, жирэмсэн эхийн тэтгэмж 2937 иргэнд 306,797,421, ихэр хүүхдийн тэтгэмж 20 иргэнд 47,000,000, халамжийн тэтгэвэр 2459 иргэнд 3,373,738,279, онцгой тохиолдлын тэтгэмж 16 иргэнд 19,200,000, алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлт 31 иргэнд 10,435,500, асаргааны тэтгэмж 3325 иргэнд 1,433,654,657 төгрөгийг тус тус олгосон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг дохионы хэлмэрчтэйгээр бэлтгэн, дүүргийн цахим болон фейсбүүк хуудсанд байршуулсан.
- Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 07/115 дугаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих эрхийг хангаж ажиллах” тухай албан мэдэгдлийг холбогдох барилгын стандарт, дүрэм журмын хамт барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 50 байгууллагад хүргүүлсэн.
- Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2 удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан 2 удаагийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, 300 орчим хүүхдийг хамруулсан.
- Биеийн тамир спортын хорооны зааланд долоо хоног бүрийн Лхагва гарагийн 11:00-13:00 цагт хөгжлийн бэрхшээлтэй иргэд биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлснээр давхардсан тоогоор 800 гаруй иргэд үйлчлүүлсэн байна.



Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх замаар дэмжлэг үзүүлж, амжилтыг ахиулах зорилтын хүрээнд:

Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн 640 тамирчин улс, нийслэлийн 28 тэмцээн, уралдаанд оролцож, алтан медаль-51, мөнгөн медаль-47, хүрэл медаль-56, нийт 154 багц медаль хүртсэн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг спортын 10 төрөлд 10 дасгалжуулагчийн удирдлага доор нийт 270 тамирчин бэлтгэл сургуулилт хийж байна. 2022 онд орон нутгийн төсөвт өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаанд шаардагдах 42.0 сая төгрөгийг тусгуулан дэмжлэг үзүүлэн ажилласан.



Дүүргийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/276 дугаар захирамжаар “Эко ногоон дүүрэг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөл байгуулагдаж, ажлын төлөвлөгөө, шаардагдах төсөв хөрөнгө батлагдсан. Дэд хөтөлбөрийн хүрээнд 111308 ширхэг мод, бут, сөөг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, 250,000 гаруй гоёл чимэглэлийн цэцгийг үрслүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу 1, 2, 6, 8, 11, 13, 14, 15, 20, 21 дүгээр хорооны 17 байршилд нийт 2778,1 м.кв талбайд цэцгийн мандал байгуулах, 2532,1 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлэх ажлууд тус тус хийгдсэн.


“Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяны хүрээнд мод, бут, сөөг тарих ажлыг “Ойжуулалт, ойн зурвас байгуулах /14 дүгээр хороо, Айцын ам, 7 га/”, “Гэр хорооллын өрхүүдтэй хамтарч мод тарих /9, 10, 12, 13, 14, 16 дугаар хороо/, “Нийтийн эзэмшлийн болон хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх”, “Мод үржүүлгийн газрын хамгаалалтын зурвас байгуулах” гэсэн үндсэн 4 чиглэлийн хүрээнд зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор нийт 111308 ширхэг мод, бут, сөөгийг тарьсан.

Зураг. Нээлтийн арга хэмжээ, Айцын ам, ойн төгөл байгуулах талбай, 7 га



Хөдөө аж ахуйн их сургуультай хамтарч иргэдэд мод тарих соёлыг түгээн сурталчлах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад мод тарьж ургуулах, зөв арчилж хамгаалах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч 41 сургагч багшийг мэргэжлийн багш, судлаачдын бэлтгэсэн 3 модуль, 15 сэдвийн хүрээнд 20 цагийн багц сургалтад хамруулж, батламж олгосон. Тус багш нар аяны туршид мод тарьж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байна.





“Ногоон хот – Иргэний оролцоо мод тарих аян” мод тарих, арчлах хамгаалах хялбаршуулсан заавар, аргачлал бүхий 1650 ширхэг гарын авлагыг бэлтгэж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөмж, мэдээлэл хүргэсэн. Мишээл групп ХХК болон мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтарч гоёлын

болон жимс, жимсгэнийн тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг 2022 оны 05 дугаар сарын 07-12-ны өдөр хүртэл Байгаль орчин, танин мэдэхүйн цэцэрлэгт хүрээлэнд, 05 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд 14 дүгээр хороо Айцын аманд зохион байгуулсан.

Зураг. Тарьц, суулгацын үзэсгэлэн худалдаа



Хүснэгт. “Ногоон хот – Иргэний оролцоо” аяны хүрээнд тарьсан мод, бут, сөөгийн тоо

№	Мод тарьсан байршил	Оролцсон байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, төлөөлөгчид	Тарьсан мод, тоо
1	Айцын ам, ойжуулалт, ойн зурвас байгуулах талбай /14 дүгээр хороо/	УИХ-ын гишүүд, нийслэл, дүүргийн төлөөлөгч нар, ЗДТГ, нийслэлийн төр захиргааны байгууллагууд, аж ахуйн нэгж, байгууллага	4683
2	Гэр хороолол /9, 10, 12, 13, 14, 16 дугаар хороо/	790 өрх	7643
3	13 дугаар хорооны өрхүүд	Байгалиа дээдэлъ ХХК	1000
4	114, 118, 130 дугаар сургууль, 28, 121, 290 дүгээр цэцэрлэг	114, 118, 130 дугаар сургууль, 28, 121, 290 дүгээр цэцэрлэг	125
5	Ногоон хэрэм /ХУД, 14 дүгээр хороо/	Нийслэлийн төр захиргааны байгууллагууд	1380
6	7, 8 дугаар байрны далангийн тохижилтын ажлын хүрээнд /ХУД, 2 дугаар хороо/	Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгч "Таван од констракшн" ХХК	400
7	Олон улсын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн /ХУД, 8 дугаар хороо/	БОАЖЯ, "Туурайн төвөргөөн" ХХК, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд	22000
8	Богд хааны ордон музейн зүүн талд /ХУД, 19 дүгээр хороо/	Улаанбаатар зам засвар, арчлалт ОНӨААТҮГ	560
9	41 дүгээр цэцэрлэгийн гадна талбай /ХУД, 20 дугаар хороо/	Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс	200
10	Наадамчдын зам /Нисэх - Морин, Биокомбинат - Шувуун фабрик/	"Охь мандал" ХХК /УБЗАА/	1500
11	Өлзийтийн зам дагуу /Жаргалантын уулзвараас МТ ШТС хүртэл/	"Эко эрин тохижилт" ХХК /УБЗАА/	610
12	Жаргалантын ам /ХУД 8 дугаар хороо/	Онцгой байдлын Ерөнхий газар	2000
13	Арцатын ам /ХУД 4 дүгээр хороо/	Цагдаагийн Ерөнхий газар	10074
14	Наадамчдын зам дагуу	Гэрэлтүүлгийн компаниуд /УБЗАА/	20000
15	Оргил худалдааны төвийн баруун талд /ХУД, 8 дугаар хороо/	"Улаанбаатар шинэчлэлт" ХХК, "Тотал инж" ХХК /УБЗАА/	2500
16	Нийтийн эзэмшил болон хязгаарлагдмал хэрэгцээний ногоон	21 хорооны иргэд, ААНБ, сургууль, цэцэрлэг, СӨХ	11243

	байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд		
17	Яармагийн гүүр /ХУД, 4 дүгээр хороо/	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	2350
18	Агропаркийн талбай, мод үржүүлгийн газрын хамгаалалтын зурвас	"Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ	18400
19	Буянт-Ухаа 1 хороолол	НОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй тохижилтын ажлын хүрээнд	3600
20	Морин тойруулга	Макс өргөө ХХК	1040
Нийт		-	111308

Дүүргийн Засаг даргын 2022 оны А/75 дугаар захирамжийн дагуу 10 төрлийн 250,000 гаруй гоёл чимэглэлийн цэцгийг үрслүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу 1, 2, 6, 8, 11, 13, 14, 15, 20, 21 дүгээр хорооны 17 байршилд нийт 2778,1 м.кв талбайд цэцгийн мандал байгуулах ажлыг хэрэгжүүлж, усалгаа, арчлалт хамгаалалтыг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгэж байна. Нийслэлийн хот тохижилтын газар ОНӨААТҮГ Чингисийн өргөн чөлөөний авто замын 5 бөлвэрт нийт 1800 ширхэг гоёл, чимэглэлийн байцаан цэцэг тарьсан.

Нийслэл, дүүргийн төсвөөр хэрэгжиж байгаа тохижилтын ажлын хүрээнд болон аж ахуйн нэгж, байгууллагуудын хөрөнгөөр 2, 4, 15, 19, 20, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийт 12532,1 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлж, тоосжилтыг бууруулсан


Зураг. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайн зүлэгжүүлэлт, цэцэрлэгжүүлэлт



Тохижилтын чиглэлээр: Дүүргийн Засаг даргын 2022 оны А/151 дүгээр захирамжаар байгуулагдсан Техник хяналтын комисс 2022 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр шинээр болон он дамжин хэрэгжих ажлуудыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлж, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 26 төсөл арга хэмжээний ажлын явц, гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавьж, стандарт, норм, дүрмийг мөрдүүлэн ажиллаж байна.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр "Орчны тохижилт"-ын чиглэлээр 1, 2, 3, 4, 10, 12, 14, 15, 16, 18, 19, 20, 21 дүгээр хороодод он дамжин хэрэгжиж буй 3 төсөл арга хэмжээний хүрээнд 16 ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

Зураг. Орчны тохижилтын хүрээнд хийгдэж буй ажлын явц



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр 2 дугаар хороо 7, 8 дугаар байрны ард амралтын талбай, сагсан бөмбөгийн талбай, тоглоомын талбай, авто зогсоол, явган зам, ногоон байгууламж бүхий иргэд, олон нийтэд зориулсан тохижилтын ажил, 1 дүгээр хороо, 14, 15 дугаар хорооны тоглоомын талбайн засвар, шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлж байна.

Зураг. Тохижилтын ажлын явц



Хог хаягдлын тээвэрлэлтийн чиглэлээр: Дүүргийн хэмжээнд хог хаягдлын тээвэрлэлт, цэвэрлэгээ, үйлчилгээнд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ, “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ, “Хан-Эко тээвэр” ОНӨААТҮГ, “Эко Хотын тээвэр” ОНӨААТҮГ газрууд айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудаас нийт 64,940 тонн хог хаягдлыг 17,420 рейсээр ачиж тээвэрлэсэн байна.

Зураг 11. Хог тээвэрлэлтийн явц



Хог тээвэрлэлтийн газруудын авто машин, ачигч болон тээвэрлэсэн хогны жингийн мэдээг өдөрт 2 удаагийн давтамжтай авч, хороодын Засаг дарга нараас ажлын үнэлгээг авч хяналт тавьж ажилласан.

Зураг 12. Хог тээврийн байгууллагуудын хариуцсан хороодын бүтэц зохион байгуулалт



Зам цэвэрлэгээ, үйлчилгээний чиглэлээр: Дүүргийн Засаг даргын 2022 оны А/46 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэр дэх туслах болон хорооллын доторх зам, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээний хуваарийг баталж “Тохижилт Үйлчилгээний Төв” ОНӨААТҮГ, “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ, “Охь мандал” ХХК, “Эко Эрин тохижилт” ХХК-ууд хариуцан ажиллаж байна.

Зураг 13. Давс бодис цацаж буй ажлын явц



Байгаль орчны чиглэлээр: Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/90, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/77, А/146 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангахаар Өлзийт-шувууны уулзварын болон Морингийн давааны хяналтын цэгт Агаар орчны бохирдлын хяналтын тасаг нь Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуй нэгжүүдийн тээвэрлэлт, тээвэрлэлт хийж байгаа жолооч нарт “MNS4598:2020” Авто тээврийн хэрэгслийн техникийн ерөнхий шаардлага, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд нөлөөлөх үзүүлэлтүүдийн хэмжээг мөрдүүлэхээр 10,12,13,14,16, 21 -р хороодын хэсгийн ахлагч нар болон Цагдаагийн 2-р хэлтсийн албан хаагч, Замын цагдаагийн албан хаагчтай хамтран 103 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Зураг 14. Хяналт шалгалтын ажлын явц



Цагдаагийн байгууллага хороодын Засаг дарга нартай хамтран түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжийн тээвэрлэлттэй холбоотой хууль тогтоомж, захирамжийг холбогдох байгууллагуудад сурталчлан танилцуулах, хэрэгжилтийг хангахаар дүүргийн Засаг даргын 1-р орлогч даргаар удирдуулан ажлын хэсэгтэй 13, 14-р хорооны нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг 34 аж ахуй нэгжийн 17 байгууллагаар орж хяналт шалгалт хийсэн. Тус шалгалтаар 5 аж ахуйн нэгж байгууллага бичиг баримтын шаардлага хангасан байсан.

Зураг 15. Хяналт шалгалтын ажлын явц



Шалгалтаар зөрчил илэрсэн 12 аж ахуй нэгж байгууллагад дүүргийн Засаг даргын албан шаардлагыг хүргүүлсэн.

Нисэхийн тойргоос, Био, Шувуун фабрик, Өлзийт хүртэлх замд ТТАМ авто тээврийн хэрэгслийн “Авто тээврийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2020” стандартыг мөрдүүлэх хүрээнд авто тээврийн хяналтын хуудасны бүртгэлд хяналт тавьж Өлзийт шувууны уулзвар дээр Пост-1, Морингийн давааны уулзвар дээр Пост-2-г тус тус ажиллуулж байна.

Тус постуудаар 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс 6 дугаар сарын 11 өдрийг дуустал хугацаанд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудын тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллахад 8287 тээврийн хэрэгсэл 13179 рейсээр 237,384 тн хайрга, дайрга зөөвөрлөн тээвэрлэсэн байна. Тээвэрлэх хугацаандаа MNS4598:2020 стандартыг зөрчсөн 4880 тээврийн хэрэгслийн жолоочид 94,126,500 сая төгрөгийн торгуулийг Зөрчлийн тухай хуулийн дагуу ногдуулж ажилласан.

Үр дүнд нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/90 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажилласны үр дүнд шөнийн 22 цагаас хойш байнга тээвэрлэлт хийдэг байсан явдал таслан зогсож, иргэдээс ирж байгаа шөнийн тээвэрлэлтийн гомдол буурсан байна.
2. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/77, А/146 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажилласны үр дүнд хулгайгаар олборлолт хийж ажиллаж байсан “Дабль мөнх”ХХК, “Очир шүр” ХХК-ны үйл ажиллагааг таслан зогсоосон.
3. Хулгайгаар тээвэрлэлт хийж байсан 8 тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийг зогсоосон.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулах зорилгоор дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Мал эмнэлгийн тасагтай хамтран мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж 2021 оны ажил гүйцэтгэх гэрээг дүгнэн, зөрчил дутагдлыг арилгуулж, 2022 онд ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажилласан. Нийт 3 удаагийн арга хамжээ зохион байгуулж, 11.5 сая төгрөг үйл ажиллагааны зардалд зарцуулсан.

Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

Мал амьтны гоц халдварт шүлхийн вакцинжуулалтад 621 малчин, мал бүхий өрхийн 33837 толгой малыг хамруулсан.



Дүүргийн хэмжээнд малын сэг зэм устгалын ажлыг Мал эмнэлгийн тасаг, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, мал бүхий хороодын ажилтан, албан хаагчидтай хамтран зохион байгуулж, 902 ширхэг мал, амьтны сэг зэмийг зориулалтын цэгт устгаж булшлан, 15950 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, малчин өрх, фермерүүдийн хашаа хорооны 62710м2 талбайд ариутгал хийж гүйцэтгэсэн.



Дүүргийн Засаг даргын 2022 оны А/210 тоот “Мал эмнэлгийн арга хэмжээний тухай” захирамжийн хүрээнд мал бүхий 12,13,14 дүгээр хорооны мал, амьтныг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 81932 малыг хамруулаад байна.

Малын гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг ба үхрийн арьс товруутах өвчний илрүүлэлт, тандалтын ажилд 3 өрхийн 48 толгой малыг хамруулсан.



Улсын Мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 22-1092 тоот дугаартай шинжилгээгээр 14 дүгээр хорооны иргэн С.Дүгэржавын адуунаас ям өвчний эсрэг бием илэрсэнтэй холбогдуулан, дүүргийн Засаг даргын А/165 дугаар захирамжаар иргэн С.Дүгэржавын хашаанд хязгаарлалтын дэглэм тогтоож 51 адуунаас цусны ийлдэсний дээж авч, 2 адууг мал, амьтны хүүр, сэг, зэм устгах зааврыг дагуу хогийн нэгдсэн цэгт устгаж, голомтын бүсийн 700мкв талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.



Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр: Дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хорооны 250 өрхөд 2.2 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний ногооны үрийг олгож, тариалалтыг дэмжин ажилласан. Хүнсний ногооны борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 3 удаагийн үзэсгэлэн худалдаанд хүлэмжийн тариалан эрхлэгч 10 иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулж, эрт ургацын хүнсний ногоог олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.




Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” 3 хувийн хүүтэй зээлд хамрагдах хүсэлтэй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, хүлэмж, үр тариа, тос тэжээлийн таримлын тариалалтын үйлдвэрлэл эрхэлдэг 477 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, ХХААХҮЯ-д хүргүүлсэн.

“Хан-Уулд тариалав” брэнд болох тарвасын тариалалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

Хан-Уулд тариалав” брэнд бий болгох зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүгийн тооцоолол бүхий төслийг боловсруулж Засаг даргын зөвлөлийн хүралд танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.



Тарвас тариалах сонирхолтой иргэдийн судалгааг цахимаар авч, тарвас тарих сонирхолтой иргэдэд тарвасын ач холбогдол, тарилт, ургалт, хортон шавжтай тэмцэх чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж ажиллахаар төлөвлөж, хагас жилийн байдлаар нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран 16 иргэнийг сургалтад хамруулсан.



Дүүргийн "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ын агропаркат тарвас тарьж ургуулахаар 2000 ширхэг тарвасын үрслэгээний ажил хийгдэж байна.

Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Богд банктай хамтран жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан сарын 1.2-1.9 хувийн хүүтэй зээлд дүүргийн шаардлага хангасан 58 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг холбон зуучилсан. 2022 оны хагас жилийн байдлаар дүүргийн 58 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид 3.7 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна.

Дүүргийн Засаг даргын 2022 оны А/160 дугаар захирамжаар ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд стандарт шаардлага мөрдүүлэх, галын аюулгүй байдлыг хангуулах, иргэдэд амрах аялах таатай нөхцөлийг бүрдүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт 13 амралтын газар, жуулчны баазад дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэстэй хамтран хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан, зөвлөн тусалж ажилласан.

Дүүргийн хүнсээр хангах албаны гамшгийн төлөвлөгөөнд тодотгол хийж, хүнсний хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг ослын үед хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүнээр хангах зорилгоор хүнс нийлүүлэх 35 мэргэжлийн анги буюу худалдаа, хоол, үйлдвэрлэл үйлчилгээний газруудтай "Болзошгүй гамшгийн үед хүнсний нөөц нийлүүлэх гэрээ" байгуулж, бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг 7 хоног бүр 11 хүнсний үйлдвэр, 20 худалдааны газраас авч нэгтгэн, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлж байна.



"Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвийг хүн амын нягтаршил сайн, ашигтай талбайд нээхээр дүүргийн 10 гаруй томоохон худалдааны төвийн судалгааг гаргасан. Уг судалгаагаар байршил, м2 тутмын үнэ, иргэдийн нягтаршил зэргийг харгалзан үзэж дүүргийн 4 дүгээр хороонд байрлах "Фүүд сити" худалдааны төвийг сонгосон. Борлуулалтын төвийн үйл ажиллагааг нээх санхүүжилтийг "Эко Ногоон дүүрэг" дэд хөтөлбөрөөс гаргуулах саналтайгаар "Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих төсөл"-ийг боловсруулан ажлын хэсэг, Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулсан. Төрийн Хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд уг төслийн хэрэгжих хугацаа хойшилсон.

"Цагаан сар-2022", "Их хотын хавар-2022", "Амралтын өдрийн худалдаа", "Улаанбаатар марафон-2022" зэрэг өргөтгөсөн худалдаанд давхардсан тоогоор дүүргийн 51 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж, нийт 37.7 сая төгрөгийн борлуулалтыг дэмжин ажилласан.

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 1 давхарт 32 м2 бүхий 2 өрөөнд 15 үйлдвэрлэл эрхлэгчийг үнэ төлбөргүй ажлын байраар ханган дэмжин ажилласан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 15 үйлдвэрлэл эрхлэгчид нийт 3.5 сая төгрөгийн борлуулалт хийж ажилласан.

2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Бойжуулах төвийн бойжигч нарын бүтээлээр үзэсгэлэн гаргасан. Мөн тус төвийн багш Монгол улсын зөвлөх багш, мастер оёдолчин С.Бадамхандтай хамтран “Оёдол, эсгүүрийн практик сургалт”-ыг зохион байгуулсан. Сургалтад 4 дүүргийн 32 иргэн хамрагдсан.

“Иргэд, өсвөр үе, залуучуудыг согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх хорт зуршлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө”- г дүүргийн Засаг даргаар батлуулан, ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба, дүүрэг дэх Цагдаагийн газар, Боловсролын хэлтэс, Хуульчдын холбоо, “Мөрдөхүйн ухаан” ТББ-тай хамтран сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэстэй хамтран ерөнхий боловсролын 52, 75 дугаар сургуулийн сурагчдад “Хүүхдийн эрхийн тухай ойлголт, хүүхэд хамгааллын тогтолцоо”, “Сургуулийн орчин дахь дээрэлхэлд, дарамтаас урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 25, 05 дугаар сарын 18-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж 251 сурагч хамрагдсан.

Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албатай хамтран “Мансууруулах эм, хар тамхины хор уршиг, шалтгаан, хүчин зүйл, эрх зүйн орчин болон урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт сургалтыг 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад 117 эцэг, эхийн төлөөлөл, сэтгэл зүйч хамрагдсан.

Хуульчдын холбоотой хамтран “Ажлын байран дахь дарамт болон хүчирхийлэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хандлага” сэдэвт сургалтыг 04 дүгээр сарын 13-ны өдөр Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 14, 30, 65 дугаар ангийн 55 албан хаагч хамрагдсан.

Дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэстэй хамтран “Архи, согтууруулах ундааны хор хөнөөл ба гэр бүлийн хүчирхийлэл” сэдэвт сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 12-ны өдөр, 03 дугаар сарын 24-ний өдөр тус тус зохион байгуулж 25 иргэн хамрагдсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний дагуу эрх зүйн 5 сургалтын зохион байгуулж давхардсан тоогоор 645 иргэн, албан хаагч, сурагчийг хамруулсан.



ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1 Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийслэл, дүүргийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын 2022 оны 01 дүгээр улирлын байдлаар тайлагнах 4 тогтоолын холбогдох 12 заалтыг хяналтад авч, биелэлтийг нэгтгэн, Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулсан. /Биелэлт-45%/ Мөн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 01 дүгээр улирлын байдлаар тайлагнах 4 тогтоолын

биелэлтийг нэгтгэн 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04/610 дугаар албан бичгээр хүргүүлсэн. /Биелэлт-80%/

2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар Нийслэлийн Засаг даргын 5 захирамжийн 10 заалт, Засаг даргын 8 зөвлөлийн хурлын холбогдох 17 заалтыг тус тус хугацаанд нь <https://monitoring.ulaanbaatar.mn/> программаар тайлагнасан. Биелэлт-91%

Дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 3 тогтоол, хуралдааны тэмдэглэл-1, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 3 тогтоол тус тус ирж, хяналтын картын маягтын дагуу холбогдох албан тушаалтнуудад танилцуулан хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны эхний хагас жилд тайлагнах 20 тогтоол шийдвэрийн холбогдох 60 заалтыг хяналтад авч, биелэлтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, алба болон Засаг даргын дэргэдэх 29 хэлтэс, албадаас авч нэгтгэж байна. Тайлагнах хугацаа болоогүй.

Хүснэгтээр харуулбал:

ТОГТООЛ, ШИЙДВЭР	ТОО	ЗААЛТ
2022 оны эхний хагас жилийн байдлаар		
Монгол Улсын хууль	1	12
Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол	1	1
Ерөнхийлөгчийн зарлиг	2	9
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	1	1
Засгийн газрын тогтоол	9	27
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	6	10
ДҮН	20	60

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУДААС:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын 3.1 дэх заалтын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу дүүрэгт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Уг төлөвлөгөөнд 13 ажил, үйлчилгээг зохион байгуулахаар төлөвлөж, биелэлтийг хэлтэс, албадаас хүлээн авч нэгтгэн дүүргийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 11/956 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн. Биелэлтийн дундаж 92%

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай 2022 онд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний Хан-Уул дүүрэгт хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг нэгтгэж ЗДТГ-ын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 11/916 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 217, 218 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын Хэрэг эрхлэг газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн хавсралтад заасан журмын дагуу Засаг даргын Тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлан, үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг сар, эхний хагас жилээр, тус тус нэгтгэн боловсруулж, холбогдох албан тушаалтад танилцуулан баталгаажуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст тус тус

тайлант хугацаанд нь <https://erp.ulaanbaatar.mn/> цахим хаягаар болон албан бичгээр хүргүүлсэн.

Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах саналыг хэлтэс, албадаас хүлээн авч нэгтгэн 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр батлуулсан.

Тус төлөвлөгөө нь нийт 6 бүлгээс бүрдэж байгаа бөгөөд нэгдүгээр бүлэг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 15 зорилт, 23 арга хэмжээ, хоёрдугаар бүлэг Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд 3 зорилт, 3 арга хэмжээ, гуравдугаар бүлэг Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд 11 зорилт, 16 арга хэмжээ, дөрөвдүгээр бүлэг дүүргийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд 35 зорилт, 64 арга хэмжээ, тавдугаар бүлэг Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 1 зорилт, 32 арга хэмжээ, зургаадугаар бүлэг Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд 1 зорилт, 16 арга хэмжээ, нийт 66 зорилт 154 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 88.5 хувьтай хэрэгжсэн.

Хүснэгт -1

Д/д	Бодлогын баримт бичиг	Зорилтын тоо	Хувь	Арга хэмжээний тоо	Хувь
1	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	15	80.6	23	84
2	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд	3	100	3	100
3	Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд	11	88	16	88.1
4	Дүүргийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд	35	70	64	77.4
5	Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд	1	96.3	32	96
6	Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	1	82.8	16	82.8
7	Нийт	66	86.2	154	88.5

Хүснэгт -2

№	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ	Арга хэмжээ	Хувь	ҮҮНЭЭС				
				Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй

1	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд	23	78.6	13	6	2	1	1
2	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд	3	100	2	-	-	-	1
3	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд	16	88.7	12	3	1	-	-
4	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд	64	78.2	39	13	6	1	5
5	Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд	32	96.3	26	2	-	-	4
6	Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	16	82.8	10	2	2	-	2
7	НИЙТ	154	88.5	102	26	11	2	13

Засаг даргын Тамгын газрын нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, үнэлж, дүгнүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр:

Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах хүрээнд албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх "Үнэлгээний баг"-ийн бүрэлдэхүүнийг ЗДТГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан.

Үнэлгээний багийн үйл ажиллагаа: Засаг даргын Тамгын газрын 11 хэлтэс, албадын 71, хороодын 45 нийт 116 албан хаагчийн 2022 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн нэгжийн даргын үнэлгээг, тайлангийн хамт 06 дугаар сарын 17-ны өдөр хүлээн авч 20,21-ний өдөр хуралдан, үнэлгээг бодитой дүгнэсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч баталгаажуулсан.

2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ

Хүснэгт-3

Д/д	Хэлтэс, албад	Дүгнэгдсэн нийт албан хаагч	Төрийн жинхэнэ албан хаагч	Төрийн үйлчилгээний	А үнэлгээ	В үнэлгээ	С үнэлгээ	Д үнэлгээ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР								
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	8	4	4	4	4	-	-
2	Санхүү, төрийн сангийн хэлтэс	12	12	-	8	4	-	-
3	Хууль, эрх зүй, архивын хэлтэс	5	3	2	2	3	-	-
4	Төлөвлөлт, гүйцэтгэл, мониторингийн хэлтэс	4	4	-	3	1	-	-
5	Нийгмийн хөгжлийн хэлтэс	4	4	-	3	1	-	-
6	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	5	5	-	4	1	-	-

7	Тохижилт, ногоон байгууламжийн гүйцэтгэл хяналтын хэлтэс	4	3	1	3	1	-	-
8	Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтэс	7	2	5	2	5	-	-
9	Аж ахуй, үйлчилгээний хэлтэс	13	2	11	11	2	-	-
10	Цэргийн штаб	6	6	-	2	4	-	-
11	Олон нийттэй харилцах алба	3		3	1	2	-	-
12	НИЙТ	71	45	26	43	28	-	-
ХОРООД								
13	Зохион байгуулагч	27	27	-	11	14	2	-
14	Нийгмийн ажилтан	18	18		8	9	1	
15	НИЙТ	45	45		19	23	3	
16	НЭГДСЭН ДҮН	116	90	26	62	51	3	-

Дээрх шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийг баримтлан үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний саналыг Төсвийг шууд захирагчид хүргүүлж, албан хаагчдаас гарсан алдаа дутагдлыг арилгах, чадавхыг дээшлүүлэх арга хэмжээг дараагийн тайлант хугацааны төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг боловсруулан хэлтэс, алба, хороодод хүргүүлсэн.

Үүнээс албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах нийтлэг үүрэг, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй гүйцэтгэсэн 3 албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгоогүй.

Бусад албан хаагчдад Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн Б/83 дугаар тушаалаар урамшууллыг холбогдох журмын дагуу олгосон.

Засаг даргын Тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг нийслэлийн Засаг даргын 2017 оны 335 дугаар захирамжийн хавсралтад заасан журмын дагуу нэгтгэн боловсруулж Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр албан бичгээр болон файлаар нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст тус тус хүргүүлсэн.

ТОХИЖИЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко – Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор мод, бут, сөөг, цэцэг тарьж ургуулах, арчлан хамгаалах замаар ногоон байгууламжийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, тохилог орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор “Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяныг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, хяналт тавьж, ажиллаж байна.


“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 07 дугаар хурлаар хэлэлцүүлж, шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлүүлсэн.

Зураг. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө



Дүүргийн Засаг даргын 2021 оны А/664 дүгээр захирамжаар Засаг даргын Тамгын газарт Айцын аманд 100 га, Айцын даваанд 10 га талбайг Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих зориулалтаар олгосон. “Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяны хүрээнд Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай хамтарч Айцын амны 7 га талбайг хашаалж, ойжуулах, ойн зурвас байгуулах талбайн бэлтгэл ажлыг бүрэн хангасан.


“Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяны нээлтийг 2022 оны 05 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Айцын аманд зохион байгуулсан бөгөөд төр захиргааны 20, хувийн хэвшлийн 6 аж ахуйн нэгж байгууллага оролцож, нийт 4683 ширхэг мод, бут, сөөг тарьсан.



Ойжуулалт, ойн зурвас байгуулах талбайн ашиглалт, арчлалт, хамгаалалтыг сайжруулах, тогтмолжуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 16 дугаар хурлаар 1 гүний худаг гаргах, 25 тн багтаамжтай 1, 10 тн багтаамжтай 2, 1 тн багтаамжтай 10 усны нөөцийн сав байршуулах, дуслын усалгааны систем суурилуулах, цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэх, байнгын харуул хамгаалалттай

болгох ажилд шаардагдах 108,8 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг танилцуулж, төсөв хөрөнгийг шийдвэрлүүлсэн. 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар гүний худгийн өрөмдлөг болон цахилгааны ажил бүрэн шийдвэрлэгдсэн. Усан сан, дуслын усалгааны систем суурилуулахаар ажиллаж байна.

Зураг. Ойжуулалтын талбайд гүний худаг гаргах ажлын явц



Дүүргийн Засаг даргын 2022 оны А/239 дүгээр захирамжийн дагуу Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ 1, 2, 5, 7, 12, 13, 21 дүгээр хорооны 14 байршилд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эвдрэлтэй тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, амралтын талбайг засварлах, орчны аюулгүй байдал, чанар, стандартыг хангуулах ажлыг хэрэгжүүлж байна.


Тус ажлын хүрээнд дүүргийн 2 дугаар хороо 3 дугаар байрны урд амралтын талбайг засварлах ажлын хүрээнд хуучирч эвдэрсэн 500 м.кв явган хүний зам талбай, 1 ширхэг сүүдрэвч, 9 ширхэг сандлыг бүрэн шинэчлэх, 14 дүгээр хорооны гадна бичил цэцэрлэгийн эвдрэлтэй тоглоомын талбай, сандал, хогийн савыг засварлаж, шинээр будаж тохижуулах, 1

дүгээр хороо Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуурын эвдрэл, гэмтлийг засварлах ажлыг тус тус хэрэгжүүлсэн.

Зураг. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн засвар, арчлалтын ажлын явц



Зураг. Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуурын засварын ажил



Зураг. 14 дүгээр хороо, тоглоомын талбайн засварын ажлын явц



Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/211 дугаартай захирамжийн хүрээнд нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй амьдарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ хийх 4 ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Цахилгааны ил гарсан утастай гэрэлтүүлгийн 121 ширхэг шон, таггүй гэрэлтүүлгийн 403 ширхэг шон, явган хүний зам, орц гарц, хурд сааруулагч засаж сайжруулах саналыг 16 хорооны 85 байршил, шинээр хийлгэх шаардлагатай саналыг 18 хорооны 58 байршил, 14 засварлах шаардлагатай тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, амралтын талбайн судалгааг гаргасан.

Барилгын аюулгүй байдлыг ханган ажиллаагүй захиалагч, гүйцэтгэгч бүхий 20 аж ахуй нэгж байгууллагуудад нийт 80 заалттай 10 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч 6 байгууллагын зөрчлийг арилгуулсан.

Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд зөвшөөрөлгүй барьсан хашаа, хайсыг стандартын шаардлагад нийцүүлэх 18 байршилд хугацаатай мэдэгдэл өгснөөс нийт 4 байршилд зөрчлийг арилгасан.

Мөн хороодоос үүсмэл болон хур хог хаягдал үүссэн цэгүүдийн судалгааг авч нэгтгэн, газар дээр нь очиж 30 байршилд хяналт тавьсан.

Төрийн өмчийн болон, төрийн бус өмчийн нийт 176 ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчны эрсдэлийн үнэлгээ хийгдсэн.

Дүүрэгт устгал хийх эрх бүхий "Өлтэй" ХХК мэргэжлийн байгууллагаар 121 эзэнгүй нохой устгуулсан.

Зураг. Орчны аюулгүй байдлыг хангах ажлын явц



Нийслэлийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дүүргийн 1, 2, 3, 17 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж талбайд зөвшөөрөлгүй барьсан 183 авто машины гараашийг чөлөөлж, тохижуулахаар тусгагдсан бөгөөд тус байршлууд дээр Хот байгуулалт, хөгжлийн газраас архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан.

Газар чөлөөлөхөөр тусгагдсан 183 гараашийг бүрэн буулгаж, газрыг чөлөөлсөн бөгөөд "Нийслэлийн хот тохижилтын газар" ОНӨААТҮГ 2 дугаар хороо, 65 дугаар цэцэрлэгийн баруун талд, 29, 31, 33 дугаар байрны хооронд, 17 дугаар хороо, Удирдлагын академийн зүүн урд талд нийт 101 гарааш чөлөөлсөн талбайд, дүүргийн Засаг даргын Зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу "Хан-Уул зам засвар, арчлалт" ОНӨААТҮГ 1, 2, 3 дугаар хорооны 4 байршилд авто зогсоол болгож тохижуулахаар бэлтгэл хангаж байна.

Зураг. Газар чөлөөлөх ажлын явц



Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад нэгдсэн үзлэг шалгалт явуулж, барилгын түр хашааны стандартын шаардлага хангуулах, зөрчлийг арилгуулах, стандарт, норм, дүрмийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хооронд тус дүүрэгт зохион байгуулсан.

Тус ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, ногоон байгууламж, явган зам дээр зөвшөөрөлгүй байршуулсан өнгө үзэмжгүй урагдаж, хуучирсан 49 мэдээллийн самбар

болон хайс, хашлага дээр наасан хулдаасан хэвлэл, зар сурталчилгааны 304 хулдаасан самбарыг буулгасан.

Зураг. Зөвшөөрөлгүй хаяг, хаягийн байгууламж буулгах ажлын явц



Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/211 дүгээр захирамжийн хэрээнд иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай, амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор эзэнгүй нохой, муурны устгал, үүсмэл болон хур хог хаягдлыг цэвэрлэх, устгуулах ажлыг дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран хэрэгжүүлж ажилласан.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай гэрээ байгуулан тус дүүрэгт эзэнгүй муур нохойны устгал хийх эрх бүхий "Өлтэй" ХХК мэргэжлийн байгууллагаар устгуулан ажиллаж байна. 2022 оны 06 сарын байдлаар нийт 121 нохой устгасан байна.

№	Хороо	Устгасан нохой, муурны тоо	12	12-р хороо	15 нохой
1	1-р хороо	Устгуулах байхгүй	13	13-р хороо	5 нохой
2	2-р хороо	Устгуулах байхгүй	14	14-р хороо	15 нохой
3	3-р хороо	2 нохой	15	15-р хороо	Устгуулах байхгүй
4	4-р хороо	10 нохой	16	16-р хороо	14 нохой
5	5-р хороо	15 нохой	17	17-р хороо	Устгуулах байхгүй
6	6-р хороо	4 нохой	18	18-р хороо	Устгуулах байхгүй
7	7-р хороо	2 нохой	19	19-р хороо	Устгуулах байхгүй
8	8-р хороо	5 нохой	20	20-р хороо	Устгуулах байхгүй
9	9-р хороо	16 нохой	21	21-р хороо	3 нохой
10	10-р хороо	3 нохой	22	Нийт	121 нохой
11	11-р хороо	12 нохой			

Орчны бохирдол ихээр үүсгэж, байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа хур хог, хог хаягдалд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтэс, дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс хамтран хяналт шалгалт хийсэн.




Сууц өмчлөгчдийн холбооны чиглэлээр: Сууц өмчлөгчдийн холбоодод төрөөс тавих хяналтыг сайжруулах, хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ажил үйлчилгээний түвшнийг сайжруулах үйл ажиллагааг давхар эрхлэх барилгын компани, хувийн орон сууцны контор хууль бусаар байгуулагдсан сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор дүүргийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А/208 дугаар захирамжийн хүрээнд 4 дүгээр сарын 07-ны өдрөөс 5 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлтэй хамтран 1, 2, 3, 4, 8, 10, 11, 12, 15, 16, 17, 18, 19, 20, 21 дүгээр хороодын бүртгэлтэй 292 сууц өмчлөгчдийн холбооноос 208 сууц өмчлөгчдийн холбооны ажлын байранд очиж үзлэг шалгалт хийж үнэлэлт, дүгнэлт, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Шалгалтын дүнд ажил сайжруулах шаардлагатай 13, хангалтгүй үнэлгээ авсан 11, бүрэн хангалттай үнэлгээ авсан 78, зөвлөгөө авсан 44 СӨХ байна. Тус ажлын хүрээнд Сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэл мэдээллийг шинэчлэн дүүрэг, хороодын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 205 СӨХ-той гурвалсан гэрээг байгуулсан.

Зураг.27 Шалгалтын үйл явц



ЭНГ ДҮҮРЭГ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ХОРООД



Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу үзлэг шалгалтад хангалтгүй үнэлгээ авсан хороодод ажлын хэсгийн зөвлөмж хүргүүлсэн.

Хүүхдийн зуны амралт эхэлж байгаатай холбогдон дүүргийн Засаг даргын захирамжаар хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж дүүргийн нутаг дэвсгэр дэх хүүхдийн



тоглоомын талбай, амралтын талбайн байгууламжуудын бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ үйлчилгээ, чанар аюулгүй байдлыг хянан шалгаж эвдэрч гэмтсэн, сэргээн засах шаардлагатай тохижилтын ажлуудыг дүүргийн орон сууц өмчлөгчдийн холбоодтой хамтран хийж гүйцэтгэлээ.

Худалдаа, үйлчилгээний чиглэлээр: Дүүрэг дэх Цагдаагийн газар, Эрүүл мэндийн төвтэй хамтран Ерөнхий боловсролын сургуулийн ахлах болон дунд ангийн 978 сурагчдыг хамруулан, “Архи, тамхины хор уршиг, хорт зуршил гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 9 удаа зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



НЗД-ын А/987 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргүүлэх чиглэлээр Ulaanbaatar.mn цахим сайтын “Онлайн бизнес төв” бүртгэлийн системээр иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч, тухай бүрт шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.



Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний газруудад <https://service.ulaanbaatar.mn/home> сайтын “Онлайн бизнес төв” үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системийг танилцуулах сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран танхимаар 5, цахимаар 4 удаа зохион байгуулж нийт 1070 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж, мэдээлэл өгч, гарын авлага материалаар ханган ажилласан.



Эхний хагас жилийн байдлаар дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр бүртгэлийн системээр нийт 510 хүсэлт ирснээс 49%-ийг нь шийдвэрлэсэн. Хүсэлтийн явц:

- Шийдвэрлэсэн – 249
- Шилжүүлсэн – 230
- Судалж буй -31 байна.

Дэргэдэх байгууллагуудын шийдвэрлэлтийн явцыг сайжруулах чиглэлээр дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын албан бичгийг хүргүүлж ажилласан.



Нөөцийн махны чанар, аюулгүй байдал, үнэ, борлуулалтад дүүргийн Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, хороодын албан хаагчидтай хамтран 16 удаагийн хяналт тавьж, иргэдийн гомдол, санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан.

Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал оруулахгүй байх, орж ирсэн малыг зөвшөөрсөн бүсэд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр 5 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 2.6 сая төгрөг үйл ажиллагааны зардалд зарцуулсан. Үүнд :

Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд хяналт тавин ажиллаж буй 2 эргүүлийн ажилтны ажлын гүйцэтгэл, цаг ашиглалтад хяналт тавин ажиллаж байна.



2022 оны эхний 6 сарын байдлаар хориглосон бүсэд орж ирсэн нийт 670 гаруй толгой малыг зөвшөөрсөн бүсэд тууж гарган, 13 өрхийн 191 толгой малыг хашаалан, малын эздэд нийт 800,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, эздэд нь хүлээлгэн өгсөн.



Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүс буюу дүүргийн 12 дугаар хорооны малтай 24 өрхөд дүүрэг дэх Мал эмнэлгийн тасаг, хороотой хамтран нүүлгэн шилжүүлэх хугацаатай албан мэдэгдэл, шаардлагыг хүргүүлж, 1 иргэний 27 тооны үхрийг Төв аймгийн Батсүмбэр суманд нүүлгэн шилжүүлсэн.



Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгийн үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих ажлын хүрээнд:

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 46 түргэн хоолны цэгийн үйл ажиллагаанд дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран хүнсний түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, стандарт шаардлагад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан.


Нийслэлийн мэргэжлийн хяналтын газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт түргэн хоолны үйл ажиллагаа эрхлэгч 43 иргэнд хүнсний эрүүл ахуй, чанар стандарт, галын аюулгүй байдал, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг техникийн ерөнхий шаардлага MNS 6192:2010 стандартын танилцуулах сургалт уулзалтыг зохион байгуулж ажилласан.

Дүүргийн худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр хурлаар явуулын үйлчилгээтэй түргэн хоолны үйл ажиллагаа эрхлэгчдийг стандарт шаардлага хангасан, явган хүн, тээврийн хэрэгслийн замын орц, гарц хааж, замын хөдөлгөөнд саад учруулахгүй, ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй газраас хол зайд байрлаж хоол үйлдвэрлэлд ашиглаж буй бүтээгдэхүүн нь гарал үүсэл тодорхой, шинжилгээнд хамрагдсан байхаар шаардлага тавьж, үйлчилгээ эрхлэхийг дэмжихээр шийдвэрлэсэн.



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоол, Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны “Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай” А/82 дугаар захирамжийн хүрээнд тус дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийт хорооллын Уяачдын задгайн далан дагуу хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулж байгаа эсэхэд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн албан хаагчид, хорооны хамтарсан багийн нийгмийн ажилтан, хэсгийн байцаагчийн хамт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хяналт шалгалт хийсэн.

Хяналт шалгалтын явцад 22 зүчээгээр орж, 73 хүүхдийг бүртгэснээс сургууль завсардсан 6, орон нутаг болон бусад дүүргийн харьяалалтай 34 хүүхдийг илрүүлэн харьяалах орон нутаг, дүүрэгт мэдэгдэж, тус дүүргийн 59, 165 дугаар сургуульд хамрагдаж байгаа хүүхдүүдийн бүртгэлийг сургуулийн нийгмийн ажилтан, хамтарсан багт хүргүүлэн ажилласан.



Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолын хүрээнд үндэсний бичгийн хичээлийг танхим болон цахим орчинд зааж, анхан шат, гүнзгийрүүлсэн шатны сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан.

Нийслэлийн Боловсролын газраас зохион байгуулсан “Монгол бичиг заах арга зүйн зөвлөмж” сургалтад 78 багш, Боловсролын хэлтсээс зохион байгуулсан “Үндэсний бичиг” -ийн анхан шатны цахим хичээлд төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн 2600 гаруй багш, ажилчид, Монгол бичгийн гүнзгийрүүлсэн болон бийр, уран бичлэгийн сургалтад 14 багш тус тус хамрагдсан. Сургуулийн өмнөх боловсролын 16 цэцэрлэг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан монгол бичгийн танхимын сургалтыг зохион байгуулж, 326 багшийг хамруулсан.

2.2 Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажилтай холбоотой мэдээлэл:

“Хотын иргэний жил” зорилтот жилийн хүрээнд Хан-Уул дүүрэг хариуцсан хэрэгжүүлэх 6 зорилт 38 арга хэмжээг төлөвлөн биелэлтийг улирал тутам гарган нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж байна. Тус төлөвлөгөөний 1 дүгээр улирлын биелэлт 36.4%, 2 дугаар улирлын биелэлт 55.6 хувьтай тус тус хэрэгжсэн.

Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээнүүдээс дурдвал:

Дүүргийн Засаг даргын 2022 оны А/239 дүгээр захирамжийн дагуу Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ 1, 2, 5, 7, 12, 13, 21 дүгээр хорооны 14 байршилд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эвдрэлтэй тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, амралтын талбайг засварлах, орчны аюулгүй байдал, чанар, стандартыг хангуулах ажлыг хэрэгжүүлж байна. Тус ажлын хүрээнд дүүргийн 2 дугаар хороо 3 дугаар байрны урд амралтын талбайг засварлаж, хуучирч эвдэрсэн 500 м.кв явган хүний зам талбай, 1 ширхэг сүүдрэвч, 9 ширхэг сандлыг бүрэн шинэчлэх, 14 дүгээр хорооны гадна бичил цэцэрлэгийн эвдрэлтэй тоглоомын талбай, сандал, хогийн савыг засварлаж, шинээр будаж тохижуулах, 1 дүгээр хороо Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуурын эвдрэл, гэмтлийг засварлах ажлыг тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 16, 17 дугаар хороонд 2,8 км авто зам барих 2 төсөл арга хэмжээ, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 17, 18, 19, 20 дугаар хороонд 3,64 км хатуу хучилттай авто зам тавих ажил хуваарийн дагуу хэрэгжиж байна. Үүнд:

- 17-р хороо Эрдэнийн төгөл хотхоны баруун талаас Хүннү хорооллын авто зам хүртэлх 0,18 км авто замын ажлын гүйцэтгэгчээр “Эс Ар Пи инженер консалтинг монголиа” ХХК-тай шалгарч гэрээ байгуулсан.
- 18-р хороо Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох 0.6 км авто замын ажлын тендерийг 2 удаа зарласан боловч аж ахуйн нэгж байгууллага материал ирүүлээгүй. Тендер дахин зарлагдах шатанд.
- 19-р хороо Ерөнхий боловсролын 115 дугаар сургуулийн баруун талаар Туул гол гудамжийг Б.Шаравын гудамжтай холбох 0,6 км авто замын ажлын тендерийг 2 удаа зарласан боловч аж ахуйн нэгж байгууллага материал ирүүлээгүй. Тендер дахин зарлагдах шатанд.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр Хан-Уул зам засвар арчлалт ОНӨААТҮГ-ийн 2022 онд шинээр 4 авто замын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- 21-р хороо Буянт-Ухаа 2 хорооллын 0,25 км авто зам. Газар шорооны ажил хийгдэж байна.
- 9-р хороо Нисэхийн эцсийн автобусны буудал орчмын авто зам. Авто замын зураг төсөв батлагдсан. Замын ажил 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр эхэлнэ.
- 8-р хороо Сонсголон 8 дугаар гудамж хатуу хучилттай авто зам. Авто замын зураг төсөв батлагдсан. Замын ажил 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдөр эхэлнэ.
- 20-р хороо 27 дугаар цэцэрлэгийн зүүн талаар 70 метр авто зам. Авто замын зураг төсөв батлагдсан. Замын ажил 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр эхэлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”

3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр

Засаг даргын Тамгын газрын албан бичиг боловсруулалтын үйл ажиллагаанд Стандартчилал Хэмжилзүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-2021 стандартыг мөрдсөн.


2021 оны эхний хагас жилийн байдлаар дүүргийн хэмжээнд 17125 бичиг ирж шийдвэрлэлтийн хувь 97,47% -тай байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 22827 бичиг ирж шийдвэрлэлтийн хувь 98,18% хувь болж өссөн. 12026 албан бичгийг төлөвлөн явуулсан байна.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем ашиглагч нийт 102 байгууллагын албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног тутамд гаргаж Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулж ажилласан бөгөөд тайлант хугацаанд нийт 17 мэдээг бэлтгэн танилцуулсан байна.

Мөн дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж дээд шатны байгууллагад танилцуулан ажилладаг. Энэ ажлын хүрээнд сар тутмын 6, улирал тутмын 2 мэдээг тус тус гаргаж Нийслэлийн Архивын газарт хүргүүлээд байна.

Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газар нь нийт 2159 албан бичгийг цахим болон цаасан хэлбэрээр хүлээж авсан бол 2021 оны эхний хагас жилд 2214 бичиг хүлээн авсан буюу энэ хугацаанд ирсэн бичгийн тоо 55-аар буурсан байна.

Нийт албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 2021 оны эхний хагас жилийн байдлаар 93,94% байсан бол 2022 оны эхний хагас жилд 94,37% байна.



Хариутай бичгийн тоо 2021 оны эхний хагас жилийн байдлаар 171 байсан бол 2022 оны эхний хагас жилд 177 буюу 6 хариутай албан бичгээр өссөн бөгөөд хаалтын хувь нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар 92,69%, харин 2021 оны эхний хагас жилд 93,89% байна.

Зөрчлийн тоо 2021 оны эхний хагас жилийн байдлаар 276 байсан бол 2022 оны эхний хагас жилд 44 буюу 232-оор буурсан байна.

Хан-Уул дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн мэдээ:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем ашиглагч нийт 100 байгууллагын албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног тутамд гаргаж Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулж ажилладаг бөгөөд тайлант хугацаанд нийт 17 мэдээг бэлтгэн танилцуулсан байна.

Мөн дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж дээд шатны байгууллагад танилцуулан ажилладаг. Энэ ажлын хүрээнд сар тутмын 6, улирал тутмын 2 мэдээг тус тус гаргаж Нийслэлийн Архивын газарт хүргүүлээд байна.



Хүснэгтээс харахад тус дүүргийн хэмжээнд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 17125 албан бичгийг хүлээн авч шийдвэрлэсэн бол 2022 оны эхний хагас жилд 22827 буюу 5702-оор өссөн байна.


Дүүргийн хэмжээнд нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 2021 оны эхний хагас жилд 97,47% байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 98,18% байна.

Хариутай бичгийн тоо 2021 оны эхний хагас жилийн байдлаар 3440 байсан бол 2022 оны эхний хагас жилд 3060 буюу 380-аар буурсан бөгөөд хаалтын хувь нь 2021 оны эхний хагас жилд 97,06%, харин 2022 оны эхний хагас жилийн байдлаар 97,90% байна.

Зөрчлийн тоо 2021 оны эхний хагас жилийн байдлаар 711 байсан бол 2022 оны эхний хагас жилд 238 буюу 473-аар буурсан байна.

Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд явуулсан бичгийн мэдээ:

Засаг даргын Тамгын газраас төлөвлөн явуулсан албан бичгийн тоо 2021 оны эхний хагас жилийн байдлаар 1031 байсан бол 2022 оны эхний хагас жилд 1032 буюу явуулсан албан бичгийн тоо 1-ээр өссөн байна.



Дүүргийн хэмжээнд явуулсан албан бичгийн тоо 2021 оны эхний хагас жилийн байдлаар 8957 байсан бол 2022 оны эхний хагас жилд 12026 буюу явуулсан албан бичгийн тоо 3069-өөр өссөн.

Дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт хийсэн мэдээ

Нийслэлийн Архивын Газрын даргын 2018 оны А/05 дугаар тушаалаар дүүргийн төр, захиргааны байгууллагуудын баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих эрхийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт албан ёсоор шилжүүлсэнтэй холбогдуулан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ирсэн бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажилласан мэдээг сар тус бүрээр графикт харуулав.



Тус ажлын хүрээнд тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд нийт өссөн дүнгээр 13995 албан албан бичгийн шийдвэрлэлтийг хянаж үүнээс 13757 албан бичгийн шийдвэрлэлтийг хангалттай гэж үзэн баталгаажуулж, 231 албан бичгийн шийдвэрлэлтийг хангалтгүй гэж үзэн цуцалсан байна.

Захирамж, тушаалын мэдээ

Д/Д	Төрөл	2021.06	2022.06
1	Засаг даргын А захирамж	295	325
2	ЗДТГ-ын даргын А тушаал	62	53
3	Нийт	357	378

Дүүргийн Засаг даргын А захирамжийн тоо 21-ээр өссөн, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаалын тоо 9-өөр буурсан байна.

Засаг даргын тамгыг албан ёсоор Засаг даргын шуурхай ажил хариуцсан туслах Д.Балжинням Тамгын газрын даргын тамга, тэмдгийг Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн, даргын туслах Б.Ариунаа нар хариуцан түшиж ажилласан.

Байгууллагын нууц баримт бичиг, мэдээлэлтэй ажиллахдаа "Байгууллагын нууц"-ын журмыг мөрдлөг болгосон.

Байгууллагын хэмжээнд Архивын тухай, Төрийн албан ёсны хэлний тухай, Хөдөлмөрийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зарцуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын архивын үндсэн заавар, Тамга, тэмдэг баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар, бусад холбогдох стандартуудыг мөрдүүлэн ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/453 дугаар захирамжаар батлагдсан "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" захирамжийн дагуу Хан-Уул дүүрэг, Засаг даргын Тамгын газар түүний эрхлэх асуудлын хүрээний албан хэрэг

хөтлөлтийн нэгдсэн "EDOC" систем ашиглагч 100 байгууллагуудыг Тоон гарын үсгийн "Токен" төхөөрөмж ашиглаж хэвшүүлсэн. Энэ ажлын хүрээнд өдөр тутам утсаар болон биечлэн заавар зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.

Батлагдсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын хэмжээнд ирсэн болон явсан бичиг 7 төрлийн 91 боть баримтыг архивын стандартын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн акт үйлдэж, байгууллагын архивт хүлээлгэн өгсөн.

Байгууллагын албан бичигт стандарт хангуулах чиглэлээр

Захирамжлалын болон баримт бичиг болох зохион байгуулалт, мэдээлэл, лавлагааны баримт бичиг 2029 албан бичгийн боловсруулалтад Монгол улсын MNS 5140:2021 стандартын дагуу өдөр бүр мөрдлөг болгон хяналт тавьж ажилласан. Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамж 2022 оны хагас жилийн байдлаар 1030, ЗДТГ-ын даргын тушаал 349 нийт 1379 захирамжлалын бланк хэвлэгдсэн байна.

Хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээ:

№	Хэвлэмэл хуудасны төрөл	Нийт зарцуулсан хэвлэмэл хуудасны тоо	Хүчингүй болгосон хэвлэмэл хуудасны тоо
1	Засаг даргын захирамж	1030	66
2	Засаг даргын албан даалгавар	-	-
3	Засаг даргын А4	81	8
4	Засаг даргын А5	438	25
5	Засаг даргын гадаад	-	-
6	Тамгын газрын даргын тушаал	349	12
7	Тамгын газар А4	230	22
8	Тамгын газар А5	1280	82
9	Тамгын газар гадаад	-	-
	НИЙТ	3408	215

Архивын үйл ажиллагааны чиглэлээр:

Дүүргийн архивын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 11/494 дүгээр албан бичгээр Нийслэлийн архивын газарт хүргүүлсэн.

Дүүргийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комисс /цаашид "Дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК" гэх/-ын төлөвлөгөө, Байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын төлөвлөгөөг боловсруулан Засаг даргын Тамгын газрын дарга, Хууль, эрх зүй, архивын хэлтсийн даргаар тус тус батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2022 оны төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нөхөн бүрдүүлэлтийн 16 байгууллагын данс бүртгэл бэлэн болсон ба үүнээс 5 байгууллагын данс бүртгэлийг дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болоод байна.

Нөхөн бүрдүүлэлт:

Дүүргийн архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн 72 байгууллагын

➢ Байнга хадгалах-7845 хн

➢ Түр хадгалах-28042 хн

➢ 70 жилийн 6784 хадгаламжийн нэгжийн бүртгэлийг нягтлан шалгаж, дүүргийн

архивын хөмрөгийн нэгдсэн жагсаалтыг шинэчилсэн.

Хувийн хэргийн бүрдүүлэлт хийгдээгүй 18 байгууллагын хувийн хэргийн бүрдлийг ТААҮЗ-ын дагуу гүйцээж хийсэн.

Төрийн архивт 2022 оны төлөвлөгөөт нөхөн бүрдүүлэлт хийгдэх байгууллагууд:

➢ Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба (2013-2020)

➢ Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс (2013-2020) он

➢ Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба (2013-2020) он

➢ Хан-Уул дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв (2013-2020)

➢ Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв (1992-2020) он

- Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ (2013-2020)
- “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ (2011-2020) он
- “Хан-Уул Яармаг” ОНӨААТҮГ (2013-2020) он
- Хан-Уул дүүргийн Газар зохион байгуулалтын алба (2013-2020) он
- Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэс (2002-2020) он
- Хан-Уул дүүргийн 118 дугаар сургууль (2011-2020) он
- Хан-Уул дүүргийн 134 дүгээр цэцэрлэг (2013-2020) он
- Хан-Уул дүүргийн 189 дүгээр цэцэрлэг (2012-2020) он
- Хан-Уул дүүргийн 190 дугаар цэцэрлэг (2012-2020) он

Төлөвлөгөөт бус өмнө оны 2 байгууллага: Татварын хэлтэс (2010-2018) он, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэс (2010-2018) оны нийт 16 байгууллагад мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөг тогтмол өгч, данс бүртгэлийг хянан, стандартыг мөрдүүлэн ажиллаж байна.

Сургалт, мэргэжил арга зүй: Төрийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагууд болон Тамгын газрын албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах ажлын хүрээнд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 2022 оны нөхөн бүрдүүлэлт хийгдэх 16 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад “Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг эмхлэн цэгцлэх, цаасан болон цахим нөхөн бүрдүүлэлт хийх ажлын арга зүй”, Нийслэлийн Архивын газартай хамтран “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам” сэдэвт сургалтыг ЗДТГ-ын албан хаагчдад тус тус зохион байгуулсан. Нийт 105 ажилтан, албан хаагч хамрагдсан.

Засаг даргын Тамгын газрын 2021 онд үүссэн

- Засаг даргын захирамж “Б”-57 /1 боть, 70 хуудастай/
- Тамгын газрын даргын тушаал “Б”-397 /2 боть, 473 хуудастай/
- Тамгын даргын “А” тушаал-147 /2 боть, 278 хуудастай/
- Засаг даргын “А” захирамж-675 /6 боть 1476 хуудастай нийт 1276 захирамжлалын баримтыг сканердаж www.Arch.ulaanbaatar.mn системд шивж баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн, 1276 хадгаламжийн нэгжийн 2166 хуудас бүхий баримтад нягтлан шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадад 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан, хэлтэс албадаас баримтыг архивт хүлээн авч баяжилт хийгдэж байна. Нийт 715 хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авч, төрөлжүүлэн цэгцэлж, дугаарлан архивын шүүгээнд байрлуулаад байна.

№	Хэлтэс, алба	Байнга хадгалах	Түр хадгалах	70 жил
1	Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс	28	118	5
2	Санхүү, төрийн сангийн хэлтэс	56	228	
3	Хууль, эрх зүй, архивын хэлтэс	5	26	
4	Төлөвлөлт, гүйцэтгэл мониторингийн хэлтэс	9	5	
5	Нийгмийн хөгжлийн хэлтэс	5	30	
6	Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтэс	10	10	
7	Тохижилт, ногоон байгууламжийн гүйцэтгэл, хяналтын хэлтэс	-	4	
8	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	1	36	
9	Аж ахуй, өмчийн хэлтэс	8	112	14
10	Олон нийттэй харилцах алба	3	1	1
	Нийт	125	570	20

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 15.6.3 заасан дагуу 2006-2021 оны хүртэлх 3251 хадгаламжийн нэгжээс хугацаа дууссан 264 устгах баримтын тооллогыг нийт 2 удаа хийж ялгаж гүйцэтгэсэн.

Дүүргийн архивын баримтаас лавлагаа, хуулбар үнэн олгосон байдал:

Төрийн архиваас данс бүртгэлийн 5 хөмрөгийн баримтаас 2002-2007 оны Б тушаал, захирамж 7хн, Малын "А" дансны 3 хөмрөгийн баримтаас 8 иргэнд 1995-2018 оны 52 хадгаламжийн нэгжийн 176 хуудас архивын баримтаас лавлагаа, хуулбарыг олгосон ба байгууллага иргэдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлсэн.

Хуулбар үнэн, лавлагаа олгосон байдал:

№	Хуулбар олгосон баримтын төрөл	Хуулбар олгосон огноо	Хуулбар олгосон баримтын тоо	Хуудасны тоо
1	Захирамж /А/	2000-2022	19	40
2	Захирамж /Б/	2017-2021	24	24
3	Тушаал /А/	2002-2007	7	7
4	Тушаал Б	2004-2022	24	25
5	Малын А данс	1995-2018	52	176
6	Албан бичиг	2011-2022	23	40
7	Хамтран ажиллах гэрээ	2020-2021	4	14
8	Төлөвлөгөө, тайлан	2019-2022	13	229
9	СӨХ-ын үйл ажиллагаатай холбогдох баримт бичиг	2006-2020	9	110
10	Б маягт	1997-2008	3	3
	Нийт		178	668

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/633 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт, БАҮАНЖ-ын 7.5 дугаар зүйлийн 7.5.4, 7.6-7.8, 7.12-т заасны дагуу ажлаас чөлөөлөгдөж буй албан хаагчдын Албан хэрэг хөтлөлтийн шатанд хөтлөгдөж буй цаасан суурьт болон цахим баримт /компьютер дахь мэдээлэл, файлууд/-д, архивын хадгаламжийн нэгжид тооллого хийж, актаар хүлээн авч ажиллаж байна. 2022 оны хагас жилийн байдлаар нийт 52 албан хаагчдын ажлыг хүлээлцээд байна.

Архиваас дотооддоо түр олгосон баримт: Дүүргийн архиваас дотооддоо 197 баримтыг түр ашиглуулсан ба 178 баримтаас лавлагаа хуулбарыг олгосон байна.

Хөмрөг үүсгэгч байгууллагын захирамжлалын баримт бичгийн цахим нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах ажлын хүрээнд нийслэлийн Засаг даргын 2013 оны А/452 дугаар захирамж буюу "Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх" ажлын хүрээнд, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар цахим нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөг батлуулан, дүүргийн харьяа 96 байгууллагын 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн 177 хадгаламжийн нэгжийн, 9335 баримтын, 14837 хуудас захирамжлалын баримтаар цахим нөхөн бүрдүүлэлт, батлан шалгалтын ажлыг хийж гүйцэтгэн нийслэлийн Архивын газарт 2021 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 11/817 дугаар албан бичгээр биелэлтийг хүргүүлсэн.

ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН:

"Засаг даргын зөвлөлийн хурал: Засаг даргын зөвлөлийн хурлыг 2022 оны эхний хагас жилийн байдлаар 20 удаа зохион байгуулж, 141 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн бөгөөд 85 үүрэг даалгавар өгөгдөж, хэрэгжилт 75 хувьтай байна. Хурлаас гаргасан шийдвэр хэрэгжилтийг цаг алдалгүй холбогдох хэлтэс, албадад хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан.

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 13 удаа зохион байгуулагдан, нийт 112 үүрэг даалгавар өгөгдөж, 87.4%-тай хэрэгжсэн. Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг

даалгаврын хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн батлуулж, хугацаанд нь тайлагнан ажилласан.

Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн: Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар 20 удаа зохион байгуулан, нийт 53 үүрэг даалгавар өгөгдөж, 91%-тай хэрэгжсэн.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн: Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг 2022 оны эхний хагас жилд 9 удаа зохион байгуулж, 82 үүрэг даалгавар өгөгдөн 88.9 %-ийн биелэлттэй хэрэгжсэн байна.

Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөн: Хороодын Засаг дарга нарын Шуурхай зөвлөгөөнийг 18 удаа цахимаар зохион байгуулж, 198 үүрэг даалгавар өгөгдсөн нь 90 %-тай хэрэгжсэн.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Захиргааны актын эрх зүйн үндэслэлийг хянан, биелэлтийг тооцох: Дүүргийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гаргасан Засаг даргын 361 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 131 тушаалын эрх зүйн үндэслэлийг хууль, тогтоомжид нийцүүлэн хянаж зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Эхний хагас жилд дүүргийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан 105 захирамжийн хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэсэн. Биелэлтийн дундаж 88.7%

Гэрээний эрх зүйн үндэслэлийг хянах, бүртгэлжүүлэх чиглэлээр: Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, тасгаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 306 гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж бүртгэлжүүлсэн.

№	Гэрээний индекс	Хэлтэс	Тоо
1	4/01	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	4
2	5/01	Санхүү, төрийн сангийн хэлтэс	10
3	6/01	Төлөвлөлт, гүйцэтгэл, мониторингийн хэлтэс	6
4	7/01	Нийгмийн хөгжлийн хэлтэс	36
5	8/01	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	13
6	9/01	Тохижилт, ногоон байгууламжийн гүйцэтгэлийн хяналтын хэлтэс	11
7	9/01	Хог орчны бохирдол зохицуулалтын хэлтэс	29
8	10/01	Цэргийн штаб	10
9	11/01	Хууль, эрх зүй, архивын хэлтэс	0
10	12/01	Аж ахуй, өмчийн хэлтэс	117
11	13/01	Олон нийттэй харилцах алба	34
12	ОК/01	Шуурхай хариу арга хэмжээний баг	4
13	ХО	Хөрөнгө оруулалт	32
		НИЙТ	306

Шүүхэд төлөөлөх, хууль хяналтын байгууллагатай харилцах чиглэлээр: Захиргааны хэргийн шүүхэд 16, иргэний хэргийн шүүхэд 1, цагдаагийн байгууллагад 1 нийт 18 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлийн үндсэн дээр оролцсон.

Үүнээс анхан шатны шүүхийн 13, давж заалдах шатны шүүхийн 7, дээд шатны шүүхийн 1 нийт 21 хуралдаанд цахимаар болон танхимаар оролцсон.

- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж гэрээ байгуулахыг даалгасан 2,
- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 6

Нийт хэрэг, маргааны тоо-18

Он дамжсан-16

Тайлант хугацаанд гардсан нэхэмжлэл-4

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон тоо-4

Нийт оролцсон шүүх хуралдаан-21

Анхан шатны-13

Давж заалдах шатны-7

Хяналтын шат-1

Шүүхийн үзлэг/ Газар, баримт/-21

Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр: Хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг тайлбарлах, эрх зүйн сургалтыг иргэд, албан хаагчдад зохион байгуулах, иргэдэд хуулийн чиглэлээр лавлагаа, зөвлөгөө өгөх ажлын хүрээнд эрх зүйн сургалтыг 5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 241 иргэн, албан хаагчийг хамруулж, 1759 ширхэг гарын авлага тараан, 850.000 төгрөгийн төсөв зарцуулсан.

Хуульчдын холбоотой хамтран Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн талаарх сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн талаарх сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж 140 албан хаагч хамрагдсан.



Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхтэй хамтран “Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдал” сэдэвт сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж 35 иргэн хамрагдсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран Цахим гарын үсгийн тухай хуулийн сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж 35 албан хаагч хамрагдсан.

Хуульчдын холбоотой хамтран Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ бусад хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж 31 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, гарын авлага тараасан.



Шагнал урамшуулал: 2022 онд төрийн болон төрийн бус байгууллага боловсрол, эрчим хүч, хөнгөн үйлдвэрийн салбарт үр бүтээлтэй олон жил ажилласан 476 иргэнийг төрийн дээд одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлсэн материалыг хянан шалгаж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 04,11 дүгээр тогтоолоор хэлэлцүүлэн батлуулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Алдарт эхийн 1, 2 дугаар одон авах болзол хангасан 803 эхчүүдийн 31 боть архивын баримтыг НЗДТГ-т хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр зарлигаар дүүргийн 803 эхчүүд “Алдарт эх”- I, II зэргийн одонгоор 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гардан авсан.



Нутаг дэвсгэрийн байгууллага болон иргэдийг байгууллагын шагналаар шагнуулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан цар тахлын хүнд үед ачааны хүндийг үүрэлцэж, иргэдийнхээ эрүүл мэндийг сахин хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулсан Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг, дүүргийн Эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгийн 18 сувилагчийг Хан-Уул дүүргийн “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ээр шагнасан.



ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон бусад тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан төрийн болон төрийн бус байгууллагын нийт 51 ажилтан, албан хаагч, иргэдийг дүүргийн “Хүндэт тэмдэг”-ээр тус тус шагналаа.

Гадаадын зочид төлөөлөгчидтэй холбоо тогтоож, хамтын ажиллагааны хүрээнд санал хүргүүлж, хоёр талын хамтын ажиллагааны уулзалт зохион байгуулах ажлын хүрээнд:

Хан-Уул дүүрэг болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Гуанжин дүүрэгтэй хамтын ажиллагааг сэргээх чиглэлээр хоёр талын хамтын ажиллагааг идэвхжүүлэх хүсэлтэй байгааг илэрхийлсэн албан бичгийг хүргүүлсэн.

Хан-Уул дүүрэг болон Болгар Улсын Изгрев дүүрэгтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр албан бичгийг хүргүүлж, 2022 оны 06 дугаар сарын 04-ний өдөр тус дүүргийн Засаг дарга болон бусад холбогдох албаныхан Хан-Уул дүүрэгт албан айлчлал хийж, Болгар, Монголын харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт өргөжин хөгжихөд түлхэц болсон айлчлал болж өндөрлөсөн.



Хан-Уул дүүргийн зүгээс Бүгд Найрамдах Солонгос Улсын Хаман сумтай хамтын ажиллагаа өргөжүүлэх хүсэлтэй байгааг илэрхийлсэн албан бичгээр тус тус хүргүүлсэн

ХОРООДТОЙ ХОЛБООТОЙ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

“Шилдэг хороо-Хэсгийн ахлагч нарын шилдэг баг” шалгаруулах болзолт уралдаан:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/468 дугаар захирамжийн дагуу 2022 оны “Шилдэг хороо-Хэсгийн ахлагч нарын шилдэг баг” шалгаруулах болзолт уралдааны хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/46 дугаар тушаалаар Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Н.Сарангуа, Аж ахуй өмчийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Мөнхгэрэл, Ногоон байгууламжийн гүйцэтгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн Э.Баатарсүрэн, Хороо хариуцсан мэргэжилтэн Г.Одноран, Багахангай дүүргийн


Хороо, шагнал хариуцсан мэргэжилтэн Ж.Наранцэцэг нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдсон. Ажлын хэсэг 05 дугаар сарын 26-аас 06 дугаар сарын 15-ны өдрүүдэд удирдамжид заасан Нийслэлийн 9 дүүргийн хуваарьт 32 хороодод зөвлөгөө, мэдээлэл өгч, туршлага солилцон ажиллаж байна.

Уг ажлын хүрээнд бусад дүүргүүдийн хороодын хэрэгжүүлж буй сайн туршлагыг судлах, хорооны байрны тохижилт болон үйл ажиллагааны зохион байгуулалт, төрийн үйлчилгээний цахим шилжилт, нутаг дэвсгэрийн хүрээнд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудыг судлан цаашид Хан-Уул дүүргийн нийт хороодын үйл ажиллагааг сайжруулахад чиглэн ажиллалаа.

Мөн тус хороодын судалгаа, мэдээллийн баяжилтын чанар, боловсруулах арга зүй, баримт бичиг боловсруулалтын стандарт, ERP болон www.manaikhoroo.mn системийн өргөдөл гомдол, зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийг хөтлөх арга зүй зэрэг шилдэг хорооны 105, хэсгийн ахлагчдын багийн 35, нийт 140 шалгуур үзүүлэлтүүдээс шаардлагатай үзүүлэлтийн дагуу зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Ажлын хэсгийн зөвлөн тусалсан хороодод гарч буй нийтлэг асуудлуудаас дурдвал:

- Хүн амын судалгааны баяжилт дутуу хийгдсэн. Иргэдийн мэдээлэл 2020, 2021 оны байдлаар байгаа боловч судалгаа хийгдсэн хугацааг 2022 оноор тайлагнасан.
- 1 хэсгийн ахлагчийн хариуцах өрхийн тоо 300-аас давсан.
- ХАӨМС-ийн алдаа их. Энэ нь хороодын албан хаагчдын тогтвор суурьшил муу, туршлагагүй шинэ ажилтны алдаатай бүртгэл, уг алдаануудыг засаагүйгээс удаан хугацаанд хуримтлагдсан гэх мэт. (Зарим хороодод 200-500 хүртэл хуудас алдаатай.)
- ERP системд өргөдөл, гомдлын бүртгэл бага хийгддэг, зарим хороодод огт хийгддэггүй.
- www.manaikhoroo.mn системд бүртгэсэн сайн туршлага болон зөрчлийн бүртгэл байхгүй. Бүртгэсэн зөрчлүүдийг шийдэж, арилгасан ч систем дэх шийдвэрлэлтийг бүртгэж хаагаагүй, дүүргийнхээ хариуцсан хэлтэст хандах талаар мэдэхгүй байх зэрэг нийтлэг асуудлуудад чиглэсэн арга зүй, зөвлөгөөг түлхүү өгсөн.



НЗДТГ-ын ХНХТ-өөс хэрэгжүүлэгч агентлаг, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газруудын албан хаагчдын дунд зохион байгуулсан “Мэтгэлцээн”-ий 2 дахь удаагийн тэмцээний техникийн зөвлөгөөнд оролцож, Хууль эрх зүй, архивын хэлтсийн Эрх зүйн маргаан шийдвэрлэлт хариуцсан мэргэжилтэн Б.Очир, Нийгмийн хөгжлийн хэлтсийн Төрийн бус болон олон улсын байгууллага, хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Баярбат, Хог орчны бохирдол зохицуулалтын хэлтсийн Хог хаягдлын менежмент, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн Б.Эрдэнэзул нарын бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлэн оролцсон.

НЗДТГ, НҮБ-ын ОУШХБ хамтран зохион байгуулсан “Дотоод шилжих хөдөлгөөнийг ойлгож удирдахад төрийн үйлчилгээ чухал болох нь” сэдэвт сургалтад 5-р сарын 12, 17-ны өдрүүдэд 2 ээлжээр хороодын албан хаагчдыг хамруулан Хороо хариуцсан мэргэжилтнүүд ХУД-ийн Соёлын ордонтой хамтран сургалтын заал, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж оролцсон. Үүнд:

- Зохион байгуулагч- 25,
- Хэсгийн ахлагч- 14,
- Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн- 20,
- Хөгжлийн нийгмийн ажилтан- 19,
- Улсын бүртгэгч- 17, нийт 95 албан хаагчийг хамруулав.



САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Дүүргийн төсвийн орлогын талаар: 2022 оны эхний 5 дугаар сарын төлөвлөгөөгөөр орон нутгийн төсөвт 93,116.9 сая төгрөг, гүйцэтгэл 85,054.5 сая төгрөг, биелэлт 91.3%-тай байна.

➤ Дүүргийн 2022 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг нийт 13-н дансны 1-5 сарын орлого болон зарлагын гүйлгээгээр тулган хянаж, Татварын хэлтсийн орлогын эдийн засагчтай тооцоо нийлэн дүүргийн Нэгдсэн Санхүүгийн тайланд амжилттай нэгтгэгдлээ. Орон нутгийн 2022 оны батлагдсан төсвийн орлого болон зарлагын сар, улирлын хуваарийг татварын орлогын ангиллын дагуу Татварын хэлтсийн тооцоо, саналд үндэслэн орлогын нэр төрөл бүрээр төлөвлөгөөг боловсруулж Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/53 дугаар захирамжаар батлуулан Фрийбаланс програмд шивж оруулан орон нутгийн санхүүжилтийг саадгүй явуулах нөхцөл бололцоог ханган ажиллалаа. Орон нутгийн төсвийн орлого болон зарлагын гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж орлогын давалт, тасралтын мэдээллийг 7 хоног бүр удирдлагад тогтмол танилцуулсан.

➤ Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавин, нийслэл, дүүргийн эдийн засаг нийгмийн зорилтыг биелүүлэх үүднээс улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогыг жилийн эхнээс жигд ханган биелүүлэх тухай дүүргийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/03 дугаар захирамжийн төслийг боловсруулан батлуулж, холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн. Захирамжийн дагуу төлөвлөгөө тасарсан татварын орлогуудын талаар хийх ажил, анхаарах асуудлын талаар Татварын хэлтэстэй хамтран ажиллав.

➤ 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлаас бусад зардлыг батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хэмнэлт гаргах гэсний дагуу жижиг мөнгөн сангийн зарцуулах эрх нээгээгүй тул ЖМСан олгоогүй болно.

➤ Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны орлого, даатгалын төлбөр, нэр данс зөрүүгийн болон бусад орлого, нэмэлт санхүүжилт, улсын төсвийн байгууллагуудын санхүүжилт, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогыг эдийн засгийн ангилал, хөтөлбөр зориулалт тус бүрээр задалж нээх гүйлгээг тухай бүрд хийж гүйцэтгэсэн.

Нийслэлд төвлөрүүлэх орлогын талаар: Дүүргийн ерөнхий орлогын дансанд татварын нэр төрлөөр 84,973.7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж нийслэлд 52,112.8 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэв.

Улсын Тэмдэгтийн хураамж буцаан олгох талаар: Төсвийн “тэг” үлдэгдэлтэй данснаас гарах зардлын гүйлгээний баримтуудыг нэг бүрчлэн тулган хянан 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Улсын тэмдэгтийн хураамжийн буцаалтаар нийт 363.2 сая, 1223 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгов. Татварын хэлтсээс ирүүлсэн албан бичиг, жагсаалтыг улсын тэмдэгтийн хураамжийн 100200100941 тоот дансны хуулга, шүүхийн захирамж, иргэн, аж ахуйн нэгжийн өргөдөл, иргэний үнэмлэх, гэрчилгээний хуулбар, мөнгө тушаасан баримт, татварын тодорхойлолт зэргийг нарийвчлан тулгаж, төлбөрийн хүсэлт бичиж ерөнхий нягтлан бодогч, хэлтсийн даргаар батлуулан орлого бууруулах гүйлгээ хийв. Мөн нэр данс зөрүү болон залруулгын 306.4 сая төгрөгийн гүйлгээг татварын хэлтсээс ирүүлсэн албан бичиг, жагсаалт, дансны хуулга зэрэг үндсэн баримтыг үндэслэн олгосон.

Бүртгэлийн үйлчилгээний талаар: Хан-Уул дүүрэгт харьяалагдах аж ахуйн нэгж, байгууллагуудыг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох


бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд, Зөрчил шалган шийдвэрлэх, Зөрчлийн тухай хууль, Сангийн сайдын 46-р тушаалыг баримтлан Тайлан баланс, Орлого үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланг Сангийн яамны шинэчилсэн “E-Balance” нэгтгэлийн программд бүрэн шивүүлж илгээсэн тайланг заасан хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулан, нэгтгэлийг заавар журмын дагуу тайлагнаж байна.

Нэгтгэлийн программд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан өгвөл зохих нийт 16030 аж ахуйн нэгж, байгууллагаас 12972 тайлан буюу 80,9%-ийг цахим системээр ирүүлсэн байна. Үүнээс 11355 байгууллага буюу 70,8%-ийг баталгаажуулж, 1617 байгууллагын алдаатай болон аудитын байгууллагын нэрийн баталгаажуулалт хийгдээгүй тайланг буцаасан. 2490 аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.



Сар бүр Прокурорын газарт Шийтгэл оногдуулалтын мэдээг хүргүүлж байна. Шинээр ААНБ бүртгэхэд шаардлагатай материал, тайлан хүлээн авалттай холбоотой мэдээллийг тогтмол хүргэж байна. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 37 аж ахуйн нэгж, байгууллагуудын нягтлан бодогч нарт шийтгэл оногдуулж нийт 14.800.000 төгрөгийг төсөвт төвлөрүүлэн, зөрчлийг арилгуулан ажилласан.

2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛТ



Төсвийн тухай хуулийн 54.2-т “ТЭЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, төсөл, сан, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн тайланд хамруулна” гэж заасны дагуу Засгийн Газрын санхүүгийн нэгтгэлийн Э-ТАЙЛАН системд дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагддаг төсөвт 82 байгууллагын 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт, касс харилцахын нэгтгэл, нэмэлт санхүүжилтийн тооцоог тулган Сангийн Яамны нэгтгэлийн Э-тайланд байгууллага бүрээр тулган шалгаж хүлээн авч дүүргийн нэгдсэн тайланг Нийслэл дэх

Төрийн аудитын газраар шалгуулж “Зөрчилгүй дүгнэлт” авсан. Мөн 2022 оны 1 дүгээр улирлын төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгаж хүлээн авсан. Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудад үйл ажиллагааны үр ашигт НТАГ аудитын 8 ОНӨААТҮГ хамрагдав.

САНХҮҮЖИЛТ ОЛГОСОН ТАЛААР:

Орон нутгийн байгууллагуудад олгосон санхүүжилт: 2022 оны дүүргийн орон нутгийн 33 байгууллага, хөтөлбөр, зардлын төсвийн сар, улирлын хуваарийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төсвийн дагуу боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж тухайн байгууллагад хүргүүлж, хяналт тавьж байна. Төсвийн орлого, зарлагын жилийн болон сар, улирлын хуваарийг төсвийн төлөвлөлтийн Фискал програмд байгууллага бүрээр оруулан нэгтгэж, нийслэлийн ЗДТГ-ын СТСХ-т илгээн байгууллагуудын төсвийн зарцуулах эрхийг нээлгэж зарлагын гүйлгээ хийх нөхцөлийг ханган 01-06 дугаар саруудын санхүүжилтийг хуваарилсан. Тайлант хугацаанд ИТХ, ЗДТГ, Татварын хэлтэс, БТСХороо, ГБХЗХХ, Цагдаагийн газар, ОБХ, ОБХ-ийн 113-р анги, зарим ТЗШ-ийн байгууллагуудын нийт /өссөн дүнгээр/ 711.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрхийг нээж, зардлын данснуудад хуваарилав.

Нийгмийн салбарын байгууллагуудад олгосон санхүүжилт: Нийгмийн салбарын байгууллагуудын үйлчилгээний ажилчдын цалингийн 7,615.4 сая төгрөг, байр ашиглалтын тогтмол зардлын 7,226.4 сая төгрөгийн батлагдсан төсвийг байгууллага тус бүрээр төсвийн сар, улирлын хуваарийг хийж батлуулан, зарцуулах эрхийг хуваарийн дагуу нээн ажилласан. Эхний 5 сарын байдлаар 6,444.8 сая төгрөгийн ТҮ-1-3 шатлалын албан хаагчдын цалин болон тогтмол зардлыг төсвийн хуваариар сар бүр хийж, батлуулан зарцуулах эрхийг татуулан, санхүүжилтийг хугацаанд нь олгуулан ажилласан.

Хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн талаар: Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжих 47,098.6 сая төгрөгийн 90 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс 2021-2022 онд дамжин хэрэгжих 3 төсөл арга хэмжээний 4,643.8 сая төгрөг, 2022 онд шинээр хэрэгжих 20 төсөл арга хэмжээний 11,618.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021-2022 он дамжин хэрэгжих 1,446.2 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, 2022 онд хэрэгжих 1,263.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ нийт 2,709.2 сая төгрөг батлагдсанаас 2 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж хамгийн сайн үнэлэгдсэн төсөл арга хэмжээг хянаж 784.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан.

2020-2021 он дамжин хэрэгжих 3 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 50,2 сая төгрөг, 4 төсөл арга хэмжээнд 1,432.5 сая төгрөгийн явц, 2022 онд хэрэгжиж буй 2 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 1,222.0 сая төгрөг, 5 төсөл хэмжээний гүйцэтгэлээр 1,727.0 сая төгрөг нийт 4,431.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Төрийн сангийн үйлчилгээний талаар: Төрийн сан банк нь харилцагч төсөвт байгууллагуудын дансны нэгдсэн жагсаалт гаргаж, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдэд хуваарилан, Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 2022 оны 1 дүгээр сарын 03-ны өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 14,460 ширхэг 142,925.6 сая төгрөгийн төлбөр тооцоог хянан баталгаажуулж ажилласан.

Төсөвт байгууллагуудын гарын үсгийг баталгаат маягтын дагуу 10 төсвийн шууд захирагч, 13 нягтлан бодогчоос журмын дагуу шинэчлэн авсан. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд байгууллагыг ажлын 8 цагт багтаан бэлтгэн нийлүүлэгчээр 89 байгууллага болон хувь хүн бүртгэсэн.

Дүүргийн харилцагч төсөвт байгууллагуудаас Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн 7100-1112 дугаарын дуудлагыг хүлээн авч зөвлөгөө өгч ажиллаж байна. Эрхийн бүртгэлийн сан болон payroll.gov.mn программууд дээр харилцагч төсөвт байгууллагуудад заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.


Сургалт, тайлан мэдээний талаар: Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд орон нутгийн байгууллагууд 16, орон нутгийн төсвийн цэцэрлэг 30, сургууль 21, нийт 67 байгууллагын мэдээ нэгтгэгдэн, орон нутгийн төсвийн цэцэрлэг, сургууль болон орон нутгийн байгууллагуудын 01-05 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Сангийн яамны програмтай тулган баталгаажуулан ажилласан.

Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл гэсэн нийт 3 төрлийн мэдээг 1-6 дугаар саруудад нийт 18 удаагийн давталтаар хуулийн хугацаанд нь мэдээлж ажилласан. Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Дүүргийн статистикийн хэлтэст Дүүргийн орлого, Төсвийн байгууллагуудын зарлагын мэдээ, бусад холбогдох мэдээллийг сар бүр нэгтгэн гаргаж, хүргүүлэн ажиллалаа.


АЖ АХУЙ, ӨМЧ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Санхүүгийн чиглэлээр: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангасан харилцахын гүйлгээнүүдийг хянаж баталгаажуулсан.


Засаг даргын Тамгын газрын үндсэн дансаар 1153 ширхэг баримтаар 4,194,100,968.20 төгрөгийн гүйлгээ хийсэн.



Дүүргийн хөрөнгө оруулалтын харилцахын дансаар 33 компанийн 4,860,815,657 төгрөгийн санхүүжилтийг хянан баталгаажуулсан.




Нэмэлт санхүүжилтийн харилцахын дансны 3 ширхэг баримтаар 5,221,871.25 төгрөгийн гүйлгээг хянасан.



Санхүүгийн анхан шатны баримтад тулгуурлан бараа материалын 411,297 ширхэг баримтаар 621,693,717 төгрөгийн орлогын гүйлгээ хянасан.


Бараа материал орлого /төгрөгөөр/



Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, НББОУС-ын дагуу анхан шатны баримт болон холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн 355,886,631 төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж ажилласан. Үүнээс:

- Нийслэлийн хөрөнгө оруулалтаар -213,662,731 төгрөг
- Дүүргийн төсвийн хөрөнгөөр -142,223,900 төгрөг

Үндсэн хөрөнгийн орлого /төгрөгөөр/




2022 оны 1-5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуулийн хугацаанд нь Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН САРЫН МЭДЭЭ

	6,729,268,730.0				
	5,703,159,830.0				
	4,656,810,930.0				
	3,039,833,500.0				
	616,082,500.0				
	1-р сард	2-р сард	3-р сард	4-р сард	5-р сард
■ Гүйцэтгэл	616,082,500.0	3,039,833,500	4,656,810,930	5,703,159,830	6,729,268,730

Засаг даргын Тамгын газрын болон 21 хорооны нийт 154 төрийн албан хаагч, хороодын 204 хэсгийн ахлагчийн цалин, 7 ажилтны ээлжийн амралтыг бодож олгосон.

ЦАЛИН ХӨЛС, НЭМЭГДЭЛ УРАМШУУЛАЛ



Шилэн дансны мэдээллийн сайтад 2022 оны 1-5 сарын нийт 65 мэдээг хуулийн хугацаанд нь шинэчлэн байршуулсан.

Бараа материалын эхний хагас жилийн байдлаар нийт 1239 баримтаар 408.627 ширхэг 593.626.927 төгрөгийн зарлагын гүйлгээг шаардах хуудасны дагуу хянасан.

- 2022 оны 1-р улирлын Хөрөнгө оруулалтын барьцаа сан, Орон нутгийн хөгжлийн сан, Хөрөнгө оруулалтын сан, Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь Санхүү төрийн сангийн хэлтэст тушааж, баталгаажуулсан.
- Засаг даргын Тамгын газар болон хороодын нийт 17 албан хаагчийн эд хөрөнгийг хууль журмын дагуу хүлээлцэж, гарын үсэг зурж баталгаажуулсан.
- Тамгын газар, дэргэдэх хэлтэс албад болон шуурхай штабын жолооч нарын замын хуудсыг үндэслэн 95,100,000 төгрөгийн шатахууны тооцоог бодож хяналт тавьсан.
- Засаг даргын Тамгын газрын 2022 оны А/43 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг эд хөрөнгийн хагас жилийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан. Нийт 11 хэлтэс албад болон 21 хорооны албан хаагчдын хөрөнгө тоолсон.
- 2022 оны 1 дүгээр улирлын ХХОАТ тайланг хугацаанд нь илгээж, автомашины татвар болон бусад татвар хураамжуудыг цаг тухай бүр төлөлт хийн татварын өр үүсгэлгүй ажилласан.

Өмч бүртгэлийн чиглэлээр: 2022 оны 1 дүгээр сард түрээсийн байртай 3,15,17,19,20,21 дүгээр хороодын түрээс, цахилгаан, дулаан, усны гэрээнүүдийг холбогдох байгууллагуудтай нь

шинэчлэн байгуулсан. Мөн 4,5,6,7,8,9,16,12,14, хороодын бохирын гэрээг шинэчлэн байгуулсан. 12-р хорооны ӨЭМТ, халуун усны барилгын дулааны гэрээг шинэчлэн байгуулсан. Нийт 15 аж, ахуй нэгжтэй Тамгын газрын хороодын байрны ашиглалтын зардлын гэрээг байгуулж, хамтран ажиллаж байна. 21 хорооны нийт 170,010,533 төгрөгийн ашиглалтын зардлын тооцоо хийсэн байна

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг 2022 оны улсын үзлэг тооллогыг зохион байгуулах дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/218 дугаар захирамжийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын даргын 2022.04.22-ны өдрийн А/36 дугаар тушаалыг гаргасан. Засаг даргын Тамгын газрын болон нийтийн эзэмшлийн хөрөнгийг тоолох ажлын хэсэг болон ажлын төлөвлөгөөг батлуулсан. Улсын үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын тамгын газрын өмчид бүртгэлтэй эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал хэмжээ тогтоох, чанар байдал, хадгалалт, хамгаалалт, үнэлгээ, бүртгэлд үнэлгээ өгөх, цахим сан бүрдүүлэх, эзэмшиж буй газрын хэмжээ, баталгаажилт хийх зэрэг бүх хөрөнгийг тоолж баталгаажуулаад байна. Үүнд Төх-2 маягтаар 34 газар, Төх-6 маягтаар 14 авто тээврийн хэрэгсэл Төх-9 маягтаар 14 худаг, Тө-3 маягтаар 6 биет бус хөрөнгө болох программ хангамж, Тө-13,1 маягтаар 73 авто зам, Тө-13,2 маягтаар 18 гүүр, Тө 5 маягтаар 11 түүх соёлын дурсгалт зүйлс, Төх-4 маягтаар 1588 нийтийн эзэмшлийн хөрөнгө, Төх-5 маягтаар 918 машин тоног төхөөрөмж, Төх-7 маягтаар 1043 ширхэг тавилга эд хогшлыг тоолж, өмчийн программд бүртгээд байна. Нийт 183.377.576.651.066 төгрөгийн өмч хөрөнгийг тоолж, программд шивж оруулсан. Одоогийн байдлаар тооллогын явц 80 хувьтай явагдаж байна.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/23 дугаар тушаалаар хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж байна. Нийт 21 хорооны өмч эд хөрөнгийг тоолсон. Мөн Засаг даргын дэргэдэх 5 хэлтэс, албадын 14 төрлийн өмч хөрөнгийг тоолоод байна. Өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах талаар зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан. Нийслэлийн Өмчийн харилцааны газартай хамтарсан ажлын хэсэгт орж дүүргийн төрийн болон орон нутгийн өмчийн 90 байгууллагын 2021 оны өмчийн гэрээг дүгнэсэн. Засаг даргын Тамгын газрын 2021 оны Өмчийн гэрээг бүрэн хангалттай буюу 90 хувьтай дүгнүүлсэн.

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:


Эрүүл мэнд: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн Яармаг дахь Салбар амбулаторийн нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд хамаарахаас бусад чиг үүргийг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн Нэгдсэн эмнэлэгт шилжүүлсэн.

Дээрх тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн Яармаг дахь Салбар амбулаторит ажиллаж, тушаал шийдвэрийг танилцуулан үүрэг чиглэл өгсөн.

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол улсын хөгжлийн бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хүрээнд “Хан-Уул дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар /ОНӨТҮГ/-ыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 01 дүгээр тогтоолоор байгуулж, дүрмийг батлуулсан.

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв болон Нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах хорооны хурлыг зохион байгуулж, Олон нийтийн төлөөлөл сонгон шалгаруулах зарыг боловсруулан www.khanuul.mn сайтад байршуулж, ажлын хэсэг 2 эмнэлгийн олон нийтийн төлөөлөлд тус бүр 3 төрийн бус байгууллагын төлөөллийг сонгон шалгаруулсан

Сүрьеэгийн эрсдэлт бүлгийн иргэдийн дунд сүрьеэ өвчнийг илрүүлэх үзлэг шинжилгээг “Глобал” сан, МӨАУХ, дүүргийн сүрьеэгийн диспансер, хороод, ӨЭМТ-үүд хамтран зохион байгуулсан. Сүрьеэгийн өвчнийг эрт илрүүлэх үзлэг шинжилгээг 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 21, 16, 12, 14-р хорооны эрсдэлт бүлгийн 4428 иргэнийг үзлэгт хамруулсан.



Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан нийт сувилагч нарт мэндчилгээ дэвшүүлж, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 17 сувилагчийг Хан-Уул дүүргийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнаж урамшуулсан.



“Хүүхдийн өвчний цогц менежмент” сургалтад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн залуу 30 эмч, Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах, эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх, мэдлэг арга зүйгээр хангах сургалтад Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 28 эмчийг хамруулсан.

Олон улсын болон төрийн бус байгууллагын чиглэлээр: Монголын Улаан загалмай нийгэмлэг, “Скай Ресорт” ХХК-тай хамтран зохион байгуулсан “Цэвэр агаар-Эрүүл инээмсэглэл” арга хэмжээнд 63 дугаар тусгай сургуулийн сурагчид болон зорилтот өрхийн 90 хүүхдийг хамруулсан.



Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Тайваний хүүхэд, гэр бүлийг дэмжих сангийн “Гэр хотхон” салбар 2022 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн, нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан.

“Гүүд Нэйборс” олон улсын төрийн бус байгууллагын Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтран хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад тус дүүргийн 4, 5, 6, 8 дугаар хорооны хамтарсан багийн 18 гишүүдийг хамрагдсан.

Боловсролын чиглэлээр: Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/70 дугаар захирамжаар Боловсролын байгууллагын ёс зүйн зөвлөлийг шинэчилж, сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнуудтай холбоотой 5 асуудлыг шийдвэрлэсэн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны А/654 дүгээр захирамжаар байгуулагдсан сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус хяналтын зөвлөл 2022 онд төрийн өмчийн 19 сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавьж ажилласан.

Хүүхэд бүрд сургуулийн өмнөх боловсрол олгох боломж, шийдэл ажлын хүрээнд сургуулийн өмнөх боловсролд хамрагдвал зохих 21390 хүүхдийн судалгааг шинэчлэн гаргасан. Судалгаанд суурилан нэмэгдүүлэх шаардлагатай цэцэрлэгүүдийн байршлын судалгааг гаргаж, Боловсролын ерөнхий газарт хүргүүлсэн.

Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 280 хүүхдийн ортой 290 дүгээр цэцэрлэг, 300 дугаар цэцэрлэг, 20 дугаар хороонд халамжийн 28 дугаар цэцэрлэгийн салбар, УБЦТС ТӨХК-ийн албан хаагчдын хүүхдийн 50 ортой “Чамбай хүү” цэцэрлэгийг тус тус нээсэн.

Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан алслагдсан хороодын 26, 59, 114, 130 дугаар сургуулийн удирдлагуудтай уулзан зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэн ажилласан.



Сургуулийн өмнөх насны хүүхэд багачуудыг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний мэдлэг дадлага олгох, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор “Замын хөдөлгөөний цагаан толгой-2022” тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан. Тус тэмцээнд 18 цэцэрлэгийн 204 хүүхэд оролцсон.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр: Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ахмадаа дээдэлье” дэд хөтөлбөрийн хүрээнд 17 дугаар жарны “Буян үйлдэгч” хэмээх Усан бар жилийн сар шинийн баярыг угтан Хан-Уул дүүргийн Засаг даргын гарын бэлгийг 2200 ахмад настанд олгосон. Монгол Улсын Ерөнхийлөгчийн гарын бэлгийг 100 ба түүнээс дээш настай 11 ахмад настанд хүлээлгэн өгсөн.

Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны Улсын бүртгэгч Н.Энхтуул, 16 дугаар хорооны Улсын бүртгэгч Ж.Наранцэцэг нарт гэр олгож, батламжийг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр гардуулан өгсөн.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн А/251 дүгээр захирамжийн хүрээнд зорилтот 4 өрхөд гэр олгосон. Мөн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид “Нэг байгууллага-Нэг сайн үйлсийн аян”-д нэгдэж, 10 дугаар хорооны зорилтот 1 өрхөд гэр олгосон.

Хан-Уул дүүргийн 18 дугаар хороо, “Оргил” сургуулийн дэргэдэх “Оргил-Ивээл” сангаас 2022 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр тус дүүргийн 120 зорилтот өрхөд хүнсний тусламж олгосон.



Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Засаг даргын орлогч А.Амартүвшин, Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр нар 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж ажилтан албан хаагчидтай уулзсан. Уулзалтын үеэр Засаг даргын зүгээс хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээ цахимжсантай холбогдуулан иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, түргэн шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлж шаардлагатай зарим тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.



Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын үйл ажиллагаа: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/47 дугаар тушаалаар “Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн байгуулсан. Тус комисс нь 18-аас дээш насны иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 16 удаа хуралдаж, 1735 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоосон байна.

- Сунгасан-1314
- Шинээр орсон-263
- Цуцалсан- 158

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаа: Хан-Уул дүүргийн Засаг даргын 2017 оны А/129 дүгээр захирамжаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс”-ыг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус комисс нь 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, үнэлэх, тогтоох, нийгмийн амьдралд тэгш оролцох боломж, хүртээмжийг дээшлүүлэх, хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын салбар комисс 11 удаа хуралдаж нийт 302 хүүхдийн асаргаа халамжийн асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд: 91 хүүхдэд шинээр асаргаа тогтоон, 7 хүүхдийн байнгын асаргааг цуцлан хөгжлийн бэрхшээлтэй иргэн болохыг тогтоон, 15 хүүхдэд туслах хэрэгсэл олгуулан, хөгжил хамгаалал, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлж ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2022-2023 онд хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийг танилцуулах өдөрлөг, арга хэмжээг дүүргийн хэмжээнд 4 бүсэд хуваан зохион байгуулж, 950 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч төсөл, хөтөлбөрт хамрагдах 400 гаруй иргэний төслийг хүлээн авсан. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ы хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнуудад 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр сургалт зохион байгуулж, 78 аж ахуй нэгж байгууллагын 118 ажилтныг хамруулсан.



Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх “Осолгүй хамт олон” дарцгийг барилгын үйл ажиллагаа явуулж буй 90 аж ахуйн нэгжид аялуулж, 1300 орчим ажилтныг хамруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих эрхийг хангаж ажиллахыг үүрэг болгосон Хан-Уул дүүргийн Засаг даргын 07/115 дугаар албан мэдэгдэл, холбогдох барилгын стандарт, дүрэм журмын гарын авлага материалыг барилгын үйл ажиллагаа явуулж буй 50 ААН байгууллагад хүргэн ажилласан. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдэд зориулсан “Хүслийн жигүүр” үйл ажиллагааг 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан. Үйл ажиллагаанд 100 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхийн хамт оролцсон.



Гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр: Хүүхдийн эрхийн ахлах байцаагч, Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2022 оны ерөнхий төлөвлөгөө, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 01/82 дугаар чиглэл, Хүүхдийн тоглоомын талбайд тавигдах ерөнхий шаардлага MNS6751:2019 стандарт, Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүр, нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбайн бүрэн бүтэн байдал, хүүхдийг болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалт хийж, зөвлөмж өгч ажилласан.

Хяналт шалгалтыг төвийн /1, 2, 3, 11, 15, 17, 18, 19, 20-р хороо/ яармаг /4, 5, 6, 7, 8-р хороо/, нисэх /9, 10, 16, 21-р хороо/ алсын /10, 12, 13, 14-р хороо/ 4 бүсэд хуваан зохион байгуулсан ба Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтнүүд, хороодын нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарын хамт 2022 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан.

Хан-Уул дүүргийн 21 хорооны нутаг дэвсгэр дэх 288 тоглоомын талбайгаас 144 тоглоом, хэрэглэл нь ямар нэгэн эвдрэл гэмтэлтэй, хүүхдийн биед гэмтэл учруулж болзошгүй тогтоосон. Шалгалтын явцад тоглоом, хэрэглэлүүд хагархай, цуурсан, тоглоомуудын эрэг, боолт, бэхлэгээ суларсан, хийц хэсгүүд нь эвдэрсэн, хаалт хашлага ганхсан, гагнаас салсан, хурц үзүүртэй

хэрэгслүүд ихтэй, хүүхдийг унаж бэртэхээс хамгаалсан шалны зөөлөвч резингүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн ба цаашид засаж сайжруулах зөвлөмжийг нийт 268 сууц өмчлөгчдийн холбооны дарга, хороодын Засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд харьяалах сууц өмчлөгчдийн холбоодод зөвлөмжийг хүргүүлэн тоглоомын талбайн эвдрэл гэмтэлтэй 123 тоглоомыг засаж сайжруулсан.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан хүүхдийн тоглож, наадах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор "Хүүхдийн тоглоомын талбайг угааж цэвэрлэе, засаж сайжруулъя" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 21 хорооны сууц өмчлөгчдийн холбоод, иргэд, олон нийт харьяалах нутаг дэвсгэр дэх 265 хүүхдийн тоглоомын талбайг угааж цэвэрлэсэн.

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7 "21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулахыг хориглох", Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 2.1 "Хүүхдэд утаат тамхи татахыг санал болгосон, бэлэглэсэн, эсхүл утаат тамхи олж авах, хэрэглэхэд дэмжлэг үзүүлсэн" иргэн хуулийн этгээдийг торгох гэх заалтын дагуу дүүргийн хэмжээнд худалдаа үйлчилгээ эрхэлж буй хүнсний дэлгүүрүүдэд "Насанд хүрээгүй хүнд электрон тамхи болон утаат тамхи худалдан борлуулахгүй байх сануулга, стикерийг тараасан.

Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороонд байрлах "Алтан босго" академийн дотуур байранд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөн туслах ажлыг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хийж гүйцэтгэсэн.



Нийслэлийн Боловсролын газрын даргын "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын орчны эрсдэлийн үнэлгээ хийх" удирдамж, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/153 дугаар захирамжийн хүрээнд "Сургууль, цэцэрлэгийн орчны гадна талбайн тохижилт, аюулгүй байдал, ашиглалтыг шалгах хуудас"-аар төрийн болон төрийн бус өмчийн 48 сургууль, 117 цэцэрлэгийн гадна орчны эрсдэлийн үнэлгээг 2022 оны 3 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд зохион байгуулж, зөвлөмж өгч ажилласан.



Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/152 дугаар тушаалаар батлагдсан “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавигдах нийтлэг шаардлага”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны А/674 дүгээр захирамжаар хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан.



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 20 өдөр өнжүүлэх төвийн үйл ажиллагаанд 2022 оны 03 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Үйл ажиллагаа явуулж байгаа зарим өдөр өнжүүлэх төвүүдэд нийтлэг шаардлагад заагдсан боловсон хүчин, нэг хүүхдэд ноогдох талбай, харьяа сургуультай хийсэн гэрээ, эрүүл ахуйн шаардлага хангагдаагүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн. Хяналт шалгалтад хамрагдсан өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдэд Хан-Уул дүүргийн Хүүхдийн эрхийн Улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлсэн.



Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад 2 удаагийн сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 11, 18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад давхардсан тоогоор 30 гаруй албан хаагч хамрагдсан.

Нийслэлийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 03 дугаар тогтоолоор жил бүрийн 5 дугаар сарын сүүлийн долоо хоногийн Лхагва гарагийг “Нийслэлийн хүүхдээ сонсох өдөр” болгосон.

Хүүхдээ сонсох өдрийг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, хүүхдэд тулгамдаж буй асуудлыг сурагчдын өөрсдийн оролцоотойгоор сонсох, санал хүсэлтийг нэгтгэн шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилгоор 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан.



Хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус өмчийн 18 сургуулийн ахлах ангийн сурагчдын төлөөлөл 54 сурагч оролцож, өөрт болон анги хамт олонд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, санал хүсэлтээ илэрхийлсэн.

Насанд хүрээгүй гэрч, хохирогч, холбогдогч хүүхдүүдээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед мэдүүлэг авах ажиллагааны явцад хүүхдийн эрх ашгийг ханган ажиллах, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр ажиллаж буй албан хаагч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтад Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газрын I, II хэлтсийн Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Мөрдөн байцаагч нар, Зөрчлийн байцаагч нар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн Хүүхдийн эрхийн Улсын байцаагч, Гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд хамрагдсан.

Монгол Улсын хойч ирээдүй болсон хүүхэд, залуучуудад эх оронч үзэлтэй, хууль ёс заншлаа эрхэмлэн дээдэлдэг, түүх соёлоороо бахархдаг, шударга, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Монгол Улсын Иргэний үнэмлэх гардуулах, иргэний андгай өргөх” ёслолын арга хэмжээг 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд Хан-Уул дүүргийн 16 нас хүрч буй хүүхэд, залуучуудын төлөөлөл 80 залуучууд оролцож, иргэний үнэмлэхээ гардан авсан.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр: Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хороо тус бүр хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг ханган баярын үйл ажиллагааг зохион байгуулсан ба хороодоор дамжуулан бүтэн болон хагас өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот өрхийн нийт 2500 хүүхдэд баярын бэлэг олгосон.

Хариуцсан хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхдээ хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 07/875 дугаар албан бичгээр хороодод хүргүүлсэн.



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан “Монгол хүүхдүүд-2022” Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нэгдсэн арга хэмжээний хүндэтгэлийн парадад тус дүүргийн төрийн болон төрийн бус байгууллага, Хан-Уул дүүргийн Скаутын холбоо, соёлын биет болон биет бус өв тээгч нарын 150 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон.



ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:


Тэмдэглэлт ой, баяр наадмаар худалдаа, үйлчилгээ зохион байгуулсан арга хэмжээ:
Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, дэмжлэг үзүүлэх, борлуулалтыг дэмжих ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Олон улсын хүүхдийг эрхийг хамгаалах өдөр, автомашингүй өдөр зэрэг Нийслэл, дүүргээс зохион байгуулсан соёл урлаг, спорт, олон нийтийн 5 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 76 иргэн, ААНБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан, борлуулалтыг дэмжин ажилласан.

Д/Д	Үзэсгэлэн худалдааны төрөл	Оролцсон байгууллага, иргэн
1	Улаанбаатар марафон 2022	5
2	Д.Сүхбаатарын талбайд "Энх тунх Мөнх тунх" арга хэмжээ	14
3	Төв цэнгэлдэх хүрээлэнд "Хүүхэд таныг хамгаалъя" арга хэмжээ	42
4	Амралтын өдрийн худалдаа	15
Нийт		76

Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд:

"Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн 3 удаагийн хуралдаанаар тамхи худалдах тусгай зөвшөөрөл хүссэн 107 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хэлэлцэж, 79 газарт тамхи худалдах тусгай зөвшөөрлийг дүүргийн Засаг даргын захирамжаар олгож, дүүргийн төсөвт 19.7 сая төгрөг төвлөрүүлсэн.

Дүүргийн Цагдаагийн газар, Эрүүл мэндийн төвтэй хамтран "Архи, тамхины хор уршиг, гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх нь" сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын 9 сургуулийн 978 сурагчдад зохион байгуулж, хорт зуршлын талаар зөвлөгөө өгч ажилласан.



Электрон тамхины хэрэглээний талаар 785 иргэнээс цахимаар санал асуулга авч, асуулгад оролцсон иргэд электрон тамхины талаар хуулийн зохицуулалт шаардлагатай, хэрэглээг бууруулахад чиглэсэн суртал ухуулга хэрэгтэй өсвөр үеийн хүүхэд залуучууд ихээр хэрэглэж байгаа талаар санал ирсэнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын захирамжаар албан байгууллагууд дотоод орчиндоо электрон тамхи хэрэглэхгүй байх, 21 нас хүрээгүй хүнд худалдан борлуулахгүй байхыг зөвлөж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.



Дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн ойр орчмын худалдаа, үйлчилгээний 67 газарт насанд хүрээгүй хүн

электрон тамхи хэрэглэж буй эсэхэд түүвэрчилсэн хяналт хийж, зөвлөгөө мэдээлэл өгч, тамхины хор хөнөөлийн талаар зурагт хуудас байршуулсан.



Худалдаа үйлчилгээний газруудад хууль тогтоомж, стандартыг сурталчлах, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хотын өнгө үзэмж сайжруулах чиглэлээр Хотын стандарт, хяналтын газартай хамтран сургалт зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан худалдаа үйлчилгээний 200 гаруй иргэн, аж ахуйн нэгжид хотын стандарт, худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага, стандартын талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЧИГЛЭЛЭЭР

Цэргийн бүртгэлийн талаар: Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны “Цэргийн бүртгэл явуулах тухай” А/331 дүгээр журмыг удирдлага болгон дүүргийн Засаг даргын 2021 оны А/657 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 21-ний өдрүүдэд цэргийн бүртгэлийн ажлыг цахим болон цаасан суурьтай зохион байгуулсан.

Дүүргийн Засаг даргын захирамжаар цэргийн бүртгэлийн ажлын хэсгийг байгуулж, цэргийн бүртгэлийн бэлтгэлийг хангах 26 ажил бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

Дүүргийн хэмжээнд 4 хороо шинээр байгуулагдсантай холбогдуулан цэргийн бүртгэлийн мэдээллийн санд иргэний хаягийн мэдээллийг шинэчлэн завсарлаж, мэдээллийн аюулгүй байдлыг ханган 21 хороонд суурилуулан, мэргэжил арга зүйн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, бүртгэлийг мэдээллийн сан ашиглан зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан.

Дүүргийн хэмжээнд нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн 16%, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн 75,98%, бэлтгэл офицер 0,68%, тайван цагт цэргийн жинхэнэ албанд тэнцэхгүй 5,26%, орон нутагт ажиллаж байгаа офицер ахлагч 1,48% дүүргийн 2021 оны жилийн эцсийн статистик суурин хүн амын тоотой харьцуулахад 93,8 хувийн хамралттай байсан.

Энэ удаагийн цэргийн бүртгэл нь “Ковид-19” цар тахлын улмаас цаасан суурьтай болон E-Монголиа портал веб сайттай хамтран /цахим/-аар зохион байгуулсан онцлог байлаа. Мөн цэргийн бүртгэлийн хугацаанд ариутгал халдваргүйжүүлэлтийг маш сайн зохион байгуулах, Улсын Онцгой комисс, Засгийн газраас өгсөн зөвлөмж, шийдвэрүүдийг дагаж мөрдөх чиглэлээр 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр, хорооны Засаг дарга, зохион байгуулагч нартай Цэргийн бүртгэлийн зөвлөгөөнийг зохион байгуулж үүрэг чиглэл өгч ажилласан.



Цэргийн бүртгэлийн үйл ажиллагааг E-Монголиа портал веб сайттай хамтран зохион байгуулж, иргэдээс ирсэн цэргийн бүртгэлийн үйлчилгээний хүсэлтүүдийг хүлээн авч хянан шалгаж баталгаажуулж ажилласан.

Цэргийн бүртгэлийн зорилго, ач холбогдол, явцын талаар “МҮОНТ”, “TV-5”, “NTV”, гэсэн телевизүүдэд мэдээлэл өгч, цэргийн бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилсан мэдээ мэдээллийг явуулсан.

Мөн дүүрэг хорооны Фейсбүүк хуудас, байр, СӨХ, хорооны группүүд, Khan-Uul.mn веб сайт, UBM-FM-89.3 радио зэрэг цахим мэдээллийн сувгуудыг ашиглан 2022 оны цэргийн бүртгэлийн онцлог, иргэд хэрхэн цэргийн бүртгэлдээ хамрагдах, шинээр цэргийн бүртгэлд хамрагдах иргэд хэрхэн бүртгүүлэх талаар мэдээ мэдээллийг дэлгэрэнгүй түгээж ажилласан.

Мөн хороонд төрийн болон албаны нууцыг хамгаалах журмыг мөрдүүлэн цэргийн бүртгэлийн мэдээллийн сантай цахим зөвөөрлөгч, бүртгэлийн тэмдэг зэргийг өдөр тутам цоожтой сейф, шүүгээнд хадгалуулах, цэргийн бүртгэл хийгдэж буй компьютерыг интернэт сүлжээнээс салган ашиглах, цэргийн бүртгэлтэй холбоотой мэдээ мэдээлэл агуулсан баримт бичиг хэвлэх зэрэгт онцгой анхаарч, нууцын журмыг мөрдүүлэн ажилласан.

Дүүргийн Засаг даргын 2021 оны А/657 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлыг хэсэг томилогдон ажиллаж иргэний оролцоогүй цаасан суурьтай цэргийн бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 05-наас 21-ний өдрүүдэд **93,8** хувийн хамралттай зохион байгуулсан.

Цэргийн бүртгэлийн тоон үзүүлэлт:

2022 оны цэргийн бүртгэлд хамрагдсан цэргийн үүрэгтний тоо:

- Бэлтгэл офицер –0,68%
- Бэлтгэл ахлагч –0,14%
- 1 дүгээр зэргийн цэргийн үүрэгтэн –16,42%
- 2 дугаар зэргийн цэргийн үүрэгтэн –75,98%
- Орон нутагт байгаа цэргийн жинхэнэ алба хааж байгаа офицер, ахлагч- 1,48%
- Тайван цагт цэргийн жинхэнэ албанд тэнцэхгүй –5,26%
- 19-50 насны цэрэгт бүртгэл бүхий эмэгтэйчүүд –3,84%



2022 ОНД ЦЭРГИЙН БҮРТГЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО 3,5 ХУВИАР БУУРСАН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА.

Д/д	2020	2021	2022
Статистик	-	-	-

Хамрагдсан	-	-	-
Хувь	97.1	97.3	93,8

А. 2022 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын ажил:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/512 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын А/234 дүгээр захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/37 дугаар тушаалаар ажлын төлөвлөгөө, ажиллах 145 албан тушаалтныг томилон баталгаажуулж хэрэгжилтийг ханган ажилласан.


Дүүргийн 21 хорооны Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нартай 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр цэрэг татлагын бэлтгэл болон цэрэг татлагын зохион байгуулалтын ажлын талаар семинар зохион байгуулан, цэрэг татлагаар орох хороодын хуваарь, зарлан дуудах мэдэгдэл тараасан хүний тооцоог танилцуулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас өгсөн тоон даалгаврыг биелүүлэх талаар чиглэл өгч ажилласан.

Цэрэг татлага явуулах байрыг дүүргийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байрыг түшиглэн Цэрэг татлагын товчооны тасгууд болон эрүүл мэндийн үзлэг явуулах байрыг шаардлагатай техник тоног төхөөрөмж, хэвлэлийн материал, эмнэлгийн тоног төхөөрөмж, оношилгооны багаж хэрэгслийг байрлуулан, цэрэг татлагын байрыг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 16:00 цагт нийслэлийн цэрэг татлагын товчооны гишүүн бөгөөд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргад цэрэг татлага байрыг ашиглах дараалал, үйл ажиллагааны чиглэлийг танилцуулан хүлээлгэн өгсөн.

Цэрэг татлагын явцын талаар: Цэрэг татлагын явцад цэрэг татлагын товчоогоор хугацаандаа ороогүй цэргийн үүрэгтнийг бүрэн хамруулах зорилгоор цэрэг татлагын товчооны гишүүд, хэлтэс албадын дарга нарт хороодыг хуваарилан хороодод ажилладаг цагдаагийн хэсгийн байцаагч, хорооны Засаг дарга нартай хамтран ажилласны дүнд **94,1** хувь нь хамрагдаж, **5,9** хувь хамрагдаагүй бөгөөд 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор багтаан шалтгааныг тодруулж дуусгахаар хорооны Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч уг ажлыг эхлүүлээд байна.

Хилийн ба дотоодын цэрэгт цэргийн жинхэнэ алба хаалгахаар нийслэлийн Цэрэг татлагын товчооноос өгсөн тоон даалгавраар бусад цэргийг нөхөн хангах тоон даалгаврыг 100 хувь биелүүлж, цэргийн жинхэнэ албанд татагдагсдын **3** иргэн буюу **5** хувь нь дээд боловсролтой, **7** иргэн буюу **11,6** хувь нь тусгай дунд боловсролтой, **44** иргэн буюу **73,3** хувь нь бүрэн дунд боловсролтой, **6** иргэн буюу **10** хувь нь бүрэн бус дунд боловсролтой байсан.

Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4 дэх заалтыг үндэслэн 18-25 насны цэргийн үүрэгтнүүдээс ар гэрийн гачигдлын шалтгаанаар 62 өргөдөл, санал хүсэлтийг иргэдээс хүлээн авч цэрэг татлагын товчооны эрүүл мэндийн үзлэгээр оруулж 62 иргэний хүсэлтийг Цэргийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийг үндэслэн цэргийн албаны ээлжит татлагаас түр чөлөөлж шийдвэрлэсэн.





Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны ажлын талаар: Цэргийн алба хаах хэлбэрүүдийг сурталчилсан тараах боршуурыг цэргийн гэрээт болон цэргийн дүйцүүлэх алба хаах журам, цэргийн гэрээт плакат, 4х6 хэмжээний цэргийн жинхэнэ албаны хулдаасан хэвлэл, цэргийн дүйцүүлэх алба, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах, цэрэг техникийн бүртгэлийг зохион байгуулах журам, “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг сурталчилсан 2500 гаруй сурталчилгааны баримт бичгийг хэвлүүлэн иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлахад тараан ажилласан.

Цэрэг татлагын бэлтгэл ажил, явцын талаар NTV, TV5, C1-TV телевизүүд, 2022 оны цэрэг татлагын ажлын явцын талаар мэдээлэл өгч Хан-Уул дүүргийн 34 дүгээр сургуулийн гадна 6х8 харьцаатай ЛЕД дэлгэц болон тайзыг байрлуулж, урсдаг самбарт цэргийн албанд тэнцсэн иргэдийн нэрийн жагсаалтыг тухай бүр гаргах ажлыг түргэн шуурхай мэдээлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Иргэдийн даралт үзэж, сахрын шинжилгээ хийж, улаан бурхан бусад халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар яриа танилцуулга хийж гарын авлага тарааж 841 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

Их дээд сургууль, коллежид суралцдаг оюутны материалыг хүлээн авч, цэргийн жинхэнэ алба, цэргийн гэрээт алба, цэргийн дүйцүүлэх алба, цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр, “Оюутан цэрэг”-цэргийн мэргэжил олгох сургалтыг сурталчлах, 2022 оны цэргийн бүртгэлд хамрагдаагүй иргэдийг бүртгэлд хамруулах зэрэг ажил үйлчилгээг – 391 иргэнд үзүүлж 2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар 4 хэлтэс нийт 1766 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

2021 оны 2 дугаар ээлжийн татлагыг 2022 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагатай харьцуулахад цэргийн зарлан дуудах мэдэгдэл эзэндээ хүрсэн 11,2 хувиар, эрүүл мэндийн үзлэгт орсон иргэн 1,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Он	Ээлж	Зарлан тараасан	Эзэндээ хүрсэн	Эзэндээ хүрсэн хувь	Үзлэгт орсон тоо	Үзлэгт орсон хувь
2021	II	-	-	80.8	-	92.1
2022	I	-	-	92.0	-	94.0

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан байдал:

А. Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа байдал:

№		2020	2021	2022
1	Алба хаасан	5	6	10

2	Алба хааж байгаа болон шинээр элссэн	10	6	6
3	Одоогоор 22 иргэн дүйцүүлэх албыг биеэр хааж байна.			

Б. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж байгаа байдал:

№		2022 он
1	Мөнгөн төлбөр тогтоосон	204 иргэн
2	Мөнгөн төлбөр төлсөн	Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 67 иргэний 80,620,335 төгрөг төвлөрүүлсэн.
3	Мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдсөн	39 иргэн

“Оюутан-цэрэг сургалт”-ын талаар: Дүүргийн Засаг даргын 2022 оны “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах тухай А/131 дүгээр захирамж, түүний хавсралтаар үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган батлуулсан. Төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг ханган ажилласан.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/376 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2022 оны А/131 дүгээр захирамжийн дагуу “Оюутан-Цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутны бүртгэлийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 11-ний өдрийг үндэсний портал сайт E-Mongolia бүртгэлийг хүлээн авсан.



Дүүргийн хэмжээнд 2022 онд 9 их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 52 оюутан, суралцагчид бүртгэлд хамрагдсан.

Бүртгэлд хамрагдсан оюутан, суралцагчдаас 47 иргэнийг эрүүл мэндийн үзлэг болон бие бялдрын шалгалтад оруулсан.

Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн байрлалд 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр эрүүл мэндийн үзлэгт, 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр биеийн тамирын шалгалтад оюутнуудыг хамруулсан.

Эрүүл мэндийн үзлэг, бие бялдаржилтын шалгалтад тэнцсэн 42 оюутныг Үндэсний батлан хамгаалахын их сургуульд 2022 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хүлээлгэн өгсөн.

Цэргийн болон дайчилгааны бэлтгэл сургалтыг зохион байгуулж явуулсан ажлын талаар: Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Нийслэлийн Засаг даргаас өгөгдсөн дайчилгааны даалгаврын дагуу Зэвсэгт хүчний ... ангийн ... командад оногдуулан бүртгэгдсэн бэлтгэл офицер, цэргийн үүрэгтнүүдийг 2022 оны цэргийн бүртгэлийн баримт бичигтэй тулгалт хийн шалгахад /шилжсэн, гадаадад, хаягандаа байхгүй, нас барсан гэх мэт/ шалтгаанаар өөрчлөлт орсон бэлтгэл офицер, цэргийн үүрэгтэнг тухай бүр шинээр оногдуулан бүртгэж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны мн/01 дүгээр албан даалгаврыг үндэслэн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны н/01 дүгээр захирамж батлагдсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас улирлын дохиог 1 удаа, Цэргийн штабаас дотоодод тогтоосон зарлан мэдээллийн дохиог 1 удаа дүүргийн дайчилгаа удирдах бүлгийн гишүүд, Цэргийн штабын бие бүрэлдэхүүн, Хан-Уул дүүргийн 21 хороо, дүүргийн цугларах, шилжүүлэх байруудад тус тус өгч ажилласан.

Дайчилгааны зарлан мэдээллийн дохиогоор ажилласан талаар: Дүүргийн бэлэн байдлын дохионы хадгалалт хамгаалалтад сар бүр үзлэг хийн тэмдэглэл хөтөлж, Засаг даргын Тамгын

газрын харуул хамгаалалтын албаны ажилчидтай зарлан мэдээллийн дохиог ашиглах заавар, журмыг танилцуулан үүрэг гүйцэтгэх, сургалт дадлагыг 1 удаа зохион байгуулсан. Нийслэлээс өгсөн зарлан мэдээллийн дохиогоор 1 удаа, дотоодын зарлан мэдээллийн дохиогоор 1 удаа ажиллаж бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх бодит хугацааг тогтоосон.

“Цэргийн үүрэгтний үзлэг шалгалт”-ыг дэвсгэрийн ААН, байгууллагад зохион байгуулж явуулсан ажлын талаар: 2022 оны эхний хагас жилийн байдлаар Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг дүүргийн Засаг даргын баталсан удирдамжаар зохион байгуулан шалгалтад 5 байгууллагын 18-50 насны 465 цэргийн үүрэгтний нэрсийн жагсаалт /4 дүгээр маягтаар/ авч, 75 хувийг хамруулснаас 37.6 хувь нь зөрчилтэй байсан. 1974-1996 онд төрсөн 6 хувьд нь цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоосноос 6,099,511 төгрөгийг нийслэлийн Төрийн санд төвлөрүүлсэн.

Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалт, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар: Төрийн албаны тухай хуулийн дагуу ажилтны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын архивын ажлын төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2022 оны цэргийн бүртгэлийн үеийн мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтыг сахин ажиллах хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

Төрийн болон албаны нууцын тухай хууль, цэргийн бүртгэлийн үеийн мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах чиглэлээр цэргийн бүртгэлийн нэгдсэн семинарыг 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулж, дүүргийн 21 хорооны Засаг дарга, зохион байгуулагч нарт танилцуулга хийн зөвлөмж өгч, төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа /маягт №2/-г бэлтгэж, нууцын баталгаа гаргуулсан.

Дүүргийн 21 хороонд цэргийн бүртгэлийн тэмдэг, хорооны мэдээллийн сангийн нууц мэдээлэл тээгчийг бүртгэлээр хорооны Засаг дарга, зохион байгуулагч нарт хүлээлгэн өгч, мөн бүртгэлийн үед хорооны мэдээллийн сангийн цахим зөөвөрлөгчийг ажилтнууд хүлээлцэх бүртгэлийн дэвтэр, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах зөвлөмж зэргийг бэлтгэн хүлээлгэн өгч, өдөр тутмын зөвлөмжөөр ханган ажилласнаар ямар нэг зөрчил дутагдалгүй зохион байгуулагдсан.

Төрийн болон албаны нууцын тухай хууль, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд: Монгол Улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг судлан албан тушаалтан бүрийн биелүүлэх эрх, үүрэг ажилдаа мөрдөх заавар журмуудыг судлуулан, нууцын баталгаа авах, ажил үүргийн хуваарьт нь тусгах мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллалаа.

Тус дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2021 онд төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн н/15 дугаартай албан бичгээр Тагнуулын ерөнхий газрын Төрийн нууцын хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологи, цахим сан хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт 40 хувьтай байна.

Цэргийн штабын мэдээлэл боловсруулдаг компьютерүүдэд Мэдээллийн технологи, цахим сан хариуцсан мэргэжилтнээр албан ёсны эрхтэй вирусийн программыг суулгуулж бүртгэлийг /маягт №19/ хөтөлсөн.

Цэргийн штабын албаны цахим хаягийн нууц үгийг 2 удаа шинэчлэн цахим хаягийн ажиллагааг хэвийн болгож, албаны мэдээллийг солилцож, багтаамж дүүрсэн тул тэмдэглэл хөтлөн мэдээллийг устгаж ажилласан.

Офицер, ахлагч нарын компьютерын нууц үгийг 2 удаа сольж, нууц үгийн бодлогыг хэрэгжүүлэн ажилласан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын баталсан удирдамжийн дагуу хошууч Б.Чимэд 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр тус дүүргийн Цэргийн штабын төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын байдалд үзлэг явуулж, заавар, зөвлөмжийг өгч ажилласан.

Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, "Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын хэрэгжилтийн хүрээнд: Дайчилгааны нууц бичиг хэргийн өрөө нь "Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 10.1 дэх хэсэг, "Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын 17 дугаар бүлгийн 17.1, 17.2, 17.4, 17.11- /а, б, в, г, д, е/-ийн заалтуудын дагуу биет хамгаалалтын шаардлагад нийцүүлэн төхөөрөмжилж, гал унтраах багаж хэрэгсэл, сейф, цахим мэдээлэл боловсруулах техник хэрэгслээр хангагдсан нь нууц баримт бичиг боловсруулах, хадгалах, олшруулах, төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын шаардлагыг ханган ажилласан.

Дайчилгааны бэлэн байдлын төлөвлөгөө түүнд холбогдох баримт бичиг, Засаг даргын Тамгын газрын төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг боловсруулах ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны А/03 дугаар тушаалаар байгуулж, танилцах эрхийн түвшинг тогтоон дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан, дүүргийн удирдлага, Засаг даргын Тамгын газрын холбогдох ажилтан, хорооны Засаг дарга нар, цугларах, шилжүүлэх байрын томилгоот бүрэлдэхүүнд Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын холбогдох заалт, Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 4 дүгээр бүлгийн 4.3.2, 4.3.4 дэх заалтыг танилцуулан эрх, үүрэг, хориглох зүйлийг танилцуулан зааварчилгаа өгч хүн нэг бүрээр баталгаа гаргуулсан.

Зэвсэгт хүчний Жанжин штабын Мэдээллийн аюулгүй байдлыг хангах албанаас тус Цэргийн штабын төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал, архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд шалган туслах ажил явуулсан 2021 оны н/372 дугаартай актыг ирүүлж, актын дагуу хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг 2022 оны н/22 дугаартай албан бичгээр 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Мэдээллийн аюулгүй байдлыг хангах албанд хүргүүлсэн.

Зэвсэгт хүчний Жанжин штабын 2022 оны н/98 дугаартай албан бичгийн дагуу тус Цэргийн штабт хадгалагдаж байгаа дайчилгааны нууц баримт бичгийг устгахаар нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын мэдээллийн аюулгүй байдлын офицер, хошууч Б.Чимэд заавар зөвлөмжийг өгсний дагуу нууц баримт бичгийг ангилан ялгаж, устгах жагсаалтыг үйлдэн Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дэргэдэх Баримт нягтлан шалгах комисст 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн н/32 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны н/01 дүгээр дугаартай албан бичгээр 2022 онд ажиллах дадлагын дохио батлагдаж, 2021 оны мн/01 дугаартай дадлагын дохиог дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/04 дүгээр тушаалаар нууц баримт бичиг устгахаар томилогдсон ажлын хэсэг нууцын горимын дагуу устгаж, актыг Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабт хүргүүлсэн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/05 дугаар тушаалаар томилогдсон тооллогын ажлын хэсгийн ахлагчид хурандаа Г.Жаргалсайхан, гишүүдэд хошууч Н.Насанбат, ахлах ахлагч М.Төрмандах нарын бүрэлдэхүүнтэй комисс Цэргийн штабын дайчилгааны бичиг хэрэгт хадгалагдаж байгаа дайчилгааны бэлэн байдлын онц чухал-маш нууц, маш нууц, нууц ном, баримт бичгийн 2022 оны эхний хагас жилийн тооллогыг 05 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд явуулж, тооллогын өгүүлбэр, хүснэгт актыг боловсруулан, дайчилгааны нууц баримт бичгийг устгаж, актад тусгаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлэхээр бэлтгэсэн.

Архивын үйл ажиллагааны хүрээнд: Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын 8.1.1, 8.1.2-д заасны дагуу 2022 онд хөтлөгдөх нууц бичиг, хэрэг, данс бүртгэлийн ангиллыг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дэргэдэх БНШК-ын 2022 оны 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн Цэргийн штабын даргаар батлуулж, 2021 оны ангиллыг хааж, нийт ... хавтаст хэргээс дайчилгаатай команд штабын хээрийн сургууль хойшлогдсон учир 1 хавтаст хэрэг хөтлөгдөөгүй, ... хавтаст хэрэг архивт шилжүүлж, 2022 оны ангиллаар ... хавтаст хэрэг хөтөлж байна.

2009-2015 оны байнга болон түр хадгалах нууц, албан хэрэгцээний хадгаламжийн нэгжийг нягтлан шалгаж, бүртгэлийг үйлдэж, 2022 оны н/03 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дэргэдэх БНШК-ын хурлаар хянан хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 2022 оны 03 дугаар хурлаас гарсан шийдвэрийн дагуу Цэргийн штабт хадгалагдаж байсан цэргийн байр зүйн 65 лист зургийг 2022 оны н/33 дугаартай албан бичгээр нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын нууцад шилжүүлж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/04 дүгээр тушаалаар байгуулагдсан нууц баримт бичиг устгах ажлын хэсэг дайчилгааны нууц баримт бичгийг жагсаалтын дагуу хянан хэлэлцэж, устгалыг хийн актыг хүргүүлэхээр боловсруулж байна.

а. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт: Цэргийн штабын 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дэргэдэх БНШК-ын 2022 оны 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн батлуулж, жагсаалтын дагуу албан хэрэгцээний 24 хавтаст хэргийг албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу хөтөлж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хавтаст хэргүүдийг шинэчлэн хаягжуулсан.

б. Баримт бичгийн эрээлт, түүний зохион байгуулалт: 2022 оны эхний хагас жилийн байдлаар компьютерын операторын бүртгэлээр 35 бичиг, ирсэн нууц баримт бичгийн бүртгэлээр ЗХЖШ-ын даргын тушаал, Нийслэлийн Засаг даргын захирамж, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын тушаал, дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалт зохион байгуулах тухай, хугацаат цэргийн албан хаагчдыг ангиудад хуваарилсан бүртгэл, зэрэг 16 баримт бичиг бүртгэн, холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, явсан нууц баримт бичгийн бүртгэлээр цэргийн бүртгэл, цэрэг халалт, татлагын мэдээ судалгаа, илтгэх хуудас, хугацаат мэдээ, зарлан мэдээллийн дохиогоор ажилласан тэмдэглэл, нууц баримт бичиг устгасан тухай акт зэрэг 35 баримт бичиг боловсруулан явуулж, бүртгэж тооцон тараах дансаар 29 баримт бичиг тараагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Батлан хамгаалахын сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаал, албан даалгавар, Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын дарга, Цэргийн штабын даргын тушаал зэрэг нийт 12 захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гарган, гүйцэтгэлийн мэдээг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлсэн.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, байгууллагын архивт баримт хүлээн авах батлагдсан хуваарийн дагуу Цэргийн штабын офицеруудаас 2022 оны 1 дүгээр улиралд 50 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлтийг хийсэн.

в. Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, ашиглалт бүртгэл: Цэргийн штабын тэмдэг, лацны тэмдгийг шилжүүлэхдээ тухай бүр бүртгэлийг хөтлөн ажилласан.

Цэргийн штабын тэмдэг ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 3.12, 3.13-д заасны дагуу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 2022 оны 10/21 дугаартай албан бичгээр тэмдгийг хураалгаж, Зэвсэгт хүчний Жанжин штабын гэрээт “Тамга Урлал” ХХК-иар шинэчлэн хийлгүүлж данс бүртгэлд авсан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу Цэргийн штабын хэвлэмэл хуудсыг холбогдох заавар, дүрэм стандартын дагуу эх загварыг бэлтгэн хүргүүлж, “Мандах Урлан” ХХК-аар А5, А4 тус бүр 300, нийт 600 ширхгийг хэвлүүлэн, нэр төрлөөр нь ангилж хэвлэмэл хуудас хүлээн авсан болон зарцуулалтын бүртгэлийг тухай бүр хөтөлж хэвшсэн.

Иргэдэд батлан хамгаалах төрийн үйлчилгээ үзүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр хийсэн ажил, үйлчилгээ: Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тохиолдуулан хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгын хүрээнд “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” нээлттэй хаалганы өдөрлөгийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Боловсролын хэлтэс, Зэвсэгт хүчний 326 дугаар ангитай хамтран 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн байрлалд зохион байгуулсан. Тус өдөрлөгийн арга хэмжээнд Нийслэлийн Ерөнхий боловсролын 10, 26, 59 дүгээр дунд сургуулиудын ахлах ангийн 140 гаруй багш сурагч нар оролцож хөтөлбөрийн дагуу хугацаат цэргийн албан хаагчдын жагсаалын болон ахлагч нарын гардан тулааны үзүүлэх тоглолтыг үзүүлж, зэвсэг, цэргийн техникийг үзэж сонирхуулсан.



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Ерөнхий боловсролын ахлах болон дунд ангийн сурагчдын дунд “Энхийг сахиулагч-Монгол цэрэг 20 жил” сэдэвт зохион бичлэг, “Миний бахархал-Монгол цэрэг” сэдэвт гар зургийн уралдааныг 2022 оны 2 дугаар сарын 20-ноос 3 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулж, төрийн өмчит болон хувийн хэвшлийн 21 сургууль оролцож, сурагчдын 164 бүтээлийг ирүүлсэн. Зохион бичлэг, гар зургийн уралдаанд сурагчдын ирүүлсэн бүтээлүүдийг Боловсролын хэлтэстэй хамтран дүгнэн шалгаруулж, шилдгээр шалгарсан сурагчдад шагнал гардуулах ёслолын ажиллагааг 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдөр дүүргийн хүндэтгэлийн танхимд зохион байгуулсан.

Зохион бичлэгийн уралдааны Тэргүүн байрт 32 дугаар сургуулийн 11А ангийн сурагч М.Дөлгөөн, Дэд байрт 115 дугаар сургуулийн 126 ангийн сурагч Э.Жаргалсайхан, Гутгаар байрт 60 дугаар сургуулийн 126 ангийн сурагч Э.Баяржавхлан, гар зургийн уралдаанд Гутгаар байрт 52 дугаар сургуулийн 6Г ангийн сурагч С.Мичидмаа, Дэд байрт “Оном” сургуулийн 96 ангийн сурагч Э.Эрмүүн, Тэргүүн байрт 18 дугаар сургуулийн 7А ангийн сурагч Д.Азжаргал нар тус тус шалгарсан.



Тус дүүрэгт оршин суудаг дайнд оролцсон 4 ахмад дайчинд Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медалиар шагнасныг Цэргийн штабын мэдээллийн аюулгүй байдлын офицер хошууч Н.Цэцэгбал, төлөвлөлт, сургалтын офицер, ахмад Э.Бат-Эрдэнэ нар 2022 оны 03 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд гэрт нь очиж гардуулан хүндэтгэл үзүүлсэн.

Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийг ойг тохиолдуулан Цэргийн штабаас чөлөөнд гарсан 5 ахмадад дүүргийн Засаг даргын мэндчилгээ, гарын бэлгийг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр гэрт нь очиж гардуулан, баярын мэндчилгээ



дэвшүүлж хүндэтгэл үзүүлсэн.

Хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгын хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн ахлах ангийн 70 сурагчийг Монгол цэргийн музейтэй танилцуулах, үзмэр үзүүлэх ажлыг 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан.

Тус дүүргээс 2021 оны хоёрдугаар ээлжээр татагдан Зэвсэгт хүчний 327 дугаар ангид алба хааж байгаа 18 дайчны ар гэрийнхэнтэй нь цахимаар уулзуулах ажлыг 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын “Б” танхимд зохион байгуулсан.

Тус уулзалтаар алба хааж байгаа дайчид ар гэрийнхэнтэйгээ халуун дотно яриа өрнүүлж, цэргийн албанд шамдан боловсорч байгаагаа дуулган, ая дуугаар бэлэг барьсан.



Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны 8/4872 тоот албан даалгаврын дагуу Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний 150 дугаар анги, Боловсролын хэлтэс хамтран нийслэлийн Ерөнхий боловсролын 118, 60 дугаар сургуулийн ахлах ангийн нийт 200 гаруй сурагчдад “Монгол цэрэг дэлхийн цэрэг” сэдэвт Зэвсэгт хүчнийг сурталчлах өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан.



Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жил, Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны 20 жилийн ойг тохиолдуулан дүүргийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын цогцолбор “Дөл” тэмцээнийг 2022 оны 4 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 326 дугаар ангитай хамтран зохион байгуулсан.

Тэмцээний нээлтийн ажиллагаанд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орлогч, хурандаа Б.Эрдэнэпил, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Г.Жаргалсайхан, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Ж.Отгонхорлоо, нар оролцсон.

Тэмцээнд дүүргийн Ерөнхий боловсролын 7-р сургуулийн “ХУРД”, 10-р сургуулийн “АРАВТ”, 15-р сургуулийн “ЗЭВ”, 18-р сургуулийн “СОЁМБО”, 26-р сургуулийн “СҮЛД”, 32-р сургуулийн “ОФИЦЕРУУД”, 34-р сургуулийн “ХАНГАРЬД”, 41-р сургуулийн “ЭРЧ ХҮЧ”, 52-р сургуулийн “ТЭМҮҮЛЭЛ”, 59-р сургуулийн “СҮЛД”, 60-р сургуулийн “ЦЭГЦ”, 75-р сургуулийн “АРАВТ”, 114-р сургуулийн “ОРГИЛ”, 115-р сургуулийн “СОНОР”, 118-р сургуулийн “БАРС”, 130-р сургуулийн “ДУУЛГА” багууд, нийт 16 сургуулийн 208 сурагчид 14 төрлөөр өрсөлдөж Тэргүүн байрыг 7 дугаар сургуулийн “Хурд” баг, дэд байрт 10 дугаар сургуулийн “АРАВТ” баг, Гутгаар байрт 60 дугаар сургуулийн “ЦЭГЦ” баг тус тус шалгарсан.

Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас “Жагсаалч хүү, охин”-ыг шалгаруулан “Шилдэг жагсаалч хүү”-гээр ерөнхий боловсролын 26 дугаар сургуулийн “Сүлд” багийн тасгийн захирагч Т.Ганбаяр, “Шилдэг жагсаалч охин”-оор 15 дугаар сургуулийн “Зэв” багийн гишүүн У.Мөнхчимэг, “Шилдэг гранат шидэгч”-ээр 41 дүгээр сургуулийн “Эрч хүч” багийн гишүүн А.Золбоо, 75 дугаар сургуулийн “Аравт” багийн гишүүн Э.Баярмаа нар тус тус шалгарч шагналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Г.Ялалт гардуулж, баяр хүргэсэн.

2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Зайсан толгойн зөвлөлтийн дайчдын хөшөөнд



Ялалтын баярын цэцэг өргөх арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Хотын болон дүүргийн тохижилт үйлчилгээний төв, Замын цагдаагийн тасаг болон Цагдаагийн нэгдүгээр хэлтэстэй хамтран Танкийн хөшөөний орчмын талбайн цэвэрлэгээ, усалгаа, замын зохицуулалтын ажлыг зохион байгуулсан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нь Батлан хамгаалахын сайдын нийслэлийн Засаг даргын байгуулсан гэрээ, хамтран ажиллах санамж бичиг, Нийслэлийн цэргийн штабаас 2022 онд дэвшүүлсэн **“Батлан хамгаалах хууль тогтоомж-Бэлэн байдлын бэлтгэлжилт”** зорилтын хүрээнд эхний хагас жилийн байдлаар 58.5 хувь хэрэгжүүлж ажиллалаа.

3.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

Тайлант хугацаанд хүний нөөцийн чиглэлээр Хан-Уул дүүргийн Засаг даргын 39 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 80 тушаалын төслийг боловсруулан батлуулсан байна.

Засаг дарга болон хорооны албан хаагчдын цалингийн нэгдсэн судалгааг гаргаж, судалгаанд үндэслэн ЗДТГ-ын даргын Б/28 дугаар тушаалаар Тамгын газрын нийт 28 албан хаагчийн цалингийн шатлалыг, 5 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоосон бөгөөд хорооны 23 албан хаагчийн цалингийн шатлалыг, 6 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тус тус шинэчлэн тогтоож олгосон.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын албан хаагчдын төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг боловсруулан Засаг даргын Тамгын газрын даргын 2022.02.21-ний өдрийн 04/226 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2022.05.12-ны өдрийн А/641 дүгээр захирамжаар нийт 31 төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгосон. Үүнээс Засаг даргын Тамгын газар болон хорооны 10, дэргэдэх хэлтэс, албаны 4 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон бөгөөд Засаг даргын Тамгын газар болон хорооны нийт 17 албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр олгосон.

Монгол Улсын Засгийн газраас төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны Б/78 дугаар тушаалаар Тамгын газрын төрийн захиргааны 44, хорооны 52 албан хаагчийн ангилал, зэрэглэлийг, төрийн үйлчилгээний 11 албан хаагчийн цалингийн хэмжээг тус тус шинэчлэн батлуулж, Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо” системд бүртгэлийг шинэчилсэн.

Тайлант хугацаанд ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшил, тогтвор суурьшилтай ажилласан байдал, амьдралын нөхцөлийг харгалзан 18 албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад

дэмжлэг үзүүлсэн. Засаг даргын Тамгын газрын дотоод журмын дагуу 17 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон бөгөөд Засаг даргын Тамгын газраас өндөр насны тэтгэвэрт гарсан 67 ахмад настанд 2022 оны “Сар шинийн баяр”-ыг тохиолдуулан нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлсэн.

3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна

Тайлант хугацаанд иргэдээс дүүргийн Засаг даргын харьяа, дэргэдэх хэлтэс, албан хаагчдад хандаж нийт 1837 өргөдөл, гомдол ирснээс 1710 буюу 92,85% хугацаандаа шийдвэрлэгдэж, 15 буюу 0,83% хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн, 107 буюу 6,32% судлагдаж байна.

Засаг даргын Тамгын газарт 376 өргөдөл, гомдол ирснээс 359 буюу 95,4% хугацаандаа шийдвэрлэгдэж, 17 буюу 4,6% судлагдаж байна.

ИРГЭДИЙН ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ТӨРЛӨӨР АНГИЛЖ ҮЗВЭЛ:



Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариу өгсөн хэлбэрийг авч үзвэл:



Иргэний талд шийдвэрлэж хариу өгсөн /дүүрэг/ 1239 буюу 73,3%, /ЗДТГ/ 252 буюу 71,4%, боломжгүй тухай хариу өгч шийдвэрлэсэн /дүүрэг/ 336 буюу 20%, /ЗДТГ/ 44 буюу 12,5 %, бүрэн барагдуулж шийдвэрлээгүй /зөвхөн холбогдох тайлбар, мэдээлэл өгч хаасан/ /дүүрэг/114 буюу 6,7%, /ЗДТГ/57 буюу 16,1%

Хан-Уул дүүрэг	Нийт өргөдөл		Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Шийдвэрлэлтийн дундаж хонот		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	2021 VI/12	2022 VI/12	2021 VI/12	2022 VI/12	2021 VI/12	2022 VI/12	2021 VI/12	2022 VI/12	2021 VI/12	2022 VI/12
ИТХ	18	2	18	2	0	0	09x07ц 05м	02x01ц 03м	15	0

ЗДТГ	353	376	324	359	4	0	07x04ц 10м	05x16ц 21м	182	15
Харьяа хэлтэс, алба, тасаг	678	1202	629	1105	2	12	07x07ц 29м	07x02ц 40м	200	276
Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	2	26	2	26	0	0	15x09ц 47м	04x17ц 06м	2	44
Хороод	44	75	40	65	0	3	02x17ц 48м	08x19ц 17м	30	155
Эмнэлэг	66	142	57	140	1	0	08x01ц 46м	06x12ц 43м	56	74
Сургууль, цэцэрлэг	14	14	14	14	0	0	02x14ц 44м	00x14ц 35м	3	0
Дүүргийн хэмжээнд /нийт/	1175	1837	1084	1711	7	15	07x03ц 08м	06x17ц 43м	488	564

Хугацаа хэтэрсэн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД ГАРГАСАН ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛ, БАЙГУУЛЛАГААР:

Зөрчлийн төрөл	Зөрчлийн тоо	Байгууллагаар	Зөрчлийн тоо
Бусад зөрчил	0	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0
Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	66	Засаг даргын Тамгын газар	15
Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	102	Харьяа хэлтэс, алба, тасаг	276
Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	374	Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	66
Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	21	Хороод	155
Холбогдох файл хавсаргаагүй	1	Эмнэлэг	74
НИЙТ	564	Сургууль, цэцэрлэг	0
		Дүүргийн хэмжээнд/нийт/	564

Зөрчлийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НЭГЖҮҮД	ШИЙДВЭРЛЭСЭН						ШИЙДВЭРЛЭЛТИЙН дундаж хугацаа		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	Хугацаандаа шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Бүгд		2021 VI/12	2022 VI/12	2021 VI/12	2022 VI/12
	2021 VI/12	2022 VI/12	2021 VI/12	2022 VI/12	2021 VI/12	2022 VI/12				
Удирдлага	1	0	0	0	2	0	11x02ц19м	00x00ц00м	86	1
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	54	64	0	0	56	67	04x19ц09м	03x12ц09м	12	2
Санхүү, төрийн сангийн хэлтэс	1	2	0	0	1	2	00x00ц00м	03x22ц16м	0	0
Нийгмийн хөгжлийн хэлтэс	7	29	0	0	9	29	04x17ц14м	04x17ц07м	4	3
Төлөвлөлт гүйцэтгэл, мониторингийн хэлтэс	24	39	0	0	25	40	06x06ц22м	05x21ц17м	5	1
Тохижилт, ногоон байгууламжийн гүйцэтгэл, хяналтын хэлтэс	0	46	0	0	0	50	00x00ц00м	08x07ц07м	0	3
Хог, орчны бохирдол, зохицуулалтын хэлтэс	118	81	3	0	133	85	11x21ц59м	08x10ц10м	56	5
Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	99	21	1	0	102	26	02x19ц50м	10x07ц36м	6	1
Цэргийн штаб	0	55	0	0	0	55	00x00ц00м	00x04ц54м	0	0
Хууль, эрх зүй, архивын хэлтэс	9	20	0	0	9	20	05x18ц40м	06x01ц20м	1	0
Аж, ахуй, өмчийн тасаг	1	0	0	0	1	0	18x21ц36м	00x00ц00м	4	0
Олон нийттэй харилцах алба	4	1	0	0	4	1	11x22ц34м	17x01ц41м	4	0
НИЙТ ДҮН	317	359	4	0	346	376	07x03ц35м	05x16ц21м	178	15

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ИНДЕКС	0.848
---------------------------------------	-------

ХАМГИЙН ИХ ГОМДОЛ ИРСЭН ХЭЛТЭС	ГОМДЛЫН ТЭРГҮҮЛЭХ АГУУЛГА
1. Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтэс – 63 буюу 40,6 %	1. Нийтийн эзэмшлийн болон зам талбайн эвдрэл гэмтэл, тохижилтын асуудлаар – 41 буюу 26,5%
2. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс – 26 буюу 16,8 %	2. СӨХ-ын үйл ажиллагаа, төлбөр хураамжийн асуудлаар – 26 буюу 16,8 %
3. Тохижилт, ногоон байгууламжийн гүйцэтгэл, хяналтын хэлтэс – 25 буюу 16,1 %	3. Хог цэвэрлэгээ, тээвэрлэлт, орчны бохирдлын асуудлаар – 24 буюу 15,5 %
4. Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс – 16 буюу 10,3%	4. Дүүрэг болон хороодын үйл ажиллагаа, албан хаагчдын ёс зүйн асуудлаар – 23 буюу 14,8 %
5. Төлөвлөлт, гүйцэтгэл, мониторингийн хэлтэс – 15 буюу 9,7%	

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр: Иргэдээс дүүргийн Засаг даргын харьяа, дэргэдэх хэлтэс, албан хаагчдад гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг бэлтгэн Засаг даргын болон Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд тус тус танилцуулсан.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх 5 арга хэмжээтэй төлөвлөгөөг боловсруулан 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан. Уг төлөвлөгөөний хэрэгжилт болон гомдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын мэдээг холбогдох хэлтэс албадаас авч улирал тутмын тайланд нэгтгэн нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд албан бичгээр хүргүүлж ажиллаж байна.

Мөн өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн болон шийдвэрлэх явцад зөрчил их гаргасан Засаг даргын харьяа, дэргэдэх 12 хэлтэс албад руу 2 удаагийн зөвлөмжийг албан бичгээр хүргүүлсэн. Сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтсүүдийн иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн дүүргийн Статистикийн хэлтсээс эрхлэн гаргадаг “Статистикийн мэдээлэл” гарын авлагад нийтлүүлж байна.

Засаг дарга иргэдэд мөнгөн тусламж үзүүлсэн талаар: “Дүүргийн Засаг даргаас иргэдэд үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай журам”-ыг хангуулан ажиллаж байгаа бөгөөд журамд заасны дагуу хороодын нийгмийн ажилтнаар мөнгөн тусламж хүссэн иргэдийн гэрт очиж нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар нийт 28 иргэнд 9,800,000 /есөн сая найман зуун мянган төгрөг/ нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон байна. Үүнд: А/264 дугаар захирамжаар нийт 23 иргэнд 7,900,000 төгрөг, А/331 дүгээр захирамжаар нийт 5 иргэнд 1,900,000 төгрөг тус тус шийдвэрлэн, олгож ажилласан байна.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл:

Хөрсний бохирдлыг бууруулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хан-Уул дүүргийн 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21 дүгээр хороодын гэр хорооллын айл өрхүүдийн нийт 10924 нүхэн жорлон, 5575 бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлэх ажил гүйцэтгэгчийг дүүргийн Худалдан авах ажиллагааны албаар дамжуулан сонгон шалгаруулахаар нээлттэй тендер зарласан.


Хүснэгт 1. Ариутгалын ажлын даалгавар:

1	Ажлын нэр	Хан-Уул дүүргийн гэр хорооллын нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлэх ажил
---	-----------	---

2	Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
3	Захиалагч байгууллага	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
4	Гүйцэтгэгч байгууллага	- Нийслэлийн эрүүл мэндийн газраас олгодог "Ахуйн хортон шавж, мэрэгч устгал ариутгал, халдваргүйтгэл" тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага; - Байгууллага нь эрүүл ахуйч /тархвар судлагч их эмч/-ийн удирдлагад биологич, химич /хор судлагч/, мэргэшсэн ариутгагч зэрэг бүрэлдэхүүнтэй байна; - Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан, тэдгээр нь аюулгүй ажиллагааны болон техник ашиглалтын шаардлагыг бүрэн хангасан байна. <u>Тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл:</u> - Хамгаалалтын хувцас хэрэгсэл (нэг удаагийн малгай, шүүлтүүртэй амны хаалт, нүүрний хаалт, бээлий, ханцуйвч, комбинезон, ус нэвтрэхгүй түрийтэй гутал гэх мэт); - Автоматс (мананцар үүсгэгч) - Уусмал найруулах сав, хэмжээст сав - Хэмжээст сав - Туузан тест /найруулсан уусмалыг шалгах/
5	Ариутгал халдваргүйжүүлэлт хийх үе шат	Нүхэн жорлон, бохирын цооногт ариутгал халдваргүйжүүлэлт хийхдээ: - Нүхэн жорлонд үнэр дарах, ариутгаж халдваргүйжүүлэх үйлчилгээтэй бэлдмэл хийх /уусмалаар/; - Нүхэн жорлон, бохирын цооногийн орчмын /3-4 м ² талбай/ хөрсөнд ариутгал халдваргүйжүүлэлт хийх; - Жорлонгийн гадаргууд бүх төрлийн шавжийн авгалдай, нян устгах зэрэг ажлыг нэг удаагийн үе шаттай хийж гүйцэтгэнэ. Анхаарах: Ариутгал халдваргүйжүүлэлт хийхээс өмнө болон дараа нүхэн жорлон, бохирын цооног орчмын хөрснөөс дээж авч бохирдлын хэмжээг итгэмжлэгдсэн мэргэжлийн лабораториор тодорхойлуулна. Хөрсний дээж авахдаа дүүргийн Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтсийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хорооны Засаг дарга нарыг газар дээр нь байлцуулж, акт үйлдэж, хөрсийг битүүмжилж лацдан мэргэжлийн лабораторид хүргүүлнэ. Лабораторийн шинжилгээтэй холбоотой гарах зардлыг гүйцэтгэгч хариуцна.
6	Ариутгал халдваргүйжүүлэх бодис	- Ариутгал халдваргүйжүүлэлт хийх бодис, бэлдмэл нь Монгол улсад хэрэглэхийг зөвшөөрсөн мэргэжлийн байгууллагын дүгнэлт, зөвшөөрөлтэй байх ба төндөрийн баримт бичигт хавсаргаж ирүүлнэ.
7	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцно.
8	Ариутгал халдваргүйжүүлэлт хийхэд мөрдөх дүрэм, журам, стандарт	- "Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ" MNS 5161-3:2002 стандарт - Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалын долоодугаар хавсралтаар батлагдсан "Ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм" - Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/227 дугаар тушаалаар батлагдсан "Коронвируст халдвар /COVID-19/-ын үед халдваргүйжүүлэлт хийх түр заавар" - Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/15 дугаар тушаалаар батлагдсан "Коронвируст халдвар /COVID-19/-ын үед халдваргүйжүүлэлт хийх түр заавар"

Монгол Улсын Засгийн газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах зорилтын хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим вэб www.khanuul.mn сайтыг бүрэн шинэчлэн төрийн үйлчилгээг иргэд хүндрэл чирэгдэлгүй шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэн зарим нэр төрлийн үйлчилгээг цахимжуулсан.

www.khanuul.mn, Хан-Уул Эко дүүрэг, Хан-Уул дүүргийн иргэдийн бүлэг, Товч мэдээ- Хан-Уул дүүрэг зэрэг цахим хуудаснуудад 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1605 мэдээ, нийтлэл, ярилцлага, сурвалжлага, лайв, тодруулга, зөвлөмж, зөвлөгөөг байршуулсан. Мөн “Цахим Хан-Уул” буланг шинээр нээж, чатбот үйлчилгээг нэвтрүүлэн тогтмол хяналт тавин ажиллаж байна. Мөн цаг үеийн холбогдолтой нөлөөллийн видео буюу сэтгэл зүйчийн зөвлөгөө, дохионы видеоны мэдээллийг олны танил хүмүүсээр дамжуулан сурталчилсан. www.khanuul.mn цахим сайтыг Facebook, Youtube, Chatbot- зэрэгтэй шууд холбогдож ажиллах технологийн боломж бүрдүүлсэн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1981 мэдээ, нийтлэл, ярилцлага, сурвалжлага, лайв, тодруулга, зөвлөмж, зөвлөгөөг оруулж, иргэдээс ирсэн асуултад цаг алдалгүй 24 цагаар хариулт өгч байна.



Дүүрэгт хийгдсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын 109 мэдээлэл, нөлөөллийн 298 постор бэлтгэн гаргасан:



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх ажлын тайланг бэлтгэн НИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн.



ЦАХИМ ХАН-УУЛ ДҮҮРЭГ – АНГЛИ ТАНИЛЦУУЛГАТАЙ ШИНЭ ВЕБ САЙТ

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны www.khanuul.mn цахим сайтыг бүрэн шинэчлэх ажлыг гүйцэтгэж, загварыг өөрчлөн, мэдээлэл авахад илүү цэгцтэй, хялбар болгосон. Мөн үндсэн www.khanuul.mn сайтаар дамжуулан www.visit-khanuul.mn дэргэдэх шинэ англи танилцуулгатай веб сайттай болсон.



Цахим сан, цахим хөгжүүлэлтийн чиглэлээр:

Хан-Уул Эко дүүрэг” цахим хуудсаар дамжуулан иргэдийг хэрэгцээтэй цаг үеийн мэдээллээр тогтмол ханган ажиллаж байгаа бөгөөд 2022 оны эхний хагас жилийн байдлаар тус хуудсанд 2985 мэдээлэл орж, давхардсан тоогоор **487,558 иргэн** удаа page хуудас руу хандсан байна. Иргэдээс комментоор **2637**, чатаар **2,715** асуулт ирснийг холбогдох албан тушаалтанд танилцуулан хариу мэдэгдсэн.

Тус хуудсанд Хан-Уул дүүргийн Онцгой комиссоос КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал, зөвлөгөө зөвлөмж, шинжилгээ авах, вакцинжуулалттай холбоотой мэдээллийг иргэдэд цаг алдалгүй нийтэлсэн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар **781** мэдээлэл орж, **135,800** иргэний хандалттай байна.



Хан-Уул дүүргийн иргэд бүлгэм цахим хуудас 2022 оны эхний хагас жилийн байдлаар **27,000 гаруй** гишүүнтэй болсон бөгөөд дунджаар **450,000+** удаа иргэд хандаж, мэдээлэл авсан байна.



Хан-Уул Дүүргийн иргэд

Public group · 27.0K members


About Discussion Topics Events Media Files People

Joined + Invite

Search icon and menu icon

“Нээлттэй Хан-Уул цахим хуудас”

Хан-Уул дүүргийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг цаг алдалгүй иргэдэд шуурхай хүргэх зорилгоор “Нээлттэй Хан-Уул” цахим хуудсыг нээж, 2020-2024 оны хөрөнгө оруулалтын мэдээллийг тогтмол оруулж хэвшлээ. www.khanuul.mn цахим сайтад 2022 оны эхний хагас жилийн байдлаар 65 хөрөнгө оруулалттай холбоотой мэдээлэл оруулж, 305,978 иргэнд хүрсэн байна.



ТАВДУГААР БҮЛЭГ

5.1 Холбогдох чиг үүргийн дагуу нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл:

Хан-Уул дүүргийн 21 хорооны ажилтан, албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүй, дотоод ажлын эмх цэгц, мэргэшлийн ур чадварт ахиц гаргах зорилгоор Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн дүүргийн 21 хороодод зөвлөн туслах ажлыг Тамгын газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр баталсан удирдамжийн дагуу зохион байгуулж байна.

2022 оны 06 дугаар сарын байдлаар Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүй, архивын хэлтэс, Аж ахуй, өмчийн хэлтсийн албан хаагч хороодод ажиллан өөрсдийн чиг үүргийн хүрээнд зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажилласан. Дээрх ажил бүтэн жилийн хугацаанд үргэлжлэн хийгдэх бөгөөд ЗДТГ-ын хэлтэс, албад хуваарийн дагуу ажиллана.



Зөвлөн туслах ажлыг зохион байгуулснаар хорооны өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, төрийн албаны стандартын хэрэгжилт хангагдан, иргэдэд үзүүлэх төрийн анхан шатны үйлчилгээ сайжирч, иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ. Хүний нөөц, ёс зүйтэй холбоотой дараах мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Үүнд;

- Батлагдсан албан тушаалын тодорхойлолтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг боловсруулах,
- Албан хаагчдын цалингийн шатлал, нэмэгдлийг танилцуулах,
- Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтын журам болон мэргэжил таарахгүйн улмаас шаардлага хангахгүй байгаа албан хаагчдад зөвлөх,
- Тусгай шалгалтын шаардлага хангаж байгаа албан хаагчдыг тусгай шалгалтын захиалгад оруулах,
- Засаг даргын Тамгын газарт мөрдөгдөж буй дүрэм, журамтай танилцах, хэрэгжүүлэх байдалд хяналт тавих,

Нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааны талаар: “Нэг цэгийн үйлчилгээ”-ний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг ханган 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 180,360 иргэн үйлчлүүлсэн байна. “

Тус төвөөр өдөрт 400-500 иргэн тогтмол үйлчилгээ авдаг бөгөөд Өргөдөл гомдол хүлээн авах, Эд хөрөнгийн бүртгэл, гэрчилгээ олгох, Гадаад паспорт хүлээн авах, олгох, Газар зохион байгуулалтын алба, Хуулийн этгээдийн бүртгэл, гэрчилгээ олгох, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Иргэний бүртгэл, олголт, Нотариат, Кадастр, Канон/Зурагчин/ зэрэг 15 цонхоор 69 төрлийн үйлчилгээ хүргэдэг.

Үүнээс гадна иргэдэд зориулан ТҮЦ машин, улсын бүртгэлийн хураамж, газар зохион байгуулалтын албаны хураамж, татвар, торгууль, шүүхийн тэмдэгтийн хураамж, вакцины бичиг, шинжилгээний хариу гэх мэт үйлчилгээг хялбар, шуурхай шийдэх боломжтой ГЭРЭГЭ киоск автомат машин ажиллаж байна.

Нийт үйлчлүүлсэн иргэдийн тоо 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар /давхардсан тоогоор/

№	Үйлчилгээний төрөл	2022 оны 06 дугаар сар/өссөн дүнгээр/
1	Газар зохион байгуулалтын алба	20357.00
2	Эд хөрөнгийн эрхийн бүртгэл	29163.00
3	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	607.00
4	Хуулийн этгээдийн бүртгэл	8041.00
5	Иргэний бүртгэл	12365.00
6	Гадаад паспорт	10449.00
7	Нотариат	24356.00
8	Канон, түргэн зурагчин	30837.00
9	Газрын кадастр	10201.00
	Нийт дүн	146376.00

Дүүргийн лавлагаа, мэдээллийн 77771965 тусгай дугаарын дуудлагын мэдээ: Дүүргийн хэмжээнд 2022 оны 06 дугаар сарын байдлаар 8512 үүнээс Засаг даргын Тамгын газарт 3434 дуудлага ирснийг холбогдох хэлтэс албад руу шилжүүлж, мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан байна.

Иргэдээс ирсэн дуудлага:



5.2 Хөрөнгө санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл, болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх мэдээлэл:

Хүндрэлтэй асуудлууд:

1. Хэлтсүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, цаг үеийн асуудлаар зохион байгуулах шаардлага гарч буй арга хэмжээнүүд тухайн жилийн батлагдсан төсөвт тусгагдаагүй байдаг тул шийдвэрлэхэд хүндрэлтэй, цаг хугацаа тулсан байдаг.

2. Дээд газруудаас ирж байгаа олон нийтийг хамарсан болон бусад цаг үеийн шинжтэй ажил зохион байгуулах, биелэлт, судалгаа, мэдээлэл авах тухай албан бичгүүдийн хугацаа тулж ирүүлдэг.

Цаашид анхаарах асуудлууд:

1. Зохион байгуулж буй үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлын талаар иргэдээс тухай бүр санал асуулга авч, түүний мөрөөр дүн шинжилгээ хийж ажлаа төлөвлөх.

2. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, алба, хороодын албан хаагчид, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх.

3. Төлөвлөсөн ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэл сайтай хийж гүйцэтгэх, үр дүнг тооцож ажиллах.

4. Зохион байгуулах үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилж, олон нийтэд ил тод мэдээлж байх.

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

С.ЭНХБАЯР

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ХҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.САРАНГУА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ч.АРИУНЖАРГАЛ